

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ**ГЭМТ ЭТГЭЭДИЙГ БАРИВЧЛАХ, ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖТЭЙ ҮЙЛДЛИЙГ
ТАСЛАН ЗОГСООХ ХЭР ХЭМЖЭЭ ХЭТРҮҮЛСЭН ҮЕД
ХҮЛЭЭЛГЭХ ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА****Л.Бат-Очир**

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн
эрх зүй, криминологийн тэнхимийн ахлах багш,
цагдаагийн хошууч, докторант

Эрүүгийн хариуцлага нь Эрүүгийн эрх зүйн харилцаа үүссэнтэй холбоотой үүсдэг бөгөөд уг харилцааг зохицуулах тодорхой шатуудад хэрэгждэг учраас эрүүгийн эрх зүйн харилцаатай нягт холбоотой авч үзэх шаардлагатай. Эрүүгийн хариуцлагын энэ онцлогийн талаар зарим судлаачид “Гэмт хэрэгтэн болон гэмт явдалтай тэмцэх байгууллага хоёрын хооронд үүссэн эрүүгийн ба эрүүгийн байцаан шийтгэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцааны нийлбэр цогц юм”¹ гэж үздэг. Мөн Доктор, профессор Г.Совд: “Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг засан хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэх, түүнийг дахин шинээр гэмт хэрэг үйлдэхээс болон бусад иргэдийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх эцсийн дүнд гэмт хэргийг бүхэлд нь арилгах зорилготой нийгмийн бодит хэрэгцээгээр нөхцөлдөн гарсан эрх зүйн хэм хэмжээ юм. Энэ хэм хэмжээний үндсэн агуулга нь гэмт этгээдийг журамд нийцүүлэн төрөөс зэмлэн буруушааж, албадан хүлээлгэж байгаа үүрэг бөгөөд хэрэв эрүүгийн хуульд заасан ял оногдуулж байгаа бол уг этгээдийн хувийн болон эд хөрөнгийн эрхэнд хязгаарлалт тогтоож байгаад оршино”² гэж дэлгэрэнгүй тодорхойлжээ.

Эрүүгийн хуульд хийсэн судалгаанаас үзэхэд гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох хэр хэмжээ хэтрүүлсний улмаас Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан дараах 43 гэмт хэрэг үйлдэгдэж болохоор байна.

Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох хэр хэмжээ хэтрүүлсэн үед үйлдэгдэж болох гэмт хэргүүд

д/д	Бүлэг	Бүлгийн нэр	Зүйл	Гэмт хэрэг	Гэмт хэргийн ангилал
1	10 дугаар бүлэг	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	10.1	Хүнийг алах	1.Хүнд 2.Хүнд
2			10.2	Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүнийг алах	1.Хөнгөн
3			10.3	Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй	1.Хүнд

¹Стручков.Н.А.Уголовная ответственность и ее реализация в борьбе с преступностью.Саратов.,1977.стр 14-50.

²Совд.Г.М.БНМАУ-ын эрүүгийн эрхийн курс.Ерөнхий анги.УБ.,1973.372 дугаар тал.

				үйлдлийг таслан зогсооххэр хэмжээг хэтрүүлж хүнийг алах	
4			10.6	Хүний амь насыг болгоомжгүйгээр хохиоох	1.Хөнгөн 2.Хүнд
5			11.1	Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	1.Хүнд 2.Хүнд
6			11.2	Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах	1.Хөнгөн
7			11.3	Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах	1.Хөнгөн 2.Хөнгөн
8			11.4	Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах	1.Хөнгөн 2.Хөнгөн
9			11.5	Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах	1.Хөнгөн 2.Хөнгөн
10			11.6	Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах	1.Хөнгөн 2.Хөнгөн
11	11 дүгээр бүлэг	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	13.3	Хүн барьцаалах	1.Хүнд 2.Хүнд
12			13.4	Хүнийг хүчээр алга болгох	1.Хөнгөн 2.Хөнгөн 3.Хүнд 4.Хүнд
13			13.5	Заналхийлэх	1.Хөнгөн 2.Хөнгөн 3.Хөнгөн
14			13.6	Бусдын орон байранд хууль бусаар нэвтрэн орох	1.Хөнгөн 2.Хөнгөн
15			13.7	Хууль бусаар нэгжих, хураан авах, битуумжлэх	1.Хөнгөн 2.Хөнгөн
16			13.9	Хууль бусаар гэмт этгээдийг баривчлах , саатуулах	1.Хөнгөн 2.Хөнгөн

17			13.10	Хувь хүний нууцад халдах	1.Хөнгөн 2.Хөнгөн
18			13.11	Хувь хүний нууцыг задруулах	1.Хөнгөн 2.Хөнгөн
19			13.12	Хууль бусаар мөрдөж мөшгих	1.Хөнгөн 2.Хөнгөн
20			14.2	Мэдээлэл хайх, хүлээн авахад саад учруулах	1.Хөнгөн
21			14.3	Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах	1.Хөнгөн
22			14.4	Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хэрэгжүүлэхэд саад учруулах	1.Хөнгөн
23			14.5	Иргэн сонгуулийн эрхээ эдлэх, сонгуулийн хорооны ажилд саад хийх	1.Хөнгөн 2.Хөнгөн
24	15 дугаар бүлэг	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	15.2	Аюултай байдалд орхих, тусламж үзүүлэхгүй байх	1.Хөнгөн 2.Хөнгөн
25	16 дугаар бүлэг	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	16.7	Хүүхэдтэй хэрцгий харьцах	1.Хөнгөн 2.Хөнгөн
26	17 дугаар бүлэг	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	17.7	Автотээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүйгээр авч явах	1.Хөнгөн
27			17.8	Эд хөрөнгө устгах, гэмтээх	1.Хөнгөн 2.Хөнгөн 3.Хүнд
28			17.11	Болгоомжгүйгээр эд хөрөнгө устгах, гэмтээх, үрэгдүүлэх	1.Хөнгөн 2.Хөнгөн
29	20 дугаар бүлэг	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	20.6	Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хамгаалахад хайнга хандах	1.Хөнгөн 2.Хүнд
30			20.15	Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих	1.Хөнгөн 2.Хөнгөн

				хамгаалалтгүй байлгах	
31	21 дүгээр бүлэг	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан ы эсрэг гэмт хэрэг	21.12	Эрүү шүүлт тулгах	1.Хөнгөн
32			21.13	Гүйцэтгэх ажлын тухай хууль зөрчих	1.Хөнгөн
33	22 дугаар бүлэг	Авлигын гэмт хэрэг	22.4	Хахууль авах	1.Хөнгөн 2.Хүнд 3.Хөнгөн 4.Хүнд
34			22.11	Дураараа аашлах	1.Хөнгөн
35	23 дугаар бүлэг	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	23.5	Хайнга хандах	1.Хөнгөн 2.Хөнгөн
36			23.6	Хуулиар хориглосон тусгай техник хэрэгсэл ашиглах	1.Хөнгөн
37	24 дүгээр бүлэг	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	24.7	Ой, хээрийн түймэр тавих	1.Хөнгөн
38	25 дугаар бүлэг	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	25.1	Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах	1.Хөнгөн 2.Хөнгөн 3.Хөнгөн
39			25.2	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг эвдэх, гэмтээх, устгах	1.Хөнгөн 2.Хөнгөн
40	26 дугаар бүлэг	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	26.1	Цахим мэдээлэлд хууль бусаар халдах	1.Хөнгөн 2.Хөнгөн 3.Хүнд 4.Хүнд
41	27 дугаар бүлэг	Хөдөлгөөни й аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	27.3	Төмөр замын, агаарын, усан замын тээврийн хөдөлгөөний ба ашиглалтын аюулгүй байдлын журам зөрчих	1.Хөнгөн
42			27.9	Замын байгууламжийн ашиглалт, засварын	1.Хөнгөн 2.Хөнгөн

			аюулгүй байдлын журам зөрчих	
43		27.10	Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	1.Хөнгөн 2.Хөнгөн 3.Хөнгөн 4.Хүнд

Нийт 43 гэмт хэргийн үндсэн болон хүндрүүлэх, онц хүндрүүлэх зэрэг 83 бүрэлдэхүүний шинжтэй гэмт хэрэг үйлдэгдэж болохоор байна. Гэмт хэргийн ангилалын хувьд 67 хөнгөн, 16 хүнд ангилалын гэмт хэрэг байна. Цагдаагийн алба хаагчид ихэвчлэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11 дүгээр бүлэг буюу Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээр ял шийтгэгдэж байна. Шинэчлэн баталсан Эрүүгийн хуульд гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж хүний амь нас хохироосон тохиолдолд тусгайлан бие даасан гэмт хэргээр эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр, тусгай ангийн 10.3 зүйлд заасан. Энэ гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж, тайлбар зүйлчлэлийн талаар авч үзье.

Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох хэм хэмжээг хэтрүүлж хүнийг алах гэмт хэргийн ойлголт, шинж

Нэгдсэн үндэсний байгууллагаас 1948 онд баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалын гуравдугаар зүйлд: “Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй”, 1966 онд батлагдсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын наймдугаар зүйлд: “Амьдрах эрх бол хүний салшгүй бүрэн эрх мөн. Энэ эрхийг хуулиар хамгаална. Хэний ч амийг дур мэдэн бүрэлгэж болохгүй”³ гэж заасан байдаг. Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт: “Амьд явах эрхтэй. Монгол улсын эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно” гэж тус тус заажээ. Хүний амьд явах эрх бол Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний жам ёсны эрх буюу хүн төрөлхтөний үнэт зүйл юм. Тийм учраас аливаа ардчилсан нийгэмд хүний амьд явах эрхийг хамгаалах эрх зүйн баталгааг төр иргэдийнхээ өмнө хангах учиртай.

Энэ талаар Монгол улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд: “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн бусад баталгааг бүрдүүлж, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэж, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх талаар үүргээ хэрэгжүүлэх үүднээс ертөнцөд хүн болж төрснөөс эхэлдэг хүний хамгийн нандин эрх болох амьд явах эрхийг эрүүгийн хуулиар хамгаалсан байдаг. Улсын их хурлаас 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Эрүүгийн хуулийг шинэчлэн баталсан бөгөөд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 4.2 дугаар зүйлд: Баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах үйлдэл хийх явцдаа хэр хэмжээ хэтрүүлсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасантай уялдуулан, тусгай ангийн аравдугаар бүлгийн 10.3 дугаар зүйлд “Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж хүнийг алах” гэмт хэргийн шинжийг хуульчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заажээ.

³.Хүний эрх:Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхэтгэл.НҮБ.1992.,11 дүгээр тал.

Энэ гэмт хэрэг нь төрлийн объектын хувьд хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэгт хамаарах бөгөөд эрүүгийн хуульд орсон шинэлэг зохицуулалтын нэг юм. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг гэдэг нь Монгол улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний амьд явах эрхийг хангаж буй нийгмийн харилцаанд халдсан Эрүүгийн хуулийнтусгай ангийн 10.1 /Хүнийг алах/, 10.2 /Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүнийг алах/, 10.3 /Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсооххэр хэмжээг хэтрүүлж хүний алах/, 10.4 /Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх/, 10.5 /Эх нярай хүүхдээ алах/, 10.6 /Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох/ зүйлд заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл эс үйлдэхүйн нийлбэр цогцыг хэлнэ.

Хууль тогтоогчоос энэ гэмт хэрэгт оногдуулах ялын төрөл хэмжээг харьцангуй бага байхаар хуульчилсан нь энэрэнгүй ёсны зарчмын илрэл төдийгүй, хууль тогтоомжоор хүлээсэн албан үүргээ биелүүлэх үеийн харилцааг, хувийн шинжтэй харилцаанаас ялган зааглаж, ялыг ялгамжтай оногдуулах болохоор заасан. Энэ Эрүүгийн хуулийн хууль ёсны зарчмын хэрэгжилтийг хангаж, төсөөтэй хэрэглэхээс зайлсхийн, зөв хэрэглэх боломж бүрдүүлсэн. Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж хүнийг алах гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тайлбарлах нь онол, практикийн ач холбогдолтой.

Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж хүнийг алах гэмт хэрэг гэдэг нь: Гэмт хэрэг үйлдсэн хүн, оргосон ялтныг баривчлах, эрх бүхий байгууллагад хүргэх, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох зорилгоор халдахдаа тухайн хүний үйлдсэн гэмт үйлдлийн шинж чанар, хэр хэмжээнд илт тохирохгүй үйлдэл хийж; тухайн хүнд зайлшгүй хохирол учруулж саатуулах шаардлагатай нөхцөл байдал үүсээгүй байхад халдаж алсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.3 дугаар зүйлд хуульчлан тодорхойлж эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

Монгол улсын Эрүүгийн хуульд Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж хүнийг алах гэмт хэргийг үндсэн бүрэлдэхүүнтэйгээр хуульчилсан ба Эрүүгийн хуулийн 10.3 дугаар зүйлд: Гэмт хэрэг үйлдсэн хүн, оргосон ялтныг баривчлах, эрх бүхий байгууллагад хүргэх, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох зорилгоор халдахдаа тухайн хүний үйлдсэн гэмт үйлдлийн шинж чанар, хэр хэмжээнд илт тохирохгүй үйлдэл хийж; тухайн хүнд зайлшгүй хохирол учруулж саатуулах шаардлагатай нөхцөл байдал үүсээгүй байхад халдаж алсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж хуульчилсан ба гэмт хэргийн ангиллын хувьд хүнд гэмт хэрэгт хамаардаг.

Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж хүнийг алах гэмт хэргийн объект нь: Энэ гэмт хэргийн объект нь Үндсэн хуулиар хамгаалагдсан, хүний амьд явах эрх юм. Эрүүгийн эрх зүйн онолын үүднээс хүний амь гэдэг бол эхээс төрж анхны бодисын солилцоо бие даан явуулсан үеэс эхэлдэг гэж нийтээр хүлээн зөвшөөрдөг.⁴ Иймд хүний амьд явах эрхийг түүнийг эхээс мэндэлсэн тэр мөчөөс ертөнцийн жамаар амьсгал хураах хүртэл эрүүгийн хуулиар хамгаалдаг.

⁴Совд.Г.Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар.УБ.,2002.146 дугаар тал.

Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үед хүний амь насыг хохироож, бие махбодод нь гэмтэл учруулах зэрэг олон төрлийн хохирол, хор уршиг учруулж байдаг. Тухайлбал эд хөрөнгийн, сэтгэл санааны, ёс суртахууны, чөлөөтэй зорчин явах эрхийг нь хязгаарлах зэргээс гадна хохирол нь ямагт хууль зүйн үнэлэлт дүгнэлт шаардаж байдаг.

Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж хүнийг алах гэмт хэргийн обьектив тал нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.3 дугаар зүйлийн диспозицид зааснаар обьектив талын бүтцийн хувьд материаллаг бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг бөгөөд гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох зорилгоор халдах явцад гэмт хэрэг үйлдсэн хүн, оргосон ялтны амь нас хохироосон идэвхтэй үйлдэл хийснээр гэмт хэрэг төгсөнө. Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох ажиллагаа нь ямагт биеийн идэвхтэй хөдөлгөөн шаардаж байдаг онцлогтой ба эс үйлдэхүйгээр үйлдэгдэх боломжгүй юм. Хэр хэмжээг хэтрүүлж алсан үйлдэл нь гэмт хэрэг үйлдсэн хүн, оргосон ялтныг баривчлах, эрх бүхий байгууллагад хүргэх, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох явцадаа алсан зэрэг ямар ч хэлбэрээр илэрч болно. Харин хэр хэмжээний хүрээнд үйлдэл хийж тухайн этгээдийн амь насыг хохироосон үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй.

Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж алах гэдгийг: гэмт хэрэг үйлдсэн хүн, оргосон ялтныг баривчлах, эрх бүхий байгууллагад хүргэх, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох зорилгоор халдахдаа тухайн хүний үйлдсэн гэмт үйлдлийн шинж чанар, хэр хэмжээнд илт тохирохгүй үйлдэл хийж, тухайн хүнд зайлшгүй хохирол учруулж саатуулах шаардлагатай нөхцөл байдал үүсээгүй байхад халдаж алсан үйлдлийг хэлнэ. Гэмт хэрэг үйлдсэн хүн гэдэгт: Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай, гэм буруутай, үйлдэл эс үйлдэхүй хийсэн эрүүгийн хариуцлага хүлээх чадвартай хүнийг ойлгоно. Оргосон ялтан гэдэгт: Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай, гэм буруутай, үйлдэл, эс үйлдэхүй хийж гэм буруутайн шүүхээр тогтоогдон, шүүхийн тогтоол хүчин төгөлдөр болсноос хойш оногдуулсан ялыг эдлэхээс хүндэтгэх шалтгаангүйгээр санаатайгаар зайлсхийх зорилгоор хорих анги, баривчлах байрнаас, зөвшөөрөлгүйгээр эргэж ирэхгүйгээр бүрмөсөн явсан, түүнчлэн хорихоос өөр бусад төрлийн ял эдлэхтэй холбогдон үүссэн үүргээ биелүүлэхээс ноцтой зайлсхийсэн этгээдийг хэлнэ. Гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох гэдэгт: гэмт хэрэг үйлдсэн хүн, оргосон ялтны гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох явцадаа тухайн хүний үйлдсэн гэмт үйлдлийн шинж чанар, хэр хэмжээнд илт тохироогүй, зайлшгүй хохирол учруулж гэмт этгээдийг баривчлах шаардлагатай нөхцөл байдал үүсээгүй байхад, холбогдох хуульд заасан баривчлах, таслан зогсоох үндэслэл, журмыг зөрчин гэмт хэрэг үйлдсэн хүн болон, оргосон ялтанд халдаж амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсныг баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлсэн гэж үзнэ. Хэр хэмжээ хэтрүүлж алсан үйлдэл, эс үйлдэхүй хийсний улмаас гэмт хэрэг үйлдсэн хүн болон, оргосон ялтны амь нас хохирсон хохирол хоёрын хооронд шалтгаант холбоотой байна.

Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж хүнийг алах гэмт хэргийн субъектив тал нь гэм буруугийн шууд ба шууд бус санаатай хэлбэрээр үйлдэгдэх ба энэ гэмт хэргийн бүрэлдэхүүний субъект нь тусгай субъект байна.

Эрүүгийн хуулийн 10.3 дугаар зүйлд заасан: төрийн эрх бүхий байгууллагад хүргэх, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой байна. Эдгээр зорилго нь субъектив талын заавал байх шинж болох ба энэ шинжийг зайлшгүй тогтооно. Хэрэв хуульд заасан дээрх зорилго тогтоогдохгүй, хувийн өш хонзон болон бусад сэдэлтээр алсан бол гэмт хэргийн зүйлчлэл өөрчлөгдөх ба Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан Хүнийг алах гэмт хэргийн зохих зүйл, хэсгээр зүйлчилж эрүүгийн хариуцлага оногдуулна.

Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж хүнийг алах гэмт хэргийн субъект нь нийтлэг болон тусгай субьектийн шинжтэй байх ба гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуульд⁵ зааснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оролцож, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоож байгаа иргэн нь энэ гэмт хэргийн нийтлэг субьект буюу эрүүгийн хуульд заасан насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн байдаг бол тусгай шинж шаарддаг субьект нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох хэр хэмжээ хэтрүүлж алсан, хэрэг хариуцах чадвартай, холбогдох хууль тогтоомжоор эрх олгогдсон хууль сахиулагчид буюу цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагч, хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд, байгаль хамгаалагч Монгол Улсын иргэн байна.

Цагдаагийн алба хаагч гэдэгт: Цагдаагийн тангараг өргөж, цагдаагийн аль нэг байгууллагад томилогдон ажиллаж байгаа цагдаагийн цолтой иргэнийг цагдаагийн алба хаагчийг хэлнэ.⁶

Тагнуулын алба хаагч гэдэгт: Тагнуулын байгууллагын тухай хуульд заасан тангараг өргөж, тагнан турших болон түүнтэй адилтгах ажил эрхэлж буй төрийн тусгай албан хаагчийг тагнуулын ажилтныг хэлнэ.⁷

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч гэдэгт: Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан шаардлага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тогтоосон журам, эрүүл мэнд, бие бялдар, мэргэжил, ёс зүйн шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан, арван найман насанд хүрсэн, дээд боловсролтой, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байгаагүй Монгол Улсын иргэнийг хэлнэ.⁸

Төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагч гэдэгт: Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн тангараг өргөж, хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа иргэнийг төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг хэлнэ.⁹

Хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд гэдэгт: Татварын байгууллагын сонгон шалгаруулалтад орж тэнцсэн, хууль тогтоомжоор эрх эдэлж, үүрэг хүлээсэн, татварын улсын байцаагчийн эрхтэй иргэнийг¹⁰ татварын улсын байцаагч, гадаад хэлний зохих мэдлэгтэй, дээд боловсролтой, гаалийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр мэргэжлийн тусгай сургалтад

⁵ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль. УБ., 1997.10 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэг.

⁶ Цагдаагийн албаны тухай хууль. УБ., 2017. 66 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

⁷ Тагнуулын байгууллагын тухай хууль. УБ., 1999.17 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

⁸ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ., 2017.270 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.

⁹ Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль. УБ., 1995.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

¹⁰ Татварын ерөнхий хууль. УБ., 2008.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг.

хамрагдсан ¹¹ гаалийн хууль тогтоомжийн дагуу хяналт, шалгалт хийх эрх эдэлж, үүрэг хүлээх гаалийн албан тушаалтанаар томилогдсон Монгол Улсын иргэнийг гаалийн улсын байцаагч,¹² Хил, гааль, мал эмнэлэг, эрүүл ахуй, халдвар судлал, автотээврийн, хүүхдийн, уул уурхайн зэрэг хяналтын улсын байцаагч, гэрээт харуул хамгаалалтын ажилтан нарыг ойлгох бөгөөд хуульд зааснаар дээрх хяналтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажилтанд байгаль орчны улсын байцаагчийн эрх олгож, хяналтын үүрэг гүйцэтгүүлж болно¹³

Байгаль хамгаалагч гэдэгт: Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас байгаль орчны чиглэлээр сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий сургуулийн мэргэжлийн сургалтанд хамрагдаж төгссөн, байгаль орчныг бохирдохоос урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг нь алдагдуулахгүйгээр, байгалийн даацад нь тохируулан зохистой ашиглах, нөхөн сэргээх, тэдгээрт хяналт тавих үйл ажиллагаа эрхэлж, байгаль хамгаалагчаар ажиллаж байгаа иргэнийг хэлнэ.¹⁴ Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох явцад баривчлах, таслан зогсоох үйлдэл хийж буй субъект нь гэмт хэрэг үйлдэж оргосон ялтан, гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийж буй хүний биеийн байдал, эрүүл мэндийн талаар урьдчилсан тодорхой төсөөлөл, мэдээлэлтэй байх ёстой.

Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж хүнийг алах гэмт хэргийн тайлбар, зүйлчлэлийн асуудал

Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох хэр хэмжээ хэтрүүлж хүнийг санаатай алсан тохиолдолд хууль сахиулагчын үйлдлийг нийгэмд аюултай гэж үздэг. Хохирогч нь хэдийд нас барсан нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй ба гэмт хэргийн субъект нь алах санаа зорилготой байдаг. Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үйлдэл хийж буй субъектийн хувьд өөрийн идэвхтэй үйлдлийн улмаас хүний амь нас хохирон гэдгийг урьдчилан ухамсарласан байх ёстой. Гэмт хэрэг үйлдсэн этгээд болон оргосон ялтан нь зугтаах явцад хууль сахиулагчдын үйлдлийн улмаас бус өөр бусад хүчин зүйлийн улмаас тухайн хүний амь нас хохирсон бол Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.3 дугаар зүйлд заасан “Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээ хэтрүүлж алах” гэмт хэргээр зүйлчлэхгүй.

Учир нь гэмт хэргийн бүрэлдэхүүний обьектив талын шалтгаант холбоо байхгүй гэж үзнэ. Хуульд заасан зорилгоор гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох хэр хэмжээ хэтрүүлэх үйлдэл хийх явцдаа болгоомжгүй үйлдлийн улмаас баривчлагдаж, үйлдэл нь таслан зогсоогдож буй хүний амь нас хохирсон тохиолдолд гэмт хэрэгт тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

Харин гэмт хэрэг үйлдсэн хүн, оргосон ялтныг баривчлах, эрх бүхий байгууллагад хүргэх, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох зорилгогүйгээр хууль сахиулагч нь тухайн этгээдийн амь насыг болгоомжгүйгээр хохироосон бол Эрүүгийн хуулийн тусгай ангийн

¹¹.Гаалийн тухай хууль.УБ.,2008.273 дугаар зүйлийн 5 дахь хэсэг.

¹².Гаалийн тухай хууль.УБ.,2008.273 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

¹³.Байгаль орчныг хамгаалах тухай хууль.УБ.,1995.26 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

¹⁴.Байгаль орчныг хамгаалах тухай хууль.УБ.,1995.26 дугаар зүйлийн 6 дахь хэсэг.

10.6 дугаар зүйлд заасан “Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох” гэмт хэргээр, мөн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.3 дугаар зүйлд заасан зорилгогүйгээр гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох хэр хэмжээ хэтрүүлж хувийн сэдэлтээр гэмт хэрэг үйлдсэн хүн, оргосон ялтны амь насыг хохироосон бол, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр “Хүнийг алах” гэмт хэргээр тус тус зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Хууль тогтоогч Эрүүгийн хуулийн тусгай ангид “Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээ хэтрүүлж алах” гэж зааснаас үзэхэд энэ гэмт хэрэг нь зөвхөн гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэхээр байна. Өөрөөр хэлбэл Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан “Хүнийг алах” гэмт хэргээс гэмт хэрэг үйлдсэн хүн, оргосон ялтны амь насыг санаатай алах үеийн нөхцөл байдлаараа ялгаатай байна.

Бородин.С.В.: “Хүнийг санаатай алах бусад гэмт хэргүүдээс гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох хэр хэмжээ хэтрүүлж алах гэмт хэргийн объектив талын шалтгаант холбоо тодорхойгүй байдаг ба практикт ямар нөхцөл байдалд дээрх гэмт хэрэг үйлдэгдсэнийг чухалчлан харгалздаггүй”¹⁵ гэжээ. Гэмт хэрэг үйлдэгдэх үеийн нөхцөл байдлыг зөв тогтоосноор гэмт хэргийг зөв зүйлчлэх ба эрүүгийн хуулийг зөв хэрэглэх, ялыг ялгамжтай оногдуулах, хүний эрхийг хангах, хууль ёс бэхжих үндэслэл болно. Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үед хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн хүн, оргосон ялтны хийсэн үйлдлийн нийгмийн аюулын шинж чанар, амь насыг нь хохироох зайлшгүй шаардлагатай нөхцөл байдал үүссэн, хууль сахиулагчийн үйлдлийг эсэргүүцсэн, гэмт этгээдийн тоо, эсэргүүцлийн эрч хүч, зэвсэг хэрэгсэл хэрэглэсэн эсэх, байгал цаг уурын өөрчлөлт, газар, цаг үе, зугатаасан зэрэг шинжийг харгалзан тухайн үеийн нөхцөл байдлыг тогтоохоос гадна баривчлах, таслан зогсоох хэр хэмжээ хэтрүүлж алах гэмт хэргийн объектив талыг тогтооход мөн адил харгалзана.

Гэмт хэрэг үйлдсэн хүн, оргосон ялтны эсэргүүцэл үзүүлсэн, зугтаасан үйлдэл нь хууль сахиулагчийн хувьд баривчлах, таслан зогсоох үндэслэл болно. Хэрэв гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үед хийсэн үйлдэл нь дээрх нөхцөл байдлуудад илт тохирохгүй бол баривчлах, таслан зогсоох хэр хэмжээ хэтрүүлсэн гэж үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Жишээ нь: хулгайлах гэмт хэрэг үйлдэж буй этгээдийн үйлдлийг таслан зогсоох зорилгоор амь насыг санаатай хохироож болохгүй. Харин гэмт хэрэг үйлдэж буй этгээд хууль сахиулагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг үл биелүүлэн галт зэвсэг хэрэглэн эсэргүүцсэн тохиолдолд тухайн нөхцөл байдалд тохирсон арга хэмжээ авах буюу тухайн этгээдэд хамгийн бага хохирол учруулж болохуйц арга хэмжээ авах ёстой. Хэрэв гэмт этгээдийн үйлдэл нь бусдын амь насыг хохироох нөхцөл байдлыг үүсгэх нь илэрхий болсон үед гэмт этгээдэд зайлшгүй хохирол учруулж саатуулах шаардлага бий болсон бол амь нас, эрүүл мэндэд нь хохирол учруулж болно.

Побегайло.Э.Ф.: “Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үед гэмт этгээд зугтаасан, оргон зайлсан тохиолдолд амь насыг хохироож болох бөгөөд гэмт хэрэгт тооцохгүй. Жишээ нь: дээрэмдэх,

¹⁵Бородин.С.В.Преступления против жизни.М.,1999.стр 48.

хүн хулгайлах, хүн барьцаалах, хүчиндэх, хүнийг алах гэмт хэргийн үед” гэснийг¹⁶ хүлээн зөвшөөрөх боломжгүй юм. Учир нь гэмт этгээдийн хүч хэрэглэсэн үйлдлийг харгалзах бус тухайн үеийн нөхцөл байдалд илүү тохирсон арга хэмжээ хэрэглэх ба зайлшгүй тохиолдолд л амь насыг хохироож болно гэдгийг анхаарах шаардлагатай. Харин Эрүүгийн хуулийн хорин есдүгээр бүлэгт заасан “Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг”-т хамаарах террор үйлдэх, олон улсын хамгаалалтанд байдаг хүнд халдах, төрлөөр устгах зэрэг гэмт хэрэг үйлдэж байх үедээ гэмт этгээд зугтаах, оргон зайлахаар завдсан тохиолдолд амь насыг хохироож болох юм. Эдгээр гэмт хэргүүд нь олон улсын шинжтэй, улс дамнасан, олон хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулдаг, ихэвчлэн олон улсын конвенцид заасан, нийгмийн аюул ихтэй, хүч хэрэглэсэн гэмт хэргүүд байдаг онцлогтой.

Гэмт этгээд хүч хэрэглэсэн эсэх, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үеийн хэр хэмжээ зэргийг харгалзан харьцуулж үзэх нь ач холбогдолтой бөгөөд хэрэв хийсвэр байдлаар хандвал гэмт хэргийг зүйлчлэхэд хүндрэл үүснэ. Жишээ нь: хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд давуу (биеийн хүч, зэвсэг хэрэгсэл, хүний тоо, эсэргүүцсэн байдал зэрэг) байсан тохиолдолд түүний амь насыг хохироосон бол хэр хэмжээ хэтрүүлсэн гэж үзэхгүй.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлд заасан Хүнийг алах гэмт хэрэгт оногдуулах хорих ялын дээд хязгаар нь 20 жил байгаа бол Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээ хэтрүүлж алах гэмт хэрэгт оногдуулах хорих ялын дээд хязгаар нь найман жил байна. Хүнийг алах гэмт хэрэгт оногдуулах хорих ялын дээд хязгаарыг харьцуулж үзэхэд 2.5 дахин бага, Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох, Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүний алах гэмт хэрэгт оногдуулах хорих ялын дээд хязгаартай харьцуулж үзэхэд 1.6 дахин их байна. Өөрөөр хэлбэл төсөөтэй гэмт хэргүүдээс нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээ нь Хүнийг алах гэмт хэргээс 2.5 дахин бага Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.2, 10.6 дугаар зүйлд заасан гэмт хэргээс 1.6 дахин бага байна.

Гэмт хэрэг үйлдсэн этгээд, оргосон ялтныг, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох явцад илт эсэргүүцээгүй, оргох, зугтаах үйлдэл хийгээгүй, амь насыг нь хохироохгүйгээр баривчилж, таслан зогсоох боломж байсан, зугтаагаагүй үед баривчлах, таслан зогсоох эрх бүхий субъектийн хувьд давуу (зэвсэглэсэн байдал, тооны хувьд их, биеийн хүч бэлтгэл илүү гэх мэт) байсан бол Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.3 дугаар зүйлд заасан Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж хүнийг алах гэмт хэргээр зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Бородин.С.В:“Гэмт хэрэг үйлдсэн хүн, оргосон ялтныг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үед эсэргүүцэл үзүүлж зугтаагаагүй тохиолдолд тухайн этгээдийн амь насыг санаатай алсан бол, ердийн журмаар буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлд заасан Хүнийг алах гэмт хэргээр зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь зүйтэй”¹⁷ гэснийг

¹⁶.Побегайло.Э.Ф.Уголовное право России:Учебник для вузов.В.2т.Особенная часть.Под ред.Игнатова.А.Н, Красикова.Ю.А.М.,2000.стр 60.

¹⁷.Бородин.С.В.Преступления против жизни.М.,1999.стр 230.

хүлээн зөвшөөрөх боломжгүй юм. Учир нь гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох явцад гэмт хэрэг үйлдсэн хүн, оргосон ялтныг төрийн эрх бүхий байгууллагад хүргэх, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгыг хэрэгжүүлэх явцад баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж алсан бол бол Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.3 дугаар зүйлд заасан гэмт хэргээр зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь зүйтэй. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.6.2 дугаар зүйлд заасан хөнгөн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үед алсан бол баривчлах, таслан зогсоох ажиллагааны хэр хэмжээг хэтрүүлж алсан гэж үзэж Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.3 дугаар зүйлд зааснаар зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь зүйтэй гэж үздэг судлаачидтай санал нийлэхгүй байна.

Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох гэмт хэргийн нийгмийн хор аюул, хэр хэмжээ, тухайн үеийн нөхцөл байдлыг л үнэлж дүгнэсний үндсэн дээр баривчлах, таслан зогсоох ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх боломжтой бөгөөд тухайн үед гэмт хэргийн ангиллыг харгалзан хэр хэмжээ хэтрүүлсэн эсэхийг тогтоон гэдэг нь хууль тогтоогчийн үзэл санаа, Эрүүгийн хуулийн хэм хэмжээний утга, агуулга, мөн чанарыг буруу ойлгон хэрэглэх нөхцөл бүрдүүлнэ.

Харин баривчлах, таслан зогсоох явцад бус уг ажиллагаа дууссаны дараа хувийн болон бусад сэдэлтээр гэмт хэрэг үйлдсэн хүн, оргосон ялтны амь насыг хохироосон бол ердийн журмаар буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн зохих хэсгээр зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйл нь нийтлэг хэм хэмжээ, 10.3 дугаар зүйл нь тусгай хэм хэмжээ гэж үзэх ёстой. Тусгай хэм хэмжээ гэдэгт: гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үеийн онцгой нөхцөл байдлыг хамааруулах ба гэмт хэргийг зүйлчлэхэд энэ шинжийг зайлшгүй харгалзана. Гэмт хэрэг үйлдсэн цаг хугацаа гэдэгт: гэмт этгээдийг баривчлах, таслан зогсоох үед гэм хор учруулах явцад хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй, гэмт хэрэг үйлдэж төгссөн байх үеийг хамааруулна.

Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үед хэр хэмжээ хэтрүүлж алсан бол тухайн гэмт этгээдийн үйлдсэн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг харгалзаж үзэх ёстой. Гэмт этгээдийн үйлдсэн, гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан үед баривчлах, таслан зогсоох ажиллагааг хэрэгжүүлж хохирол учруулсан бол хууль ёсны гэж үзэхгүй бөгөөд Хүнийг алах гэмт хэргээр зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээ хэтрүүлж алах үед гэм буруугийн санаатай хэлбэрээр алсан бол Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.3 дугаар зүйлд зааснаар зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Харин гэм буруугийн болгоомжгүй хэлбэрээр буюу хөнгөмсөгөөр найдаж эсвэл хайхрамжгүй хандаж амь насыг хохироосон бол хэр хэмжээ хэтрүүлж алсан гэж үзэхгүй. Энэ талаар Побегайло.Э.Ф.: “Гэм буруугийн шууд ба шууд бус санаатай байсан эсэх нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй”¹⁸ гэснийг хүлээн

¹⁸.Побегайло.Э.Ф. Уголовное право России: Учебник для вузов. В.2т. Особенная часть. Под ред. Игнатовой. А.Н., Красиковой. Ю.А. М., 2000. стр 61.

зөвшөөрөх боломжтой бол Борзенков.Г.Н:“Зөвхөн шууд бус санаатай гэм хор учруулсан байх ёстой”¹⁹ гэж үзсэнтэй санал нийлэхгүй байна.

Баривчлагдаж, таслан зогсоогдож байгаа этгээд өөрийнхөө хууль бус үйлдлээр амь насаа хохироож болох нөхцөлийг бий болгодог ба гэм буруугийн санаатай хэлбэрийн хувьд анхнаасаа ийм зорилго агуулсан байх ёстой байдаг. Тэгвэл дээрх ажиллагаа нь урьдчилан сэргийлэх зорилгоор хийгддэг тул шууд болон шууд бус санааны аль ч хэлбэрээр нь үйлдэгдэж болно. Шавгулидзе.Т.Г.:”Баривчлах, таслан зогсоох нь гэмт хэрэг үйлдсэн хүн, оргосон ялтан, гэмт хэрэг үйлдэж буй хүнд хохирол учруулах зорилгогүй байдаг учраас санаатайгаар алж болохгүй”²⁰ гэсэнтэй санал нийлэхгүй байна.

Баривчлах, таслан зогсоох ажиллагааны үед тухайн үеийн нөхцөл байдалд тохируулан хэр хэмжээ хэтрүүлэхгүйгээр амь насыг хохироосон бол гэмт хэрэгт тооцохгүй. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.5 дугаар зүйлд таслан зогсоох хэр хэмжээ хэтрүүлснийг хөнгөрүүлэх нөхцөл байдалд хамааруулаагүй учраас 10.3 дугаар зүйлд заасан гэмт хэргийг хөнгөрүүлэх бүрэлдэхүүнтэй гэж үзэхгүй. Харин хэр хэмжээ хэтрүүлэн гэмт этгээдийн амь насыг санаатай алсан бол хохирогчын хууль бус үйлдэл нөлөөлсөн гэж үзэж Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.5 дугаар зүйлийн 1.4 дэх хэсгийг журамлан хөнгөрүүлж эрүүгийн хариуцлага оногдуулж болно.

Түүнчлэн гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үед хууль сахиулагч нөхцөл байдлыг буруугаар төсөөлөн андуурсны улмаас хэр хэмжээ хэтрүүлэн гэмт хэрэг үйлдсэн хүн, оргосон ялтны амь насыг санаатай алсан бол Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.6 дэх хэсгийн журамлан хөнгөрүүлэн үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Мөн эрүүгийн хуульд заагаагүй онцгой нөхцөл байдлын харгалзан шүүх эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлж оногдуулж болно. Онцгой нөхцөл байдал гэдэгт онц байдал зарласан үед, гамшигт үзэгдлийн үед, аюулт үзэгдлийн үед, эмх замбараагүй байдлын үед эсвэл дайны болон дайн бүхий зарласан үед гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үед хэр хэмжээ хэтрүүлж алсан бол мөн хөнгөрүүлж үзнэ. Субъектив талын нэмэгдэл шинж болох гэмт хэрэг үйлдэх үеийн сэдэлт, сэтгэл санааны байдал зэрэг нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй. Практикт гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хохирол учруулах үед субъектив шинжтэй хүндрэл бэрхшээл бий болдог.

Ийм тохиолдолд хууль сахиулагч баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоосон нь хууль ёсны байсан эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх явдал нь харьцангуй байдаг. Ялангуяа гэмт этгээдийн амь насыг хохироох үед хууль ёсны эсэхийг ухамсарлах нь хүндрэлтэй байдаг. Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үед хууль сахиулагч болон гэмт үйлдлийг таслан зогсоож буй иргэн сэтгэл зүйн хөөрлийн байдалд байдаг учраас тухайн нөхцөл байдлыг үнэлж дүгнэх боломж хомс, байнга асуудалтай тулгарч байдаг. Гэмт хэрэг үйлдсэн хүн, оргосон ялтан, гэмт этгээдэд хохирол учирсны дараа л тухайн үеийн бүхий л нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгөх боломж бүрддэг юм. Ийм учраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.3 дугаар зүйлд заасан гэмт хэргийн объектив талын шинж,

¹⁹.Борзенков.Г.Н.В силу сложившихся обстоятельств.Человек и закон.1997.№9 стр 64.Уголовный кодекс Российской Федерации.Научно-практический комментарий. Стр 256-257.

²⁰.Шавгулидзе.Т.Г.Необходимая оборона.Тбилиси.,1966.стр 143.

баривчилж саатуулсан субъектийн сэтгэл санааны байдал зэрэгт зөвхөн шүүх л эцсийн үнэн, зөв, шударга, бодитой үнэлэлт дүгнэлт өгч шийдвэрлэх учиртай юм.

Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээ хэтрүүлж алах гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн хор аюулын шинж чанар хэр хэмжээ нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлд заасан Хүнийг алах гэмт хэргээс харьцангуй бага гэмт хэрэг бөгөөд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.6.1 дүгээр зүйлд зааснаар дээрх хоёр гэмт хэрэг нь хүнд гэмт хэргийн ангилалд багтдаг гэмт хэргүүд юм. ОХУ-ын эрдэмтэн Ветров.Н.И., Кадников.Н.Г., Якубович.М.И нар “Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох хэр хэмжээ хэтрүүлж алсан хууль сахиулах байгууллагын алба хаагчдын үйлдэл нь бие даасан өөр гэмт хэргээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх бус Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан төрийн алба хаагч, эрх мэдлээ урвуулах хэтрүүлэх гэмт хэргээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх ёстой”²¹ гэж үзсэнтэй санал нийлэхгүй байна.

Төрийн албан хаагч эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийн субъектийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж өөртөө болон бусдад давуу байдал бий болгох үйлдэлтэй, хууль сахиулагчийн гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, таслан зогсоохтой адилтгаж эрүүгийн хариуцлага хүлээлгэж болохгүй.

Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох хэр хэмжээ хэтрүүлж алах гэмт хэргийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.9 дүгээр зүйлд заасан “Хууль бусаар гэмт этгээдийг баривчлах, саатуулах” гэмт хэргээс ялган зөв зүйлчлэх асуудал нь практикийн чухал ач холбогдолтой юм. Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээ хэтрүүлж алах гэмт хэргийн объект нь хүний амьд явах эрх байдаг бол Хууль бусаар гэмт этгээдийг баривчлах, саатуулах гэмт хэргийн объект нь хүний халдашгүй чөлөөтэй байх эрх байдаг.

Объектив талын хувьд гэмт хэрэг үйлдсэн хүн, оргосон ялтныг баривчлах, эрх бүхий байгууллагад хүргэх, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох зорилгоор халдахдаа тухайн хүний үйлдсэн гэмт үйлдлийн шинж чанар, хэр хэмжээнд илт тохирохгүй үйлдэл хийж тухайн хүнд зайлшгүй хохирол учруулж саатуулах шаардлагатай нөхцөл үүсээгүй байхад халдаж алсан идэвхтэй үйлдэл хийсэн бол Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээ хэтрүүлж алах гэмт хэрэг буюу материаллаг шинжтэй, эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл журмыг зөрчиж хүний эрх чөлөөнд халдсан, баривчилсан, саатуулсан, уг үйлдлийг өс хонзон, шунахай, хувийн сэдэлтгээр үйлдсэн бол Хууль бусаар баривчлах, саатуулах гэмт хэрэг хэлбэрийн шинжтэй буюу ямар нэгэн тодорхой хохирол шаардахгүй.

Хууль бусаар баривчлах, саатуулах гэмт хэрэг нь зөвхөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад л үйлдэгдэх боломжтой бол Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээ хэтрүүлж алах гэмт хэрэг нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ,гэмт

²¹.Ветров.Н.И.Уголовное право.Особенная часть:Учебник для вузов.М.,2000.стр 42;

Кадников.Н.Г.Теоретические и практические основы квалификации преступлений.М.,стр 60;

Якубович.М.И.Необходимая оборона и задержание преступника.М.,Издво.Знание.1976.стр 68.

хэргээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны аль ч үед үйлдэгдэх боломжтой юм.

Дээрх хоёр гэмт хэргийн субьектив тал нь гэм буруугийн хэлбэрийн хувьд ижил байдаг боловч гэмт хэрэг үйлдсэн хүн, оргосон ялтныг эрх бүхий байгууллагад хүргэх, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох зорилгоороо, мөн хүний эрх чөлөөнд халдах үед өс хонзон, шунахайн болон хувийн сэдэлтээр ханддагаараа ялгаатай байна. Тэгвэл субьектийн хувьд хэд хэдэн шинжээрээ ялгаатай юм.

Тухайлбал Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээ хэтрүүлж алах гэмт хэргийн субьект нь эрүүгийн хуульд заасан насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн болон Цагдаа, Тагнуул, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагч, хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд буюу Гаалийн, Татварын, Нийгмийн даатгалын, Хүүхдийн эрхийн, Мэргэжлийн хяналтын, Авто тээврийн улсын байцаагч болон Байгаль хамгаалагч хэн ч байж болно. Тэгвэл Хууль бусаар баривчлах, саатуулах гэмт хэргийн субьект нь Цагдаагийн эрх бүхий алба хаагч буюу хэрэг бүртгэгч, мөрдөгч, шүүгч, прокурор байх ба энэ гэмт хэрэг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад үйлдэгддэг онцлогтой. Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох явцад хуульд заасан үндэслэл журмын дагуу тухайн үеийн нөхцөл байдал, баривчлах, таслан зогсоох хэр хэмжээний хүрээнд, тухайн этгээдийн бие махбодод хөнгөн, хүндэвтэр, хүнд хохирол учруулсан тохиолдолд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 4.2 дугаар зүйлд заасныг журамлан эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

Харин тухайн үеийн нөхцөл байдалд илт тохироогүй, зайлшгүй хохирол учруулж саатуулах шаардлага бий болоогүй байхад халдаж тухайн этгээдийн бие махбодод хөнгөн, хүндэвтэр, хүнд хохирол учруулсан тохиолдолд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.1 дүгээр зүйлд заасан Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах, 11.3 дугаар зүйлд заасан Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах, 11.4 дүгээр зүйлд заасан Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах, 11.5 дугаар зүйлд заасан Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах, 11.6 дугаар зүйлд заасан Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэргүүдийн аль зохих зүйл хэсгүүдээр тус тус зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Харин гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдэж байгаа этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үед хууль сахиулагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг эсэргүүцэн хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн бол Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11 дүгээр бүлгийн долоо дахь хэсэгт заасан Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнээр зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Энэ нь зөвхөн хууль сахиулагч ч бус хүчирхийлэгчийн үйлдлийг таслан зогсоох үйлдэл хийсэн хүн бүрт хамааралтай.

Дүгнэлт

Цагдаагийн алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журам хамгаалах талаар, хууль тогтоомжид заасан эрхээ хэрэгжүүлэх эрх зүйн орчин, баталгаа бүрэн хангагдаагүй, үүргээ хэрэгжүүлэх явцад бусдад учруулсан хохиролын улмаас эрүүгийн хариуцлагад

татагдах, улмаар ял шийтгэгдэх явдал цөөнгүй байна. Энэ нь алба хаагчдийн мэдлэг, ур чадвар, хандлагад сөргөөр нөлөөлж байна. Шүүхийн практикт баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах хэм хэмжээг хэтрүүлж бусдад хохирол учруулсан тохиолдолд тухайн үйлдлийг онолын түвшинд зөв ойлгож зүйлчлэх, гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал байгаа эсэх, ялыг ялгамжтай оногдуулах.

2015 оны эрүүгийн хуулийн үзэл санаанд нийцүүлэн зарим хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах замаар эрх зүйн орчинг боловсронгуй болгох зайлшгүй шаардлага байна. Тухайлбал гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох үед бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсан тохиолдолд Эрүүгийн хуулийн тусгай ангийн хэм хэмжээ бүрэн дүүрэн оновчтой шийдвэрлэх боломжгүй, шүүхийн байгууллага өөр өөр байдлаар ойлгон хэрэглэж байна. Энэ нь Эрүүгийн хуулийн хууль ёсны зарчим алдагдах төдийгүй, шудрага бус байдлыг бий болгон, хуулийг төсөөтэй хэрэглэж байна гэж дүгнэж болох юм. Иймд эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар дараах саналыг дэвшүүлж байна.

Санал

1.Баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах хэм хэмжээг хэтрүүлж хүнийг алсан бол Эрүүгийн хуулийн 10.3 дугаар зүйлд зааснаар зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь дэвшилттэй алхам боловч, эрүүл мэндэд хохирол учруулсан үйлдлийг хувийн сэдэлтэй гэмт хэргээр зүйлчилж байгаа явдал нь төсөөтэй хэрэглэхэд хүргэжм банийа. Тийм учраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11 дүгээр бүлэгт “Баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах хэм хэмжээг хэтрүүлж хүний биед хүнд хохирол учруулах” гэмт хэргийг шинээр нэмж хуульчлах, шаардлагтай. Гэхдээ оногдуулах ялын төрөл хэмжээ нь харьцангуй бага байх ёстой.

2.Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд харуул хамгаалалтын ажилтан аргагүй хамгаалалтын хүрээнд галт зэвсэг, биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх талаар заасан нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 4.1 дүгээр зүйлд заасан Аргагүй хамгаалалтын хэм хэмжээтэй зөрчилдөж байна. Учир нь Аргагүй хамгаалалт нь зөвхөн өөрийн болон ойр дотны хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг аюултай довтолгоон хийсэн тохиолдолд хэрэгжинэ. Тэгвэл хамгаалж буй объект буюу өмчид халдан довтолсон үед Аргагүй хамгаалалт хийх боломжгүй харин баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах хэм хэмжээгээр шийдэрлэнэ. Энэ талаар Эрүүгийн хуулийн 4.2 дугаар зүйлийн тайлбарт “Хууль сахиулагч гэдэгт...хуулиар тусгшайлан эрх олгогдсон эрх бүхий этгээд” гэдэгт гэрээт харуул хамгаалалтын ажилтаныг хамааруулан ойлгох боломжтой.

3.Баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах хэр хэмжээг хуульд заасан үндэслэл журмын дагуу хэрэгжүүлсэн үйлдлийг хэрэгсэхгүй болгохдоо Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд заасан “Гэмт хэргийн шинжгүй” гэх үндэслэлийг баримталж байгаа нь Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн уялдааг харгалзахгүй, хууль буруу хэрэглэж байгаагийн тод жишээ юм. Учир нь гэмт хэргийн шинжгүй гэдэг нь гэмт хэргийн бүрэлдэхүүний аль нэг шинж нь байхгүй гэсэн үг, тэгвэл баривчлах, таслан зогсоох ажиллагааг хуульд заасан үндэслэл журмын дагуу хэрэгжүүлж бусдад хохирол учруулсан үйлдэл нь гэмт хэргийн шинжийг бүрэн агуулсан боловч нийгэмд ашигтай зорилгоор хийгдэж байгаа тул гэмт хэрэгт ооцдоггүй.

Ийм учраас Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйл, 32.5 дугаар зүйлд тус тус "Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 4 дүгээр бүлэгт заасан гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал тогтоогдсон" гэж нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагтай байна.

СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРЛЫН ТАЛААРХ ЗАРИМ АСУУДАЛ

Б.Мөнхзул

ДХИС-ийн ЦС-ийн сургуулийн Эрүүгийн эрх зүй,
криминологийн тэнхимийн багш, магистр
цагдаагийн ахлах дэслэгч

М.Булган

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
322-р дамжааны сонсогч

Удиртгал

Эрх зүйт төрийн чухал зорилтуудын нэг бол иргэнийхээ зөрчигдсөн эрхийг аль болох шуурхай, шударга байдлаар сэргээх, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх механизмыг боловсронгуй болгон хэрэгжүүлэх явдал билээ. Олон улсын эрх зүйн хэм хэмжээнд Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай Пакт зэрэг товчхондоо олон улсын Хүний эрхийн Биллд хүний үндсэн эрх, эрх чөлөөг хангахын зайлшгүй шаардлагыг заасан байдаг ба Монгол улсын Үндсэн хуульд иргэн бүр хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохиролыг нөхөн төлүүлэх эрхтэй гэж заасан байдаг. Иймээс өнөө цаг үед тулгамдсан асуудлуудын нэг болоод байгаа хүний сэтгэл санааны материаллаг бус гэм хорыг арилгах, нөхөн төлүүлэх эрх зүйн харилцааны талаар цогцоор нь авч үзэх шаардлага тулгамдаж байна.

Энэ асуудал нь цаашлаад хүний эрх, эрх чөлөөтэй холбогдож туйлын их анхаарал татаж байгаа хэдий ч одоогоор манайд төдийлөн нухацтай судалсан, хууль тогтоомжинд нарийвчлан тусгасан зүйл бага байгаа юм. Үүний учир материаллаг бус гэм хорыг арилгах, нөхөн төлүүлэх тооцох аргыг тогтоох зорилготойгоор энэхүү сэдвийг хөндөн авч үзлээ.

Үндсэн хэсэг

Бид Монголын хууль эрх зүйн орчинд сэтгэл санааны хохирлыг тооцох тухай зүйл, заалтууд байхгүй харин гадаадын зарим улс орнууд сэтгэл санааны хохирлыг шийдэх хууль, эрх зүйн орчинтой гэсэн таамаглал дэвшүүлээд энэхүү судалгааны хүрээнд /content analysis/ буюу агуулгад дүн шинжилгээ хийх аргыг ашиглан хууль зүйн доктор Ш.Үнэнтөгс "Сэтгэл санааны гэм хорын тухай ойлголт буюу гүтгэлэг, нэр төр гутаах асуудлын талаарх эрх зүйн зохицуулалт" нийтлэл, засгийн газрын мэдээ сонин, Австрали болон Их Британы хууль зүйн зохицуулалт, Монгол улсын "Эрүүгийн хууль", "Иргэний хууль", "Сэтгэц эрүүл мэндийн тухай хууль" бусад орны "Сэтгэц эрүүл мэндийн тухай хууль"-д дүн шинжилгээ хийлээ.

Мөн сэтгэл санааны хохирлыг гадаадын зарим улс орнууд хэрхэн хууль тогтоомжиндоо оруулсан байдгийг тодруулах гэж зарим орнуудын “Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль”-г судалсан билээ.

Солонгос улс

- Солонгосын засгийн газраас эрүүл мэндийн салбарын нийт төсвийн 6%-ийг сэтгэцийн эрүүл мэндэд зарцуулдаг. Үүний 31%-ийг сэтгэцийн эрүүл мэнд ба сэтгэцийн эмнэлгүүдэд зарцуулдаг.
- Нийт хүн амын 4% сэтгэцэт нөлөөт эм бэлдмэл хэрэглэх боломжтой. Солиорлын эсрэг эмчилгээний төлбөр 8071 вон, сэтгэл гутралын эсрэг эмчилгээний төлбөр 8020 вон бөгөөд эдгээр нь өдрийн цалингийн 29% - тай тэнцэнэ.
- Өдрийн дундаж цалин 27840 вон байдаг. Сэтгэцийн бүх эмгэг, өвчнүүдийн төлбөр нийгмийн даатгалд тусгагддаг.

Чех улс

- Сэтгэцийн эмч нар даатгалынхаа хуулиар Европын холбооны журам, өвчлөл тус бүрт оноогдсон төлбөрийг эмчилгээний төлбөр болгон засгийн газраасаа авдаг.
- Сэтгэл зүйчид нь хоёр хэлбэрээр төлбөрөө авч болдог. Нэг бол үйлчлүүлэгчээсээ төлбөрөө авна. Эсвэл иргэдийнхээ эрүүл мэндийн даатгалаар сэтгэл зүйчид нь төлбөр авна.

Турк улс

- Туркийн засгийн газар, сэтгэлзүйн эрүүл мэндийг нэмэгдүүлэх ихэнх үйл ажиллагаагаа улсын сэтгэцийн эмнэлгүүдээр дамжуулж явуулдаг.
- Иймээс туркийн засгийн газар сэтгэцийн эрүүл мэндийн талаарх зорилтууддаа 2011 онд дараах зүйлүүдийг тусгасан болно. Нийгмийн сэтгэцийн эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээг явуулах, сэтгэцийн эрүүл мэндэд зарцуулж буй хөрөнгийг ихэсгэх, сэтгэл санааны хохирол болон сэтгэцийн эрүүл мэндийн эмчилгээний чанарыг сайжруулах гэх мэт үйл ажиллагаануудыг эрчимтэй явуулж эхэлсэн болно.

Орсын холбооны улс

- Сэтгэл санааны хохирлын тусламжийн төлбөрийн тухай уг хуульд дурдахдаа засгийн газар болон орон нутгийн захиргаанаас хангана гэсэн байна. Тодорхой үнэн дүн тусгагдаагүй.

Монгол Улсын Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн эрх зүйн орчин, түүний сул талыг дүгнэвэл:

- Сэтгэл судлаачийн ажиллах эрх зүйн орчны талаар дурьдсан боловч яг юу хийх нь тодорхойгүй, ажил үүргийн хувьд ойлгомжгүй.
- Сэтгэцийн урьдчилан сэргийлэх ажлын тухай хэн, ямар арга хэмжээ авах нь тодорхойгүй.
- Хүндээ, хүний сэтгэл зүйд анхаараагүй, хүндэрсэн хойно нь эмээр эмчлэх, хэвтүүлэх, торгоох талаар илүү тусгасан.
- Төрийн байгууллагууд шаардлагатай бол сэтгэлзүйн хувийн төвүүд, чөлөөт ажиллагч сэтгэлзүйчтэй хэрхэн хамтарч ажиллах болон төрөөс баримталж буй сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуультай уялдан ажиллах тухай арга хэмжээ аваагүй зэрэг болно.

Гадаад орны сэтгэцийн эрүүл мэндийн хууль нь Монгол улсын Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулиас давуу зүйлийг нь бид ийнхүү судалж

үзлээ. Иймд Монгол улсын Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулинд эрүүл мэндийн даатгалаараа сэтгэл зүйн зөвлөгөө авдаг, сэтгэл зүйчид ханддаг үйлчилгээг нэвтрүүлэх шаардлагатай байна.

Нийслэлийн төвийн 6 дүүргийн 1999-2001 оны хооронд нэхэмжлэл гаргасан мөнгөн дүнгийн дээд доод хэмжээ²².


Нийслэлийн 6 дүүргийн 1999, 2000, 2001 оны хооронд хариуцагчаас нэхэмжилсэн мөнгөний дээд, доод, дундаж хэмжээ, мөн нэхэмжлэлийг хангасан шүүхийн шийдвэрийн эд хөрөнгийн бус гэм хорын хэмжээг тогтоосон доод болон дээд, дундаж хэмжээг хүснэгтээр үзүүлэв.

1	Хаанаас тогтоосон /мөнгөн дүн/	Доод хэмжээ	Дундаж хэмжээ	Дээд хэмжээ
2	Нэхэмжлэгчийн нэхэмжилсэн мөнгөн дүн	100000 төг	2-30 сая	400 сая төг
3	Шүүхийн шийдвэрээр хариуцагчаас гаргуулахаар тогтоосон мөнгөн дүн	42000 төг	200000-500000 төг	1500000 төг

Энэхүү хүснэгттэй жишиж үзвэл Их Британи улсад бага зэргийн сэтгэл санааны хохирлыг /доромжлол, үг хэллэг / 1290- 4900 фунт стерлингээр үнэлдэг байна. Харин дунд зэргийнх /гүтгэлэг, гүжирдэл/ бол 4.9 - 45 мянга, хүнд зэргийн сэтгэл санааны хохирол /сэтгэлийн хямрал, амь нас/ учирсан хэмээн үзвэл 45-96 мянга хүртэлх фунт стерлингээр үнэлж, тооцдог аж.

Улсын дээд шүүхээс хийсэн нэхэмжлэл гаргагчдын төрөл ойлголтын судалгаа²³.

Улсын дээд шүүхээс 1999-2004 оны хооронд хийсэн судалгаанаас харахад шүүхэд хандсан сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлүүлэх талаарх нэхэмжлэлүүд хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасныг шүүхээс хэрэг хянан хэлэлцээд тогтоосон атлаа тухайн хүнд гэм хорын хохирол учраагүй гэж дүгнэж, энэ талаар нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон зөрүүтэй шийдвэрүүд олонтаа гаргасан байдаг байна.



Гэм хор нь нэлээд өргөн хүрээтэй ухагдахуун бөгөөд эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус гэж хуваагдана. Эд хөрөнгийн гэм хорын мөнгөн үнэлгээг хохирол гэнэ. Харин эд хөрөнгийн бус гэм хор гэж бусад этгээдийн хууль бус үйлдлийн улмаас учирсан зан суртахууны, сэтгэл санааны шинжийг

²² Ш.Жанцан.“Хууль зүйн сэтгэл судлал”.УБ.,2006

²³ “Хууль Зүйн Үндэсний Хүрээлэн”.2006

агуулсан бие махбодийн зүдгүүр шаналал гэж тодорхойлдог. Өөрөөр хэлбэл хохирогчоос зөрчигдсөн эрхээ сэргээхэд буюу эрх зөрчигдөхөөс өмнөх байдалд эргүүлж оруулахад шаардагдах зардал болон эрх зөрчигдөсний улмаас алдсан орлогыг хохирол гэж тодорхойлдог бол эдийн бус сэтгэл санааны гэм хор гэж эрх зөрчигдөсний үр дагавар /өвчин, сэтгэлийн шаналал зэрэг/ юм. Тэгэхээр гэм хор, хохирол гэсэн ойлголтуудыг яг ижил ойлголт гэж авч үзэх нь тийм ч оновчтой биш байна.

Аливаа гэмт хэрэг, зөрчил нь нийгмийн сөрөг үзэгдэл, хүний нийгэмд аюултай гэмт зан үйл болохын хувьд хуулиар хамгаалсан нийгмийн эрх, ашиг сонирхолд халдан нийгэмд аюултай хор уршиг учруулах нөхцлийг бий болгодог ба тэрхүү учруулсан буюу учруулж болох байсан хор уршгаас гэмт хэргийн нийгмийн хор аюулын хэр хэмжээ шалтгаална.

Гэмт хэргийн хор уршиг бол нийгэмд аюултай хууль зөрчсөн, гэм буруутай зан үйлийн эцэст Эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашиг, түүний гадаад ертөнцөд гарсан өөрчлөлт, бий болсон үр дагавар бүхэн гэмт хэргийн хор уршиг болохгүй. Учир нь гэмт гэмт хэргийн хор уршиг бол гэмт эхэрг үйлдсэний үр дүнд гадаад ертөнцөд гарсан өөрчлөлт төдий биш харин гэмт хэргийн заавал байх шинж болгон хуульчилсан үр дагавар юм.

Гэмт хэргийн хор уршгийг түүний шинж чанараас хамааран:

1. Материаллаг хор уршиг гэдэг нь хүний амь нас, эрүүл мэнд, өмчлөх эрх зэрэг нийгмийн харилцаанд учирсан илрэх гадаад хэлбэр бүхий бодит материаллаг шинжтэй хор уршгийг хэлнэ.
2. Материаллаг бус хор уршиг гэдэг нь хүний нэр төр, алдар хүнд, нийгмийн ёс суртахуун, төр, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал гэх мэт нийгмийн материаллаг бус эрх ашиг сонирхолд учруулсан хор уршгийг хэлнэ.

Үүнээс үндэслэн хэлэхэд сэтгэл санааны гэм хорыг манайд гэм хорын тусгайлсан төрөл болгож авч үзэхгүй байгаа бөгөөд харин эдийн бус гэм хорыг нөхөн төлүүлэхэд харгалзан үзэх шалгуур болгохоор хуульчилсан нь ажиглагдаж байна.

Бид энэхүү илтгэлээр материаллаг бус гэм хорын нэг хэсэг болох бие эрхтэний болон сэтгэцийн хохирол, цаашлан амьдралын баяр баясгалан байхгүй болох, стресс нервийн асуудлын хохирлыг хэрхэн арилгах талаар уг сэдвийг бэлтгэх явцдаа контент анализийн аргыг ашиглаж хууль зүйн ухааны доктор Ш.Үнэнтөгс “Сэтгэл санааны гэм хорын тухай ойлголт буюу гүтгэлэг, нэр төр гутаах асуудлын талаарх эрх зүйн зохицуулалт” нийтлэл, “Багш сонсогч, суралцагчдын эрдэм шинжилгээний бүтээлүүдийн эмхтгэл”, “Иргэний хууль”, “Сэтгэцийн эрүүл мэндийн хууль” зэрэг материалуудтай танилцаж, агуулгын дүн шинжилгээ хийлээ.

Монгол улсын Үндсэн хуульд иргэн бүр хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохиролыг нөхөн төлүүлэх эрхтэй гэж заасан байдаг. Иймээс өнөө цаг үед тулгамдсан асуудлуудын нэг болоод байгаа хүний сэтгэл санааны материаллаг бус гэм хорыг тооцох, арилгах, нөхөн төлүүлэх эрх зүйн харилцааны талаар цогцоор нь

авч үзэх шаардлага тулгамдаж байна. Тухайлбал “Хүний эрхийн үндэсний комисс”-ын гишүүн Н.Ганбаярын өнөөдөр сонинд өгсөн ярилцлагаас:

-Сэтгүүлч: Сэтгэл санааны хохирол барагдуулсан тохиолдол байгаа юу?

-Гишүүн: Байлгүй яах вэ. Гэхдээ ийм хохирлыг хуулийн дагуу мөнгөн дүнгээр тооцож олгох аргачлал манайд нэвтрээгүй. Тиймээс одоогоор тухайн шүүгчийн үзэмжээр л шийдвэрлэж байна. Иймээс гэмт хэргийн хохирогчийн сэтгэл санааны хохирлын хэмжээг тогтоох тодорхой аргачлал, эрх зүйн зохицуулалт үгүйлэгдэж байна. Хэмээн хэлсэн нь сэтгэл санааны хохирлыг тооцох, арилгах аргачлал өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль эрх зүйн актад дутагдаж байгаа нэгэн зохицуулалт мөн болохыг бататгасны илрэл юм.

Монгол улсад анх сэтгэл санааны хохирол буюу эдийн бус хохирлыг тооцох тухай 1994 оны “Иргэний хууль”-д заасан байдаг. Үүнээс хойш 2002 оны шинэчлэн найруулсан “Иргэний хууль”-д энэ тухай илүү боловсронгуй эд хөрөнгийн бус гэм хорыг арилгах гэсэн бие даасан зүйл оруулсан нь иргэн хуулийн этгээдэд хөрөнгийн бус эрх ашгийг хамгаалах чухал заалт болсон юм.

Гэвч өнөөдөр гарч буй шүүхийн шийдвэрүүдэд сэтгэл санааны хохирлыг голчлон мөнгөн хэлбэрээр хуулийн этгээдэд хариуцлага ноогдуулж байгаа нь хохирогчийн эрүүл мэнд, сэтгэл санааны гэм хорд учирсан хохирлыг бүрэн арилгаж чадахгүй байна.

Хэдийгээр ийнхүү хохирлыг нь мөнгөн хэлбэрээр үнэлж, барагдуулж буй мэт боловч анзаарч үзвэл учир дутагдалтай асуудлууд энд бий. Шүүхээс нэр төр гутаах, хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ нэхэмжлэгчид эрүүл мэнд сэтгэл санааны гутрал бий болсон эсэх, ашиг орлогын тооцоо, гэм хорын хохирлын хэмжээ, үг хэллэгийн тайлбар зэрэг тусгай мэдлэг шаардсан асуудлыг хэрхэн шийдвэрлэх бололмжийг нарийвчлан зохицуулах нь зүйтэй юм.

Түүнчлэн Австрали, Их Британи зэрэг оронд шүүхээс үндсэн дөрвөн элементийг хангагдсан тохиолдолд хэн ч нэр төрөө сэргээх нэхэмжлэл гаргаж болдог ба тухайн гаргаж буй нэхэмжлэлийг хүлээн авдаг. Уг шаардлагад:

- Бодит байдалд нийцээгүй мэдээлэл түгээсэн бол,
- Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бол,
- Тодорхой байгууллага, хувь хүний нэр зааж, танигдахаар бичсэн, дүрсэлсэн бол,
- Бодит баримт, болсон үйл явдал дээр тулгуурлаагүй бол гэсэн үндэслэлтэй байх ёстой.

Харин Монгол Улсад нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлох аргачлалд:

- Мэдээ тараасан арга
- Тараасан арга хэрэгсэл
- Тархсан хүрээ
- Сэтгэлийн шаналал үр дагавар
- Хувийн үнэлгээ зэргээр тооцож үнэлдэг байна.

Монгол Улс сэтгэл санааны хохирлыг амь нас, эрүүл мэнд болон эд хөрөнгөд учирсан хохиролтой хамтад нь тооцож олгодог. Өөрөөр хэлбэл, сэтгэл санааны хохирлыг "дагалдах хэрэгсэл" болгожээ. Гэтэл дэлхийн ихэнх орон сэтгэл санааны хохирлыг тусад нь тооцож, үнэлдэг тогтолцоонд шилжжээ. Тухайлбал, БНСУ-д сэтгэл санааны хохирлыг тооцох тусгай аргачлалтай. БНСУ-д хохирогчид сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөр олгоод зогсохгүй

хохирогчийн гэр бүлийн гишүүн бүрт нь тооцож өгдөг байна. Өөрөөр хэлбэл, хохирогчид үүссэн сэтгэл санааны тавгүй байдал гэр бүлийн гишүүдэд нөлөөлдөг хэмээн үзжээ²⁴.

Түүнчлэн сэтгэл санааны гэм хор учирсан гэх хүн буюу нэмжлэл гаргагч өөрийн хохирсон гэх үнэлгээгээ мөнгөн хэлбэрээр тооцон нэхэмжлэх, түүнийг нь шүүх хууль хяналтынхан хэрхэн үнэлэн тооцох аргачлал нэн хангалтгүй байгаа болно. Үүнээс шалтгаалан нэхэмжлэл гаргагчид өөрсдийн тооцолсноор буюу хатуухан хэлэхэд хүссэнээрээ нэхэмжлэлийн мөнгөн хэлбэрээ илэрхийлдэг гэхэд хилсдэхгүй байна²⁵. Товчхондоо, энэ хохирлын хэмжээг хэрхэн, яаж тооцож, барагдуулах талаар эрх зүйн зохицуулалт дутмагаас иргэд хохирлоо бодитой, бүрэн дүүрэн төлүүлэх эрхээ эдэлж чадахгүй үлдэж байна.

Шүүхээс сэтгэл санааны хохирлын хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ нэхэмжлэгчид эрүүл мэнд, сэтгэл санааны гутрал бий болсон эсэх, ашиг орлогын тооцоо, гэм хорын хохирлын хэмжээ, үг хэллэгийн тайлбар зэрэг тусгай мэдлэг шаардсан асуудлыг хэрхэн шийдвэрлэх боломжийг нарийвчлан зохицуулах нь зүйтэй ба гэм буруутай этгээдэд оноож буй эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлүүлэх хэмжээг тогтоох нийтлэг шалгуур байхгүй байгаа. Энэ нь шүүгч өөрийн итгэл үнэмшилдээ тулгуурлан шийдвэр гаргах боломжтойгоос гадна нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэг хүнд гэсэн ойлголтууд нь хоорондоо ялгаатай боловч шүүхийн практикт өөрөөр хэлбэл, шүүх, хариуцагч, нэхэмжлэгч нар эдгээр ойлголтыг төдийлөн анхаарч үздэггүй байна.

Дүгнэлт

Сэтгэл санааны хохирол гэдэг нь амь нас, эрүүл мэнд болон эд хөрөнгийн хохирлоос үүдэлтэй алдагдсан боломж юм. Тиймээс алдагдсан боломжийг алдахгүйн тулд холбогдох төрийн байгууллагууд анхааралдаа авах нь зүйн хэрэг биз ээ. Иймд бид энэхүү сэдвийг өнөөгийн нийгэмд тулгамдаж буй асуудлуудын нэг хэмээн авч үзэн сэдвийн хүрээнд агуулгад дүн шинжилгээ хийх аргыг ашиглан сэтгэл санааны хохирлыг арилгах талаар өгүүлсэн нийтлэл, ном зохиол, эрдэмтэн докторуудын судалгааны ажилд дүн шинжилгээ хийлээ.

Манай улсын хууль тогтоомжид сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлүүлэх талаар шууд заасан заалт байхгүй гэж болох юм. Иргэний хуулийн 511-р зүйлд энэ тухай хэсэгчилэн дурдсан байдаг боловч нэр төр, алдар хүнд, ажил мэргэжлийн нэр төр гэх ухагдхуунаар дуусаж байгаа нь сэтгэл санааны хохирлын талаарх гүйцэд ойлголтыг тусгаагүй байна. Бусад улс орнуудын эрх зүйн зохицуулалтад сэтгэл санааны хохирлыг тооцох аргачлалыг тусгайлан зааж оруулсан байдаг бөгөөд ОХУ, Турк, Чех, БНСУ зэрэг орнуудад энэхүү асуудлыг тооцох тухай “Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль”-даа зааж өгсөн байдаг.

Сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлүүлэх талаар манай хууль тогтоомжинд тодорхой зааж өгөөгүй байгаа нь хууль зүйн практикт уг зохицуулалтыг янз бүрээр тайлбарлах, ойлгож шийдвэрлэх тодорхойгүй байдлыг үүсгэх хандлага байна. Иймд бидний “Монголын хууль эрх зүйн орчинд сэтгэл санааны хохирлыг тооцох тухай зүйл, заалтууд байхгүй” гэх нэгдүгээр таамаглал батлагдаж байна. Мөн хоёрдугаар таамаглал буюу

²⁴ “Засгийн газрын мэдээ” сонин., 2017

²⁵ Хууль зүйн доктор Ш.Үнэнтөгс “Сэтгэл санааны гэм хорын тухай ойлголт буюу гүтгэлэг, нэр төр гутаах асуудлын талаарх эрх зүйн зохицуулалт”.УБ., 2015

“Гадаадын зарим улс орнууд сэтгэл санааны хохирлыг шийдэх хууль, эрх зүйн орчинтой” гэсэн таамаглал мөн батлагдаж байна.

Санал, зөвлөмж

Уг судалгааны үр дүнгээс үндэслэн, сэтгэл санааны хохирлыг тооцохтой холбоотой асуудалд шийдэл гаргах зорилгоор дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Сэтгэл санааны хохирлыг тооцох аргачлалыг “Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль”-д шинэ заалт оруулан өгч үүнд илүү дэлгэрэнгүй нөхцөлийг оруулах;
2. Сэтгэл санааны гэм хор түүнээс үүссэн стресс, шаналал зэрэг сэтгэл зүйчийн хэрэгцээ үүссэн нөхцөлийг харгалзан эрүүл мэндийн даатгалаараа сэтгэл зүйн зөвлөгөө үнэ төлбөргүй авдаг, сэтгэл зүйчид ханддаг үйлчилгээг нэвтрүүлэх;
3. Бусдын нөлөөгөөр учирсан сэтгэл санааны гэм хорыг тооцох мөнгөн /нэгж/ үнэлгээг сэтгэцийн эмч болон тусгайлан олгосон эрхтэй сэтгэл зүйчид хамтран гаргаж нэхэмжлэгчийн хүлээн зөвшөөрсөн гарын үсгээр баталгаажуулснаар шүүх нэхэмжлэлийг хүлээн авдаг болох /Энэ тухай “Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулинд заалт оруулах/
4. Хохирогчид болон түүний гэр бүлд нийгмийн даатгалаас нөхөн төлбөр олгох барагдуулах; /тухай журам батлахаар хуульчилах ингэснээр хохирогчдийн сэтгэл санаа болон эдийн засгийн баталгааг хангах давхар ач холбогдолтой юм/
5. Сэтгэл санааны хохирол гэж чухам юуг хэлэх, юуг хамруулах талаар Улсын дээд шүүхээс албан ёсны тайлбар гаргах хэрэгтэй байна. Улмаар өнөөдрийн манай шүүхийн практикт сэтгэл санааны хохирлыг бага боловч арилгаж шүүхийн нэгдсэн дадал төлөвшин тогтох үндэстэй гэж үзэж байна.

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

КИБЕР ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

А.Амарсайхан

ДХИС-ийн ЦС-ийн Эрүүгийн эрх зүй, криминологийн
тэнхимийн ахлах багш, цагдаагийн дэд хурандаа

Г.Марал-Эрдэнэ

ДХИС-ийн ЦС-ийн 3512-р дамжааны
суралцагч, цагдаагийн ахлах дэслэгч

Удиртгал

Кибер гэмт явдлын хор уршиг, шалтгаан нөхцөл, дэлхийн чиг хандлага, цахим орчины талаарх тоон судалгаа энэ төрлийн гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах чадвар эзэмших, аливаа асуудалд шинжлэх ухаанчаар хандах, зөв үнэлэлт, дүгнэлт өгөх хандалага төлөвшүүлэхэд чиглэдэг.

Монгол Улсын Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос гаргасан судалгаагаар монгол улсад 2017 оны байдлаар давхардсан тоогоор 2,656,100 интернет хэрэглэгч байгаагаас 30 сүлжээний хэрэглэгч 90.97 хувийг эзэлж, нийт хэрэглэгчийн хамрах хүрээ 86.7 хувь нь улаанбаатар хотод, 10,3 хувь нь аймгуудад, 2,9 хувь нь сумдад, интернэт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 59 аж ахуй нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байна.²⁶

Үндсэн хэсэг

Интернэт хэрэгслийг мэдээллийн эх сурвалж болгон ашиглах, түүнчлэн олон нийтийн сүлжээ ашиглаж үзэл бодолоо илэрхийлэх, аливаа зүйлийг нийтлэх болсон. Дээрх судалгаанаас үзвэл хүмүүст уламжлалт мэдээллийн хэрэгсэл ашиглахаас илүүтэй олон нийтийн сүлжээг илүү өргөн ашиглаж өөрийн үзэл бодол байр сууриа илэрхийлэх болсон. Тухайлбал цахим хуудас, ютубе, фэйсбүүк, твиттер ашиглаж үзэл бодол санал сэтгэгдлээ /коммент/ бичдэг болсон. Энэ нь нэг талаас иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх хэдий ч нөгөө талаас худал мэдээлэл тараах бусдын нэр хүндэд халдаж гүтгэх, доромжлох явдал гарснаар иргэдийн эрх зөрчигдөх явдал гарч байна. Иймд цахим орчин дахь энэ төрлийн зөрчил хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь цаг үеийн хэрэгцээ, шаардлага болоод байна.

Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд мөнгө угаах, хүний наймаа хар тамхины болон цахим гэмт хэрэг зэрэг шинэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь мөн л цаг үеийн нөхцөл байдал шаардаж байна гэж үзэх үндэслэлтэй юм.



Ю
уны өмнө
цахим
орчин
дахь гэмт
хэргийн
тухай
ойлголты

г авч үзэхээс өмнө кибер гэмт хэргийн талаарх ойлголтыг товч авч үзэх нь зүйтэй юм. Кибер /cyber/ гэх нэршил нь кибернетик гэх үгтэй утга дүйх ба утгачлан тайлбарлавал нарийн тооцоолон бодох техник-технологийн туслалцаатайгаар мэдээлэл боловсруулан үйл ажиллгааг удирдах буюу залуур зүй /удирдахуйн тогтолцоо/ гэж ойлгогдоно. Энэ утгаараа Европийн холбооноос цахим орон зайг нийтэд нь кибер орчин гэж нэрлэж байхаар өргөн хүрээнд шийдвэр гаргаж хэрэгжүүлж байна.

Кибер гэмт хэргийн үндсэн асуудал нь компьютерын мэдээлэл, сүлжээний эсрэг гэмт хэрэг хамаарч байна уу, эсвэл компьютерын мэдээлэл сүлжээний тусламжтай үйлдсэн гэмт хэрэг хамаарч байна уу гэдэгт төвлөрдөг.

²⁶ Мэдээллийн эх сурвалж: <http://www.crc>.

Кибер гэмт хэргийн тухай конвенцийг боловсруулагчдын зүгээс дээрх хоёр шинжийг хамтатгасан байдлаар кибер гэмт хэргийг тодорхойлж түүнийг төрөлжүүлсэн байдаг. Үүнд:

- Компьютерын мэдээлэл, сүлжээний бүрэн бүтэн, нууцлагдсан хүртээмжтэй байдлын эсрэг гэмт хэрэг
- Тооцоолох төхөөрөмж ашиглаж үйлдэх гэмт хэрэг
- Интернэт дэх зохистой агуулгын эсрэг гэмт хэрэг
- Интернэт дэх оюуны өмчийн эсрэг гэмт хэрэг гэж дөрвөн төрөлд ангилдаг.

Цахим сүлжээ бий болж хөгжсөнөөр нийгмийн харилцааны шинэ орчин хэлж болох цахим орчинг бий болгосон. Цахим орчинг тодорхойлсон бүх нийтэд хүлээн зөвшөөрсөн нэгдсэн тодорхойлолт байхгүй ч энэ талаарх ойлголт чухал байдаг. Цахим орчинг /cyberspace/ интернэт, харилцаа холбооны сүлжээ, компьютерийн сүлжээ, процессор зэрэг мэдээллийн технологийн харилцан хамааралтай дэд бүтцийн сүлжээнээс бүрдэх дэлхий нийтийн орон зай гэж ойлгодог.

Цахим орчин орчин нь хүн төрөлхтний мэдлэг мэдээлэл харилцан солилцох хэрэгцээнээс үүдэлтэй харилцан холбогдсон компьютерын сүлжээ ба энэхүү сүлжээ нь дэлхий дахиныг холбосон байдаг. Үүний илрэл нь хүмүүс цахим сүлжээг мэдээлэл солилцох, дамжуулах, үзэл бодлоо зураг дүрсээр илэрхийлэхээс гадна зурвас болон сэтгэгдэл бичих зэргээр бие биетэйгээ харилцах талбар болгож байна.

Олон нийтийн сүлжээг хүмүүс үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх мэдээлэл солилцох хэрэгсэл болгон ашигладаг боловч бас үүгээр дамжуулан худал мэдээ тараах бусдыг доромжлох, гүтгэх үйлдэл гарч буй нь манай улсад төдийгүй дэлхийн улууудад тулгамдаж буй асуудал болоод байна.

Олон улсын жишгээс харахад олон нийтийн сүлжээг ашиглаж хүний нэр төр, алдар хүндэд халдах доромжлох гүтгэх үйлдлийг гэмт хэрэг “мөн”, “биш” гэх маргаан дагуулах болсноор өөрийн улсын үнэт зүйл, онцлог байдалдаа тулгуурлаж уг харилцааг хууль тогтоомжоор зохицуулах болжээ.

Манай улсын хувьд зарим эрдэмтэн судлаачид гэмт хэрэг биш иргэний хуулиар зохицуулах боломжтой гэж үзэж байхад нөгөө хэсэг нь худал мэдээ тараах, хүний нэр төр, алдар хүндэд халдах үйлдлийг гэмт хэрэг гэж үзэж эрүүгийн хуулиар зохицуулах ёстой гэж үздэг.

Олон нийтийн цахим сүлжээг ашиглаж бусдын алдар хүндэд халдаж гүтгэх, доромжлох худал мэдээ тараасан тохиолдолд цахим гэмт хэрэгт тооцож болно гэж зарим судлаачид үздэг. Тухайлбал судлаач Л.Галбаатар кибер гэмт хэргийн тухай конвенцид зааснаас бусад цахим гэмт хэргийг “цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг” гэж үзнэ гэсэн байр суурьтай байна.

Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө эдлэхдээ үгээрээ дамжуулж бусдыг гүтгэх доромжлох нь бусдын эрх чөлөөг зөрчиж байгаа үйлдэл нь бодитой юм. Үүнийг хууль зүйн шинжлэх ухааны үүднээс тайлбарлах юм бол бүх гэмт хэрэгт дөрвөн шинж байж шийтгэдэг. Энэ хоёр гэмт хэрэгт хэлбэрийн өөрөөр хэлбэл гүтгэсэн, доромжилсон байх юм бол мөрдөн байцаалтын аргаар тогтоох ёстой. Гэмт хэрэгт тооцож буй үндэслэл нь тухайн хүний өөрийнх нь үйлдэл, сэдэл саанаатай нь холбоотой байдаг.

Иймд цахим орчинд худал мэдээ, мэдээлэл тараах, бусдыг доромжлох, гүтгэх үйлдлийг иргэний буруу гэхээс илүүтэй гэмт хэргийн үндсэн шинж, сэдэл учруулсан хор хөнөөлийг нарийвчилан тодорхойлж гэмт хэрэг гэж үзэж тусгайлсан хуулиар зохицуулахыг санал болгодог хэсэг байхад, нөгөө хэсэг нь үүнийг Үндсэн хууль, Иргэний хуулиар зохицуулах, эсхүл хувь хүний өөрийнх нь соёлын хэмжүүр болгох, мэдээлэл хүлээн авах боловсрол олгох тал дээр илүүтэй анхаардаг байна.



Phishing- гэдэг нь албан ёсны вэб сайт, и-мэйл чат гэх мэтээр харагдаж танд ямар нэгэн өгөөш бүхий мэдээлэл илгээн таны нэвтрэх нэр нууц үг, бусад хэрэгцээт үнэ цэнэтэй.

Та өөрийгөө кибер гэмт хэргийн хохирогч болох эрсдэлээс хамгаалах чадвартай байхаас гадна гэр бүлээ тийнхүү хамгаалж байх нь зүйтэй. Учир нь та өөрийн хувийн мэдээллийг цахим орчинд хамгаалах буюу зохистой хэрэглэж байж болох ч таны мэдээлэл танай гэр бүлийхэнд байгаа тул тэд түүнийг эрсдэлд оруулж болзошгүй юм.

Кибер гэмт хэргийн аюулаас өөрийгөө болон гэр бүлээ хамгаалахад баримтлах гол зүйл бол кибер гэмт хэрэг үйлдэх этгээдтэй адилаар бодож сэтгэх явдал юм. Өөрөөр хэлбэл, кибер гэмт хэрэгтний голчлон хэрэглэдэг арга хэрэгслийн эсрэг арга хэмжээ авах нь зүйтэй юм. Кибер гэмт хэргээс урьдчилан ²⁷сэргийлэх дараах нийтлэг арга түгээмэл байна. Үүнд:

- Компьютерын системээ шинэчилж байх;
- Кибер гэмт хэрэгтний халдлагын зүйлд нь таны компьютерын цоорхойтой буюу систем байдаг тул түүнийгээ шинэчилж байх;
- Системийн тохиргоогоо хамгаалах;
- Бусад этгээд таны компьютерын системийн тохиргоог өөрчлөх буюу аюулгүй байдлыг хангасан тохиргоог алдагдуулахаас болгоомжил;
- Нэвтрэх үг буюу нууц үгээ сайжруулж хамгаалах;

Хэргэлэгчийн нэр, нэвтрэх үг, дансны нууц дугаар зэрэг нь аливаа онлайн гүйлгээ, төлбөр тооцоо болон таны хувийн мэдээлэлд байнга хэрэглэгддэг. Иймд үсэг тоо бусад тэмдэгт оролцуулсан 8-аас доошгүй тэмдэгтээр нэвтрэх нууц үгээ сайжруулж, түүнийгээ гурван сар тутамд тогтмол

²⁷ <https://www.facebook.com/cybercrimemongolia/>

сольж хэвшээрэй. Мөн олон вэб сайтад нэг л нэвтрэх үг ашиглах нь таныг эрсдэлд оруулах тул хэрэглэдэг үйлчилгээ вэб сайт бүртээ өөр нэвтрэх үг ашиглах хэрэгтэй.

- “Галт хана”- аа асаалттай байлгах /*firewall*/

“Firewall” буюу галт хана гэх програм нь таны компьютерийг гэмт этгээдүүд эвдэх, мэдээлэл устгах, нэвтрэх үг, бусад нууц мэдээлэл хулгайлахаас хамгаалдаг.

- Вирусны эсрэг програм суулгах буюу түүнийгээ шинэчилж байх

Вирус нь компьютерийн хэрэглэгчийг мэдээгүй байхад түүний мэдээллийг устгах буюу хулгайлах, бусад байдлаар эрсдэлд оруулдаг тул заавал вирусны эсрэг програм суулгаарай.

- Хувийн мэдээлэл хамгаалах

Өнөөдөр ихэнхи оннлайн үйлчилгээг ашиглахын тулд нэр, гэрийн хаяг, утсаны дугаар, имэйл хаяг зэрэг хувийн мэдээллээ хуваалцах, түгээх нөхцөл бүрдсэн байна. Эргэлзээтэй буюу хэлний дүрмийн алдаа ихтэй, цахим шууданд хариу өгч болохгүй, мэйлд хариу өгөхийн өмнө цахим шуудангийн хаягийг шалгаж байх зүйтэй. Хувийн мэдээлэл шаардсан цахим хуудасны домэин нэрийн урд ногоон өнгийн цоожны дүрс буюу <https> харагдахгүй байвал та түүнийг ашиглахаас зайлсхийх зүйтэй.

- Вэб сайтын нууцлалын байдлыг хэвлэн авч, анхааралтай унших

Ихэнхи вэб сайт үйлчилгээний нөхцөл болон нууцлалын бодлогоо бичгээр танилцуулдаг. Үүнийг анхааратай унших нь таны хувийн мэдээлэл ямар замаар хэнд хүрэх, эс хүрэхийг мэдэхэд чухал юм. Нөгөө талаар тухайн вэб сайтын үйлчилгээ таныг эрсдэлд оруулах болбол црып хэвлэж авсан нууцлалын бодлого, үйлчилгээний нөхцөл нь таны эрхийг хамгаалахад чухал нотлох баримт болох юм.

- Санхүүгийн мэдээлэл, дансны хуулга тогтмол хянах

Таны банкны дансны дугаар, нэвтрэх үг, зээлийн картын пин код, нэгний гарт орсон юм биш биз. Таныг мэдээгүй үед ч юмуу таньд анзаарагдахгүйгээр таны данснаас мөнгө аваад байж мэдэх тул орлого зарлагын мэдээллээ тогтмол хянаж байх нь санхүүгийн луйвар, залилангаас сэргийлэх, энэ тал дээр банкнаас аюулгүй байдлын дэмжлэг авахад хэрэгтэй.

- Үнэгүй зүйл хавханд л байдаг буюу танд маш их аз тохиоход эргэлзэж байх

Хэн ч АНУ-ын цэргийн албан тушаалтнаас их хэмжээний мөнгө хүлээн авах, мэйл хаягийн өгөгдлийн сангаас санамсаргүйгээр сонгогдож, лотанд их хэмжээний мөнгө хожихгүй. Ийм утга учир бүхий зурвас мэдэгдлүүд нь ихэнхдээ хуурагдсандаа итгэхгүй байгаа хүмүүсийн “хүчин чармайлт”-аар цагдаад мэдэгдэлгүй өнгөрч, өөр хэн нэгнийг залилахаар тарсаар байдаг.²⁸

- Компьютероо унтраах

Хэрэглээгүй үедээ компьютероо унтрааж байх нь халдагч этгээдийн хууль бус холболтыг зогсоох үр дүнтэй нэг арга юм. Дээр дурьдсан аргууд нь одоогийн төвшинд санал болгож буй аргууд бөгөөд кибер гэмт хэрэгтнүүдийн сэдэл, арга мэх улам хүчтэй болж байгаа тул дараах үйлдлийг хэвшил болгох.

²⁸ <https://www.facebook.com/cybercrimemongolia/>

Дүгнэлт: Мэдээлэл технологи хурдацтай хөгжихийн зэрэгцээ “шинэ” харилцааг бий болгож байна. Үүний илрэл нь цахим мэдээлэл, харилцаа, орчин, орон зайг бий болгож байгаа явдал юм.

Монгол улсын хувьд сүүлийн жилүүдэд олон нийтийн сүлжээ ашиглаж /цахим хуудас, фэйсбүүк, твиттэр, ютубе зэрэг/ аливаа зүйлийг нийтлэх үзэл бодлоо илэрхийлэх орон зай нэгэнт бүрдсэн. Түүнийг ашиглан цахим төхөөрөмж, мэдээллийн хамгаалалттай сүлжээнд хууль бусаар нэвтрэх тусгай програм, техник хэрэгсэл ашиглан бусдын хувийн мэдээллийг олж авах байгууллагын системд нэвтрэх бусдын картны мэдээллийг хуулбарлах авах зэрэг гэмт үйлдлүүдийн тоо нэмэгдэж байна. Эдгээр үйлдлүүдээс харахад иргэдийн цахим орчны талаарх мэдээ мэдээлэл дутмаг байдлаас цахим төрлийн гэмт хэрэг гарах шалтгаан болж байна.

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛД ҮЗҮҮЛЭХ ХОТЫН АМЬДРАЛЫН НӨЛӨӨ

(Хагархай цонхны онолын жишээн дээр)

Э.Дашгаадан

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн
багш, цагдаагийн ахлах дэслэгч

Товч агуулга

Гэмт явдал судлалд маш их анхаарал татдаг онолуудын нэг нь “Экологийн онол” буюу орчин тойрны нөлөөллөөс гэмт хэрэгтэн, хохирогчдын түвшин өөрчлөгдөх магадлалтай ба биеийн болон нийгмийн онцлогийг танин мэдэх нь гэмт явдлын шалтгаан нөхцлийг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм. Жэймс Вилсон ба Жорж Келлинг 1982 онд Атлантик сэтгүүлд хэвлүүлсэн нийтлэлд жижиг төрлийн гэмт хэргүүд эсхүл зөрчлүүдтэй тэмцэх нь бусад хүнд гэмт хэргүүдийн түвшинг багасгана гэсэн санааг дэвшүүлсэн нь олны анхаарлыг татсан юм.

Хагархай цонхны онолын ерөнхий агуулга нь: “Байшингийн нэгэн хагархай цонхыг засахгүй бол байшинг эзэнгүй гэж хүмүүс ойлгож эхлэх ба бусад цонхыг ч мөн адил хагалахыг хүссэн хүмүүс хагална. Хэсэг хугацааны дараа байшинд бүтэн цонх үлдэхгүй..”

Энэ нийтлэлийн зорилго нь Хагархай цонхны онол, хотжилт болон нийгмийн асуудал, гэмт явдалд хэрхэн нөлөөлдгийг тодорхойлох, судалгааны үр дүнг хэрхэн ашиглах талаар товч авч үзлээ.

Түлхүүр үг: Хагархай цонхны онол, криминологи, гэмт явдал, хотжилт, зөрчил

Оршил

Хотжилт нь нийгмийн хөгжлийн үр дүнд бий болдог үзэгдэл бөгөөд амьдралын хэв маягт сөргөөр нөлөөлдөг парадокс юм.²⁹ Энэ өгүүлэлээр хагархай цонхны онолын үзэл баримтлалд тулгуурлан хотын амьдралын асуудлуудын

²⁹ Ackerman, W. V. (1998), "Socioeconomic correlates of increasing crime rates in smaller communities"

томоохон хэсэг болох аюулгүй байдал ба гэмт явдлын нөлөөллийг тодорхойлохыг зорилоо.

Сүүлийн жилүүдэд төв суурин газар луу шилжих хөдөлгөөний үр дүнд нийгэм эдийн засаг, улс төрийн асуудал, нийгмийн ангийн ялгаа зэрэг асуудлууд хот суурин газрын аюулгүй байдал, гэмт явдал түүнтэй тэмцэх системд хэрхэн нөлөөлж байгаа нь бидний анхаарлыг татаж байна. Өөрөөр хэлбэл гэмт явдалтай тэмцэх асуудалд хот суурин газрын мэргэжилтнийг хамруулан ажиллуулах шаардлага тулгарч байна.

Хотжилт болон хүмүүсийн амьдарч буй орчин гэмт явдалд нөлөөлөх нь шинэ ойлголт биш юм. Тухайлбал гэмт явдал судлал, криминологид “Нийгэм экологийн онол” хэмээх үзэл баримтлал 19 дүгээр зуунаас эхлэлтэй юм.

Хотжилт нь гэмт хэргийн түвшинг нэмэгдүүлдэг хэмээн анх Tonnies, Durkheim, Burkley болон Tarde гэсэн нийгмийн шинжлэх ухааны эрдэмтэд судлаачид үзсэн. Хотжих үзэгдэл нь нийгмийн хяналтын тогтолцоог бууруулдаг. Учир нь томоохон хотуудад амьдарч буй хүмүүс ихэвчлэн бие биенээ танидаггүй. Тэгснээр нийгмийг хянах механизм алдагдаж, гэмт явдал бий болох, өсөхөд тохиромжтой орчин бий болдог.³⁰

Чикагогийн их сургуульд 1892 онд Нийгэм судлалын тэнхим байгуулагдаж 20-р зууны дунд үе хүртэл нийгэм социологийн хамгийн үр нөлөөтэй байгууллага болжээ. Энд цугласан судлаач эрдэмтдийг “Чикаго онолтнууд” гэгдэх болжээ.

Чикаго онолд хоёр үндсэн үзэл баримтлал байдаг байсан. Нэг дэх нь гэмт явдлын стстистик, тухайн хот суурин газрын хүн амын нийт тоонд харьцуулан судалгаа хийх юм. Хоёр дахь нь амьдралын хэв шинж, хэрэг явдлыг судлах арга зүй юм.

Үндсэн хэсэг

Криминологийн сүүлийн 20-30 жил экологи болон хүрээлэн буй орчин нь криминологийн суурь салбар болон хөгжсөнийг бид харж байна. Энэ сэдвийн хүрээнд ялангуяа “Хагархай цонх” /Broken windows/ гэх томъёолол анхаарал татдаг. Хагархай цонх гэх ойлголтыг улс төр судлаач Жэймс Вилсон болон гэмт явдал судлаач Жорж Келлинг нар Атлантик сэтгүүлд 1982 онд ижил нэрт өгүүллээр нийтлүүлжээ. Энэхүү өгүүллийн гол санаа нь хот суурин газрын тодорхой хэсэгт төрийн үйл ажиллагааг хандуулсанаар нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд үр нөлөө гарч болох юм гэсэн санааг дэвшүүлсэн байна. Өөрөөр хэлбэл хөнгөн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцсэнээр хүнд хохиролтой гэмт хэргүүд гарахаас сэргийлнэ гэсэн санааг агуулжээ.

Вилсон болон Келлинг нар гэмт хэрэгтэй тэмцэх хамгийн үр дүнтэй арга бол эхлээд хэв журмыг сахиулах явдал гэж үзжээ. Хот суурин газар, гудамж талбай эмх замбараагүй байх нь гэмт явдал үүсэн гарах орчин нөхцлийг бий болгодог гэдгийг тайлбарлахын тулд хагархай цонх гэх зүйрлэлийг хэрэглэж байжээ.

³⁰ Cahill, Meagan Elizabeth (March 2005), "Geographies of Urban Crime: An Intraurban study of crime in Nashville, TN; portland, oR; and Tucson", AZ; A Dissertation Submitted to the Faculty of the Department of Geography and Regional Development In partial Fulfillment of the Requirements For the Degree of Doctor of Philosophy in the Graduate College The University of Arizona

Хотын нэгэн байшингийн хагархай цонх нь түүний дэргэдүүр өнгөрч байгаа хүмүүст энд хэн нэгэн байдаггүй, энэ байшинг анхаарч үзэх хүнгүй гэсэн өнгө төрхийг бүрдүүлдэг. Тэр хавиар тоглож байгаа хүүхдүүд чулуу шидлэхэд хэд хэдэн цонх дахин хагарах ба хэсэг хугацааны дараа түүгээр өнгөрөх хүмүүс энэ гудамжинд хэн нэгэн анхаарал хандуулдаггүй юм байна гэсэн бодол төрүүлнэ. Удалгүй тэр гудамжинд биеэ үнэлэгч, хар тамхи наймаалагч, тэнүүлчид, дээрэмчид, гэмт хэрэгт холбогдож болзошгүй этгээдүүд үүрлэж эхэлнэ.³¹ Товчхондоо “Хагархай цонх” онолоор жижигхэн эмх замбараагүй байдал нь илүү том замбараагүй байдлыг бий болгосоор томоохон гэмт хэргүүд бий болох нөхцөл байдалд хүргэдэг гэсэн үзэл санааг илэрхийлдэг.

Proactive policing хэмээн хэрэглэгдэж ирсэн энэхүү ойлголт нь сүүлийн 30-40 жилд аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд гол байр суурь болсон. Ингээд цагдаа болон аюулгүй байдлыг хангах нь зөвхөн үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх бус үйлдэгдэхээс өмнө нь сэргийлэх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шинэ арга болсон юм.

Хагархай цонхны онолыг анх Нью-Йорк хотын зорчигч тээврийн газарт хэрэгжүүлсэн. Галт тэрэгнүүдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай сэрэмжлүүлэг наах, эргүүл хийх, жижиг зөрчлүүдийг ч гэсэн орхилгүй нэг бүрчлэн илрүүлэн шийдвэрлэснээр гэмт хэргийн түвшинг буулгаж чадсан.

Ийм байдлаар бусад олон нийтийн газрууд, гудамж талбайд нийтийн хэв журам сахиулах, хөнгөн гэмт хэрэг, зөрчлүүдийг цаг алдалгүй шийдвэрлэх, цаашлаад гарч болох бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлнэ гэсэн үзэлд тулгуурлан Америкийн бусад хотууд цагдаа, шүүх, прокурорын хамтын ажиллагааг идэвхижүүлсэн ба үр дүн нь илт харагдаж байлаа.

Гэмт хэргийн түвшин өндөрт тооцогддог АНУ-д 2010-аас 2017 онд хүч хэрэглэж үйлдэгддэг гэмт хэрэг 19%-иар буурсан бол өмчийн эсрэг үйлдэгддэг гэмт хэрэг улсын хэмжээнд 21% буурсан байна.

Атланта, Бостон, Чикаго, Лос Анжелес, Миами болон Сан Диэго зэрэг мужуудад нийт гэмт хэргийн түвшин 33-53%-иар буурсан үзүүлэлттэй байдаг. Үүний зэрэгцээ хамгийн анх энэхүү арга барилыг хэрэглэж эхэлсэн Нью-Йорк хотод 2010-2016 онд хүч хэрэглэж үйлдэгдэг гэмт хэрэг 44%-иар, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 35%-иар буурсан үзүүлэлттэй байсан байна.³²

Бүгд найрамдах Турк улсад 1950-аад оноос хүн амын өсөлт хурдацтай нэмэгдэж, газар тариаланд техник тохнологийн дэвшлийг нэвтрүүлснээр тариалангийн ажилчдын эрэлт хэрэгцээ багассан. Үүний зэрэгцээ хот суурин газарт ажиллах хүчний эрэлт нэмэгдэж, эрүүл мэнд, боловсролдоо иргэд анхаарах болсноор том хотууд руу шилжилт хөдөлгөөн нэмэгджээ.

Истанбул хотод сүүлийн 10 жилийн хугацаанд нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил 87.6% нэмэгдсэн байна. Гэмт хэрэг, зөрчлийн түвшинд ийнхүү өөрчлөлт гарсны гол хүчин зүйл нь шилжилт хөдөлгөөн, иргэдийн ухамсар, залуучуудын ёс зүйн доголдол зэрэг болохыг тэмдэглэсэн байна. Томоохон хотуудад хулгайлах, дээрэм, булаах зэрэг гэмт хэргүүдийн түвшин нэмэгдэх хандлагатай байдаг байна.³³

³¹ Corman, Hope & Mocan, H. Naci, "Carrots, Sticks and Broken Windows" (July 2002), NBER Working Paper No. W9061

³² Harries, K. D. (1974), The Geography of crime and Justice

³³ Seyhan, K. ve M. B. Eryilmaz, (2004), "Gelismis Ulkeler ve Turkiye Uygulamasinda Suc Onleme

Хот суурин газар шилжин ирсэн иргэд хотын амьдралын дүрэм журам, хэв маягт дасан зохицоход багагүй хугацаа шаардагддаг. Иймээс иргэд хотын амьдралтай дасан зохицох, дүрэм журмыг мөрдөж эхэлснээр гэмт хэрэг, зөрчил, нийгмийн хэв журам цэгцэрдэг гэсэн дүгнэлтэнд хүрсэн.

Метрополис хотуудын гэмт хэрэг, зөрчлүүдийн түвшинг авч үзвэл 10 сая хүн амтай Истанбулд жилд 91.693, 3 сая хүнтэй Берлинд 573.000, 1.6 сая хүн амтай Вианад жилд 154.000, 2,8 сая хүн амтай Мадридад 230.000 гэмт хэрэг гардаг байна. Эдгээрийг хүн амын тоонд нь харьцуулан авч үзвэл Мадрид 8%, Виана 10%, Берлин 17% байгаа бол Истанбулд 1% гэсэн дүвшин гарч байна. Эдгээр нь Европын хамгийн тайван, аюулгүй хотуудын жишээ юм.³⁴

Гудамж талбайг эмх цэгцтэй, графит зураггүй байх нь гэмт хэрэг, зөрчил даамжран гарахаас сэргийлдэг талаар Чингэлтэй дүүргийн 10-19 дүгээр хорооны нутаг дэвсгэр буюу 79 мянга орчим хүн амтай гэр хороолол бүхий бүсийг хүн амын хувьд тэнцүүхэн Завхан аймгийн нутаг дэвсгэртэй харьцуулалт хийж үзсэн. Харьцуулан ажиглалтын үр дүнд Завхан аймгийн Улиастай хот, Асгат, Их-Уул сумдуудын гудамжны зохион байгуулалт нь эмх цэгцтэй, гудамж бүр гэрэлтүүлэгтэй, эвдэрхий хагархай, эмх замбараагүй гэх нөхцөл байдал байгаагүй бол Чингэлтэй дүүргийн 10-19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт орших гудамж талбай нь хашааны байршил, дугаар нь эмх замбараагүй, гэрэлтүүлэг, камергүй орчин, хогийн цэг ихтэй нь илэрсэн. Ялангуяа Дэнжийн 1000, Хайлааст, 7 буудал орчим гудамж талбай зохион байгуулалт хяналт шалгалт муутай байв. Гэмт хэргийн тоо мэдээнээс харвал гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг Чингэлтэй дүүргийн тус нутаг дэвсгэр Завхан аймгаас даруй 14 дахин их байна.³⁵ Мөн дээрх байдлаар Чингэлтэй дүүргийн гэр хорооллын бүсийг Хан-Уул дүүргийн байшин хорооллын бүстэй харьцуулан ажиглалт хийсэн. Дээр дурдсан онцлог шалтгааны улмаас гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 2019 оны эхний улирлын байдлаар Чингэлтэй дүүрэгт Хан-Уул дүүргээс 2 дахин их байна.

Гэхдээ энэ тоон үзүүлэлт үнэн бодитой эсэх нь эргэлзээтэй юм. Учир нь криминологичид “далд нөхцөл байдал”, “хар тоо” зэрэг ойлголтыг байдаг гэдгийг нотолсоор ирсэн. Гэмт хэрэг, зөрчлийн албан ёсны бүртгэлээс авсан тоо мэдээлэл нь гэмт хэрэг зөрчлийн жинхэнэ тооноос хол зөрөх магадлалтай юм. Хохирогч гэмт хэрэг, зөрчлийг үл мэдээлэх, тоолгүй өнгөрүүлэх зэрэг нь бодит тоо мэдээ гарахгүй байх гол шалтгаан болж байдаг.

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх стратегийн түвшинд “Хагархай цонх” үзэл баримтлалыг үндсэн ойлголт болгон авч үзэж болох юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхдээ ихэвчлэн нийгмийн анхааралыг татсан, хүнд гэмт хэргүүд рүү төвлөрдөг. Дараа нь гэмт хэрэгтнээс урьдчилан сэргийлэх буюу гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй эрсдэлтэй этгээдүүдийг хянах, сургалтын үйл ажиллагаа явуулах зэрэг байдаг.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндсэн арга нь тодорхой гэмт хэрэг зөрчил үйлдэгдэх боломж, нөхцлийг үгүй болгох, хамгийн бага түвшинд

Stratejileri"

³⁴ International Centre for the Prevention of Crime, U.S. Department of Justice Office of Justice Programs

³⁵ ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төв. "Улсын хэмжээнд 2019 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээ" 2019 оын 04 сарын 05-ны өдөр

аваачих явдал юм. Мөн орчин тойрны урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь гэмт этгээд баригдах магадлалыг ихэсгэснээр тохиолдлоор гэмт хэрэг үйлдэх явдлыг багасгах ач холбогдолтой. Энэ нь “хагархай цонх”-ны үзэл буюу орчин тойрны эмх замбараагүй байдал, нийгмийн хэв журмын сахиулсанаар гэмт хэрэг үйлдэгдэх магадлалыг багасгах боломжтой адил утгатай юм.

Дүгнэлт

Гэмт хэрэг, зөрчлийн түвшин, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаа чухал харилцан хамааралтай байх ёстой. Үүнд нөлөөлөх нэгээхэн хүчин зүйл бол хотжилт юм. Амьдарч байгаа иргэнээ тухайн хот суурин газар ямар амьдралын хэв маягаар хангаж чадах, боломж бололцоо, соёлын түвшин зэрэг нь гэмт явдлын түвшинд шууд хамаардаг. Эрүүл орчинд амьдрах, тайван аюулгүй байдал нь гэмт явдал үйлдэгдэх боломжит нөхцөл байдлыг бий болгохгүй байх хандлагыг бий болгодог.

Энэ ойлголтыг тайлбарлахын тулд “хагархай цонх” хэмээх жишээг авч үзжээ. Хагархай цонх моделийг нийгэмд хэрэгжүүлэх ач холбогдлыг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий удирдлага, улс төрийн хүрээнд дэмжих шаардлагатай. Ингэснээр нийгмийн соёл, ёс суртахуун, зан заншил, хүндлэх, хүндлэгдэх ёс нийгэмд дахин бий болох суурь болж өгнө.

Хот суурин газарт оршин суугчдын дунд гэмт хэрэг зөрчлийн талаархи мэдээ мэдээлэл хомс, хотын соёл үнэт зүйл хараахан суурьшиж амжаагүй нийгэмд энэхүү үзэл санаа анзаарахад бэрх байж болзошгүй. Тийм тохиолдолд хагархай цонхны жишээг гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийг нийгэмд таниулсан эерэг имиж бүрдүүлэх, түгээх, нийгмийн дунд ухамсарлуулах арга хэмжээг авах нь илүү үр дүнтэй болно.

Санал

1. Хөнгөн гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх, үйлдэгддэг шалтгаан нөхцлийг тодорхойлон, хяналтын тогтолцоог сайжруулах, эрх зүйн орчин бий болгож зохион байгуулах;

2. Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг дээшлүүлэх, эрх бүхий байгуулагаас зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэн зөрчлийн түвшинг багасгах;

3. Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заагдсан зөрчлүүдэд арга хэмжээ авч, шийдвэрлэгдэж чадаж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, огт арга хэмжээ авагддаггүй, хэрэгждэггүй зөрчлийг шалган шийдвэрлэх арга хэмжээ хэрэгжүүлэх;

4. Хөнгөн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд засаг захиргааны анхан шатны нэгжийн хүрээнд иргэд, байгууллагууд оролцсон олон нийтийн бүлгүүдийг үүсгэж, хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих, сурталчлах, нийтийн хэв журам, аюулгүй байдлын эсрэг зөрчил, ёс суртахууны эсрэг зөрчлүүдийг цаг алдалгүй шуурхай мэдээлэх, мэдээлэл солилцох, түгээх ажилд хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх;

5. Зөвхөн цагдаагийн байгууллагад гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл гаргаж хандах бус бусад зөрчил шалгах эрх бүлхий төрийн байгууллагуудын үйл ажиллагааг эрчимжүүлж, ирж буй дуудлага мэдээлэл, нэг цэгийн үйлтөрийн болон төрийн бус байгууллагын ажлын уялдаа холбоог хангах ажлыг зохион байгуулах зэрэг санал дэвшүүлж байна.

Ашигласан материал:

1. Ackerman, W. V. (1998), "Socioeconomic correlates of increasing crime rates in smaller communities", *Professional Geographer*, 50(3), pp. 312-387.

2. Cahill, Meagan Elizabeth (March 2005), "Geographies of Urban Crime: An Intraurban study of crime in Nashville, TN; Portland, OR; and Tucson", AZ; A Dissertation Submitted to the Faculty of the Department of Geography and Regional Development In partial Fulfillment of the Requirements For the Degree of Doctor of Philosophy in the Graduate College The University of Arizona, 2004, <http://www.ncjrs.gov/pdffiles1/nij/grants/209263.pdf> (Eriгim Tarihi : 04.6.2006)

3. Kelling, George L. & Coles, Catherine M., (1996), *Fixing Broken windows: Restoring order and Reducing crime in our Communities*, USA: Martin Kessler Books, The Free press. Kelling, George L. & Coles, Catherine M., (1991), *Fixing Broken windows: Restoring order and Reducing crime in our Communities*, USA: Touchstone Edition. Kelling, George L. & Sousa, William H. Jr. (2001), "Do Police Matter? An Analysis of the Impact of New York city's Police Reforms", Manhattan Institute Center for Civic Innovation Civic Report, No. 22. http://www.manhattan-institute.org/pdf/cr_22.pdf (Eriгim Tarihi: 1e.s.2006).

4. Seyhan, K. ve M. B. Eryılmaz, (2004), "Gelişim Ülkeleri ve Türkiye Uygulamalarında Suç Önleme Stratejileri", *Liberal Düşünce*, 34, (Bahar 2004), s. 181-214.

5. Sennett, R., (1996), *Kamusal alanın çöküşü*, Çev. S. Dr. Erkan ve A. Yılmaz, İstanbul: Ayraç Yayınları. Shaw, C. R., (1929), *Delinquency Areas*, Chicago: University of Chicago Press. Shaw, C. R. and McKay, H. D., (1942), *Juvenile Delinquency Areas*, Chicago: University of Chicago Press.

6. Shaw, C. R. and McKay, H. D., (1969), *Juvenile Delinquency Areas* (Revised Edition), Chicago: The University of Chicago Press. Sheldon, Randall G., (2005), "Assessing 'Broken Windows': A Brief Critique", CENTER ON JUVENILE AND CRIMINAL JUSTICE, (Last Modified on March 17, 2005), <http://www.cjcj.org/pdf/broken.pdf> (Eriгim Tarihi : 18.5.2006).

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫГ АШИГЛАХ АСУУДАЛ****Б.Баянмөнх**

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Цагдаагийн эрх зүйн тэнхимийн
дэд профессор, цагдаагийн хошууч

Товчлол. Энэхүү өгүүлэлд хиймэл оюун ухааны тухай ойлголт, түүний гүйцэтгэж буй үүрэг, ач холбогдол болон цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хиймэл оюун ухааныг ашиглах зарим арга зам, түний ач холбогдлын талаар товч авч үзсэн болно.

Түлхүүр үгс: Хиймэл оюун ухаан, хэл ярианы хиймэл оюун, Цагдаагийн байгууллага

Үндсэн хэсэг

Хиймэл оюун³⁶ нь компьютерын програм хангамжаар бүтээгдсэн хүний сэтгэхүйг дууриалгасан ба бараг ижил түвшинд хүргэсэн технологийн төрөл ба аливаа хүний хийдэг үйл ажиллагааг удирдахад зориулагддаг болно.

Хиймэл оюун судлаачид болон ном зохиолд судалгааны энэ чиглэлийг тодорхойлохдоо "ухаалаг агент бүтээх шинжлэх ухааны судалгаа" гэсэн байдаг. Энд ухаалаг агент гэж "орчноо танин мэдэж, тохирсон үйлдлийг гүйцэтгэхдээ амжилтад хүрэх магадлалаа дээд зэрэгт хүргэхийг эрмэлздэг систем" гэж тайлбарласан байна.

Анх "Хиймэл оюун ухаан" хэмээх нэр томъёог Жон Маккарти 1955 онд өөрийн бүтээлдээ ашиглаж, "ухаант машин техник бүтээх онолын болон инженерийн шинжлэх ухаан" гэж тодорхойлжээ.

Хиймэл оюун нь өөрийгөө хөгжүүлж байдаг программ хангамжийн төгс программ юм. Өнөөдөр бид хиймэл оюуныг хамгийн энгийнээр үзвэл роботоор төсөөлж болно. Гэхдээ өнөөгийн робот бол зөвхөн тухайн зохиогчийн бичигдсэн алгоритмын дарааллаар ажилладаг. Өөрөөр хэлбэл компьютер тоглоомууд нь үүний тод жишээ юм. Хэрэв бид төгс хиймэл оюуныг зохион бүтээх аваас хүн төрөлхтөн өөрсдийнхөө бүтээсэн зүйлд устаж үгүй болох магадлалтай.

Хиймэл оюунд байвал зохих чадварууд:

- Өөрт дүн шинжилгээ хийж, хариултыг өөрийнхөөр илэрхийлдэг байх.
- Өөрийн алдааг олж засварладаг
- Хүний сэтгэхүйгээс илүү давсныг сэтгэх

Хиймэл оюуны ухааны судалгааны салбар 1956 оны зун Дартмутын Коллежийн хотхонд болсон зөвлөгөөн дээр үүсгэн байгуулагдсан байна. Жон Маккарти, Марвин Мински, Аллен Невел, Артур Самуэл, Херберт Саймон зэрэг оролцогч олон арван жил хиймэл оюуны судалгааны удирдагчид байсан.

³⁶ англ. Artificial Intelligence, AI

Тэд болон тэдний оюутнууд ихэнх хүмүүсийн хувьд зүгээр л гайхамшигтай программуудыг бичсэн бөгөөд энэ нь тоглоомд хожигч, алгебрт өгүүлбэртэй бодлогыг боддог, логикийн теорем баталдаг, мөн ярианы англи хэлний компьютерууд байжээ.

1990-ээд он болон 21-р зууны эхэн үед хиймэл оюуны салбар хэдий анхаарлын төвд байгаагүй ч хамгийн дээд амжилтаа хүрсэн байдаг.

Хиймэл оюун ухааныг ложистик, мэдээллийн олборлолт, эмчилгээний дүн шинжилгээ болон бусад олон салбарт технологийн үйлдвэрлэлээр дамжуулан ашигладаг болсон.

Үүний нэг тод жишээ нь 1997 оны 5-р сарын 11-нд Дийп Блү дэлхийн шатрын аварга Гарри Каспаровыг ялсан анхны шатарчин компьютер болсон байдаг.

XXI зуун гарсанаар хүн төрлөхтөний хиймэл оюун ухааны талаарх анхны судалгаанууд нийтлэгдэж, робот анх удаа иргэншил олж авсан нь хүн төрөлхтөнд ихээхэн шинэ нээлтийг авчирсан билээ.

Өнөөдөр бид хиймэл оюун ухаан хөгжсөнөөр хүний хүчин зүйлээс хамааралтай олон ажил мэргэжлүүд алга болж ажил мэргэжил гэх ойлголт өөрчлөгдөхөд хүрээд байна. Хиймэл оюун ухааныг ашиглан бүтээгдсэн робот хүний өдөр тутмын амьдралд оролцож эхэлсэнээр өдөр тутмын хүмүүсийн амьдралын хэв маягийг өөрчлөгдөх нөхцөл аажмаар бий болж байна.

2016 оны 12 сард Цагаан ордны эдийн засгийн зөвлөхүүд болон судлаачид хиймэл оюун ухааны үзүүлж буй нөлөөлөл, ирээдүйд АНУ-ын нийгэм, эдийн засагт хэрхэн нөлөөлж болох талаар судалгаа хийж, үр дүнг Ерөнхийлөгчид өргөн барьсан байна. Уг судалгаанд бичсэнээр:

Хиймэл оюун ухааны дэвшлийг аж үйлдвэрт нэвтрүүлснээр бүтээмж их хэмжээгээр нэмэгдэж байна. Цаашлаад үйлдвэрлэлд ажилладаг, биеийн хүчний ажил хийдэг нийгмийн бүлэг болоод боловсрол өндөртэй мэргэжилтний цалингийн зөрүү нэмэгдэх хандлагатай байгааг дурьдсан байна.

Хиймэл оюун ухааныг аж үйлдвэрийн салбартаа ашиглаж эхэлсэн өндөр хөгжилтэй 12 орны эдийн засгийн өсөлт 2035 он гэхэд хоёр дахин нэмэгдэх хандлагатай байна.

Том хэмжээний зөөврийн машинаар тээвэр хийдэг салбарынхэн ирэх 10 жилд бүх машинаа автоматжуулахаар эхэж байгаа нь 3.8 сая хүний ажлын байрыг програмчилсан машин булаахаар заналхийлж байгаа хэрэг. Түүнчлэн ресторан, зөөврийн машин, оффисын бичиг хэргийн ажилтан гэх мэт ажлын байранд өөрчлөлт орох төлөвтэй байгаа бөгөөд энэ нь АНУ-ын нийт ажлын байрны 9 хувийг эзэлж байгаа юм.

Карл Фрей болон Майкл Осбоурн нарын 2013 онд хийсэн судалгаагаар Америкийн нийт ажлын байрны 47 хувь нь автоматжуулалтад орох аюул тулгараад байгааг сануулжээ³⁷ гэсэн байна.

Энэ нь цаашлаад дан ганц үйлдвэр, үйлчилгээний асуудлаас үүдэлтэйгээр нийгмийн дэг журам алдагдах, нийтийн эмх замбараагүй байдал үүсэх замаар улс орны нийгэм, эдийн засаг тогтворгүй байдалд орох сөрөг нөлөөллийг давхар дагуулж байгааг харж болохоор байна.

Түүнчлэн Accenture-аас гаргасан тайланд хиймэл оюун ухааныг аж үйлдвэрийн салбартаа ашиглаж эхэлсэн өндөр хөгжилтэй 12 орны эдийн засгийн өсөлт 2035 он гэхэд хоёр дахин нэмэгдэх хандлагатай байна гэжээ.³⁸

Эдгээр хөгжингүй орнууд аж үйлдвэрийн салбарт хүний хүч шаардагддаг, хар бор ажлыг робот болон зориулалтын автомат дамжлагат системээр зохицуулж байна. Ингэснээр ажилчны даатгал, үйлдвэрийн осол, осолд орсон хүнийг хангах төлбөр гэх мэт олон эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжтой болоод байгаа юм байна.

2012 онд Гүүгл компанид Deep Learning-ийн хоёрхон судалгааны баг байсан бол 2016 онд тус компани үүнтэй холбоотой 1000 гаран төсөл хэрэгжүүлж эхэлсэн байна.

Энэ технологийг хэрэглээнд нэвтрүүлснээр Гүүглийн хөрвүүлэг хийх технологи (Google translate), хүний дуу авиа таних төхөөрөмж (Android Phone, Cortana), зураг таних технологи (Google driverless car, Youtube) зэрэг нь гайхалтай өндөр төвшинд ажиллаж байгаа, цаашид улам бүр боловсронгуй технологи хэрэглээнд нэвтрэх нь цаг хугацааны асуудал болоод байна.

Жишээ нь “Ring” хэмээх зүүж болдог энэ төхөөрөмж нь камер, хөгжим, сошиал медиа бүртгэлээ удирдах боломжтой юм. Ердийн бөгжнөөс үл ялиг том энэ төхөөрөмж Bluetooth технологиор дамжуулан олон арван үүргийг гүйцэтгэж байгаа бөгөөд уг бөгжийг агаарт тэмдэг зурах, такси дуудах гэх мэт дохио зангаануудад хариулахаар урьдчилан программчлахын хамт iOS болон Android төхөөрөмжүүдтэй харилцах дохио зангаануудаа ч тохируулж болно. Зурагт асаах, хэн нэгэнтэй мэдээлэл солилцох эсвэл зураг илгээхдээ хэрэглэгч Ring-ийн мэдрэгчийг товшиход л болох юм³⁹ байна.

Хиймэл оюун ухааны хөгжилт, түүний үр дүнгээс хамаарч сайн зүйл олон бий болж байгаа хэдий ч сөрөг үр дагавар багагүй авчирч байна. Тухайлбал:

- Хиймэл оюун ухаан хөгжсөнөөр олон ажил мэргэжлүүд алга болж байна.
- Бүх зүйлс тоон системд шилжиж байна.
- Ажиллах хүч шаардлагагүй болж робот бүтээх үйл явц нэмэгдэж байна.
- Хиймэл оюун ухаанаар бүтээгдсэн хүний амьдралыг хөнгөвчлөх техник хэрэгслүүд улам бүр нэмэгдэж байна.

Бид өнөөдөр робот, жолоочгүй машин, ухаалаг гэр ахуйн цахилгаан хэрэгсэл бүхий дөрөв дэх аж үйлдвэрийн хувьсгалын эрин үед амьдарч байгаа билээ. Энгийн үгээр тайлбарлах юм бол хиймэл оюун ухаан гэдэг нь хүний чадвар, оюун ухаанаас хэтэрсэн автомат компьютерийн системийн үсрэнгүй хөгжил юм.

Хиймэл оюун ухаан буюу (Artificial Intelligence A.I. - ийн талаар хүн бүхэн ярьж, түүний дараагийн хөгжил юу болохыг дэлхий нийтээрээ ажиглан хүлээж байна.

Харин зарим хүмүүс хиймэл оюун ухааны талаар эсрэг байр суурьтай байдаг ч секундээр өөрчлөгдөн хувьсаж хүмүүсийн өдөр тутмын хэрэглээнд

³⁸ <https://www.accenture.com/us-en/insight-artificial-intelligence-software>

³⁹ news.xopom.com/66423/

түлхүү нэвтэрч буй технологийн дэвшлийн эрчийг сааруулж чадахгүй байгаа нь өнөөдрийн тулгамдсан асуудал болсон байна.

Өнөөдөр хүн төрөлхтөний хиймэл оюун ухааныг ашиглах явдал улам бүр нэмэгдэхийн хэрээр нийгмийн сөрөг үзэгдэл болох шинэ төрлийн гэмт хэрэг, зөрчил бий болох магадлалтай улам бүр нэмэгдэж байна.

Үүний хэрээр хууль сахиулах байгууллагууд хиймэл оюун ухааныг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаандаа ашиглах нь түүнтэй тэмцэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх боломжийг бий болгох явдал юм.

Тухайлбал гадаадын орнуудад орон нутгийн замд бүх автомашины хурдад хяналт тавих нь хүн хүч, техникийн хувьд боломжгүй байдаг учир зам тээврийн осол ихээр гарч байгаа газруудад хиймэл оюун ухаанаар бүтээгдсэн камерын системийг ашиглан:

- хурдны дээд, доод хязгаарлалтанд зохицуулалт хийх;
- хяналт тавих;
- хяналт тавих хугацааг сонгох;
- хурд хэтрүүлсэн жолоочийн бурууг тогтоон нотлох
- зөрчил гаргасан жолоочид бодит хариуцлага тооцох;
- хурдны хязгаарыг жолоочид анхааруулж дагаж мөрдүүлэх анхааруулга, санамж өгөх гэх мэт аргуудыг гадаад орнууд хэрэглэж байна. :

Дэлхийн улс орнууд хүний царай төрхийг камераар танин илрүүлэх, дуу хоолойны өнгөөр тухайн хүнийг тогтоох, биеийн дулаан, сэтгэл хөдлөлийг зайнаас хэмжих зэрэг олон хиймэл оюун ухаанд тулгуурласан олон техник технологиудыг бүтээн ашигласаар байна.

Тэгвэл өнөөдөр манай цагдаагийн байгууллага өөрийн орны чадварлаг программистуудтай хамтран хиймэл оюун ухаан дээр тулгуурласан дараахь ажил арга хэмжээг авч хэрэгжүүлбэл үр дүн гарна гэж үзэж байна.

Нэг. *Нийтийг хамарсан арга хэмжээний нөхцөл байдлын үнэлгээ хийх үүрэг бүхий программ бүтээх судалгааны ажлыг ШУТИС-ийн багш, судлаачидтай хамтран хэрэгжүүлэх;*

Бид өнөөдөр нийтийг хамарсан арга хэмжээний нөхцөл байдлын үнэлгээг хамгаалалтанд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын газар дээрээс нь ирүүлсэн мэдээ, мэдээлэл дээр тулгуурлан ажиллагааг удирдаж байгаа дарга өөрөө шууд үнэлж байгаа нь өнөөдрийн бодит үнэн юм.

Тэгвэл нөхцөл байдлын үнэлгээг хиймэл оюун ухаан дээр тулгуурлан бүтээгдсэн программ дээр тодорхой өгөгдлүүдийг оруулсанаар гарч болзошгүй эрсдлийг түвшин тус бүрээр гаргах асуудал нэн шаардлагатай болоод байна.

бөгөөд ажиллагааны удирдлагаас түүний тусламжтайгаар цаашдын хийх ажлын чиглэлээ тодорхойлох боломжтой болох юм.

Хоёр. *Үйл ажиллагааны төлөвлөгөөний агуулгын давхардлыг хянан илрүүлж мэдээлэх, засах үүрэг бүхий программыг зохион бүтээх*

Өнөөдөр цагдаагийн байгууллага бүхий үйл ажиллагаагаа урьдаас боловсруулсан төлөвлөгөөний дагуу явуулж байгаа билээ. Гэхдээ төлөвлөгөө нь дээрээс доошоо чиглэсэн тогтолцоон дээр тулгуурлан үе шаттайгаар боловсруулагдаж байгаа бөгөөд энэ нь өөрөө агуулгын давхардал бий болох, ачаалал зохиомлоор нэмэгдэх сөрөг хүчин зүйл болж байна.

Тэгвэл бид агуулгын давхардлыг илрүүлэх, боловсруулж байгаа албан тушаалтанд мэдэгдэх замаар үйл ажиллагааны ачааллыг бууруулах боломжтой болох юм.

Гурав. *Үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нарт дуу дүрс бүхий мэдээлэл дамжуулах зөөврийн бага овор бүхий хэрэгслийн талаар судалгаа хийх*

Өнөөдөр үүрэг гүйцэтгэж байгаа цагдаагийн алба хаагч нарт шаардлагатай дүрс бүхий мэдээлэл дамжуулах боломж байхгүй, гагцхүү богино долгионы радио станцаар үгээр тайлбарлан таниулах замаар дамжуулж байгаа нь бодит үнэн юм.

Тэгвэл гэмт хэргийн улмаас оргон зайлсан гэмт этгээдийн гадна дүр төрх, хувцас эсхүл алдагдсан эд зүйлийн ерөнхий шинжийн талаарх мэдээллийг дуу дүрстэйгээр хэдхэн секундэд дамжуулсанаар алба хаагчаас гүйцэтгэх үүргийг улам хялбар болгох боломжтой болох юм.

Дөрөв. *Авто замын уулзварыг зохицуулах үүрэг бүхий программаар зохион бүтээх*

Өнөөдөр авто замын уулзварын хөдөлгөөн зохицуулалтыг тодорхой хугацааны давтамжаар эсхүл хөдөлгөөний нягтралд камерын тусламжтайгаар хяналт тавьж буй хүний зайны идэвхитэй үйлдлээр, түүнчлэн зохицуулагч-цагдаа нарын биечилсэн хөдөлгөөнөөр хийж байгаа билээ.

Тэгвэл өнөөдөр хиймэл оюун ухааны тусламжтайгаар авто замын уулзварын хөдөлгөөн зохицуулалтыг хийх боломжтой билээ.

Өөрөөр хэлбэл хяналтын камерт ирсэн замын ачааллын талаархи өгөгдөлд программ дүн шинжилгээ хийж, аль чиглэл нь ачаалалтай байна тэр чиглэлийн дохиог нээх замаар хөдөлгөөн зохицуулах явдал юм.

Зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд хяналтын камерын тусламжтайгаар хүн биечлэн зохицуулалт хийх боломжтой байдлаар зохионо.

Дүгнэлт

Дээрхи бүгдийг нэгтгэн авч үзвэл хүн төрөлхтөн хиймэл оюун ухааны тусламжтайгаар ажил, амьдралаа хөнгөвчлөх байдал руу улам ихээр анхаарлаа хандуулж байгаа нь дэлхийн улс орнуудын явуулж буй бодлого, үйл ажиллагаанаас харж болохоор байна.

Тэр хэмжээгээр хиймэл оюун ухааны тусламжтайгаар гэмт хэрэг, зөрчил үйлдэх боломж нэмэгдэж байгаа нь өнөөдрийн цагдаагийн байгууллагын анхаарлаа хандуулах нэг асуудал болсон байна.

Тиймээс цагдаагийн байгууллага үйл ажиллагаандаа хиймэл оюун ухааныг ашиглах, өөрөөр хэлбэл үйл ажиллагаандаа шаардлагатай программуудыг мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулж үйл ажиллагаандаа нэвтрүүлсэнээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх боломжийг улам нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх болно.

Санал. Цагдаагийн байгууллага үйл ажиллагаандаа хиймэл оюун ухааныг ашиглах зарим арга замын талаар дараахь саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Гадаадын зарим улс орнуудын хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд ашиглаж байгаа хиймэл оюун ухааны талаарх судалгааг Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдаар хийлгэх;

2. Манай улсын цагдаагийн байгууллагын ямар үйл ажиллагаанд хиймэл оюун ухааныг ашиглах боломжтой талаар судалгааны төслийг Их сургуулийн Цагдаа судлалын профессорын судалгааны багийн судлаачидтай хамтран бичиж, технологийн санд хүргүүлэх;
3. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн эрдэмтэн судлаачидтай хамтран цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглах программ зохиох ажлыг эхлүүлэх;
4. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах хиймэл оюун ухааныг бүтээхэд шаардлагатай хөрөнгийг төсөвт суулгаж өгөх;

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС ХУУЛЬ БУС ЖАГСААЛ ЦУГЛААНЫГ
АЛБАДАН ТАРААХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ,
АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ**

Ш.Чулуун

ДХИС-ийн ЦС-ийн АТБТ-ийн ахлах
багш, цагдаагийн дэд хурандаа

Цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн үүргийн нэг бол хууль бус жагсаал, цуглааныг албадан тараах явдал юм.

Монгол улсын иргэн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй байдаг ба энэ эрхийг нь Монгол улсын Үндсэн хуульд тодорхой зааж өгчээ. Тухайлбал: Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно⁴⁰ гэжээ.

Ардчилсан нийгэмд хүний эрхийг дээдэлдэг хэдий ч эрхээ эдлэхдээ бусад хүний эрхийг бас зөрчиж болохгүй юм. Жагсаал, цуглаан хийх журмыг “Жагсаал цуглаан хийх журам”-ын тухай хуулиар тодорхой зааж өгсөн байдаг бөгөөд тус хуулийг зөрчин явуулж байгаа үйл ажиллагаа нь хууль бус үйлдэл юм.

Иргэдийн тайван замаар жагсаал цуглаан хийх, эрхийг ашиглан зөвшөөрөгдсөн газарт хуулийн дагуу явуулах бус, хууль зөрчих улс төр хийх, бусдыг хууль бус халдлагад өдөөн турхирах, бусдын болон төрийн тангараг өргөсөн алба хаагчдын эрх чөлөөнд халдах, бусдын болон нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг эвдэн гэмтээх, устгах, шатаах, иргэдийн нэр төр, алдар хүнд, эрх чөлөөнд бүдүүлгээр, хууль бусаар халдах, олон нийтийн зорчих хэсгийг хаах, төрийн тусгай хамгаалалтын бүсэд дур зоргоор нэвтэрч танхайрах зэрэг нийгмийн гажууд үзэгдэл гарсаар байна.

Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийнхээ дотор ердийн арга хэрэгслээр тохинуулах боломжгүй болсон тохиолдолд цагдаагийн байгууллага

⁴⁰Үндсэн хуулийн 16-р зүйлийн 16 дахь заалт

аймаг, нийслэлийн засаг даргын захирамжаар албадан тараана⁴¹ гэж хуулинд тодорхой заасан байна.

Монгол Улсын иргэдээс улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа нийтэд илэрхийлэх зорилгоор зохион байгуулж байгаа үйл ажиллагааг **цуглаан**, иргэд хот суурингийн гудамж талбайгаар зохион байгуулалттайгаар жагсан явж, иргэдээс улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа нийтэд илэрхийлэх үзэл бодол, санал, шаардлагаа илэрхийлж байгааг **жагсаал**⁴² гэнэ гэж тус тус холбогдох хуулинд нарийвчлан тусгаж өгсөн байна.

Жагсаал, цуглаан хийхийг хориглох газрыг хуулинд дараах байдлаар тусгаж өгсөн байна. Үүнд:

- Нисэх онгоцны буудал, төмөр замын бүх өртөө, буудал, нийслэлийн зорчигч тээврийн төв буудал
- цэрэг, цагдаагийн болон төрийн хамгаалалтад байгаа газар
- радио телевизийн нэвтрүүлэг явуулдаг байгууллага, аймаг, нийслэл дэх төв холбооны газар
- олон улсын буюу үндэсний яармаг, үзэсгэлэн зохион байгуулж байгаа байгууллага, хот суурин газрын хүнсний болон барааны зах
- эмнэлгийн байгууллага
- Нийслэл Улаанбаатар хотын Сүхбаатарын талбайн Төрийн ордны нутаг дэвсгэрт хамаарах хэсэгт⁴³ гэж тус тус заасан байна.

Жагсаал, цуглааныг зохион байгуулах субъектээс дараах зорилгыг агуулсан жагсаал, цуглаан хийхийг мөн хуулиар хориглосон байна. Үүнийг тодруулбал:

- Дайн сурталчлах, үндэстэн ястны хооронд хагарал гаргах буюу үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхах, аллага, хядлага, хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, төрийн эрх мэдлийг хууль бус аргаар авахыг уриалах
- Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журамд хохирол учруулж эмх замбараагүй байдал бий болгох
- Улс орны буюу тодорхой нутаг дэвсгэрийн хэмжээнд онц болон дайны байдал зарласан, байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон бол тухайн нутаг дэвсгэрт уг шалтгаан арилтал жагсаал, цуглаан хийх
- Зохих журмын дагуу бүртгэгдсэн жагсаал, цуглаан хийх газарт мөн цаг хугацаанд түүний эсрэг агуулга, зорилготой өөр жагсаал, цуглаан давхардуулан хийх
- Гудамж, талбайд өлсгөлөн зарлахыг хөндлөнгөөс зориуд зохион байгуулахыг хүний амь нас, эрүүл мэндийг үл хайхарсан хүмүүнлэг бус үйлдэл гэж үзэж хориглоно⁴⁴ гэж тус тус заасан байна.

Дээрхи нөхцөл байдлыг дүгнэжүзвэл хэдийгээр эрх бүхий албан тушаалтнаас зөвшөөрөл авсан хэдий ч жагсаал, цуглаан зохион байгуулахыг хориглосон газар, хууль бус зорилго агуулсан, эсвэл эрх бүхий субъектээс

⁴¹Үндсэн хуулийн 25-р зүйл 2.2 дахь хэсэг

⁴²Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 3-р зүйл

⁴³Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль 7-р зүйл

⁴⁴Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль 8-р зүйл

зөвшөөрөл аваагүй жагсаал, цуглаан зохион байгуулж явуулах ажиллагаа нь өөрөө хууль зөрчсөн үйлдэл буюу хууль бус жагсаал, цуглаан юм.

Цагдаагийн байгууллага нь хуульд заасан журмын дагуу зохион байгууллагдаж байгаа жагсаал, цуглааны үед хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу хэв журмын хамгаалалтын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг хариуцан ажиллаж оролцогчдын аюулгүй байдлыг гадны гэмт халдлагаас хамгаалж, хэв журам сахиулан ажиллах үүрэгтэй байна.

Мөн нөгөө талаас хууль бусаар зохион байгууллагдаж байгаа жагсаал, цуглааныг албадан тараах үүрэгтэй байна. Энэхүү үүргийг нь Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль⁴⁵, Цагдаагийн албаны тухай хууль⁴⁶-д тус тус тусгайлан заасан байна.

Өөрөөр хэлбэл хуульд заасан хүч, арга хэрэгсэл хэрэглэн жагсаал цуглааныг албадан тараах тухай Засаг даргын захирамжийг биелүүлэх зорилгоор цагдаагийн байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ юм.

Энэхүү үйл ажиллагааг гүйцэтгэхдээ цагдаагийн байгууллага нь “Шуурхай удирдлагын штаб” байгуулж ажиллана.⁴⁷ Шуурхай удирдлагын штабыг цагдаагийн төв байгууллагын даргын тушаалаар томилно.

Штаб нь суурин болон зөөврийн радио станц, дүрс бичлэгийн камер, зургийн аппарат, сүлжээнд холбогдсон телефон утас, чанга яригч, зурагт, дуран, гэрэлтүүлэгч хэрэгсэл, цахилгаан үүсгүүр, бусад шаардлагатай техник хэрэгслээр хангагдсан байна.

Штабын байранд хууль тогтоомж, журам, заавар, тушаалын эмхтгэл, бэлэн байдлын болон үйл ажиллагааны төлөвлөгөөнүүд, зураглал, газрын зураг, хүч, хэрэгслийн тоо, нөөцийн мэдээ, шаардлагатай алба хаагчдын холбоо барих утасны жагсаалт, радио холбооны дуудлага зэргийг бэлэн байлгана.

Мөн штабын дэргэд ажлын хэсэг ажиллаж, дарга, гишүүдээс өгсөн үүрэг даалгавар, хамгаалалтад ажиллаж байгаа анги, байгууллага, албан тушаалтнаас хүлээн авсан мэдээ, мэдээллийг цаг, минутаар баримтжуулах, зураглал үйлдэх, бичиг баримт төлөвлөх зэрэг удирдлагаас өгсөн бусад үүргийг гүйцэтгэнэ гэж үйл ажиллагааны чиглэлийг нь нарийвчлан тусгаж өгсөн байна.

Жагсаал цуглааныг албадан тараахад цагдаагийн байгууллага, алба хаагч нь зайлшгүй шаардлагатай нөхцөл байдал бий болсон үед хуулинд заасан үндэслэл журмын дагуу албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх эрхтэй байна.

Энэхүү эрх зүйн зохицуулалтыг нь Цагдаагийн албаны тухай хууль⁴⁸, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтран баталсан А-224/А-102 тоот тушаалд⁴⁹ тус тус зааж өгчээ.

Олон улсын болон дотоодын хууль тогтоомжоор цагдаагийн албан хаагч жагсаал, цуглааныг албадан тараахдаа хуулинд заасан үндэслэл журмын дагуу хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн тусгай хэрэгсэл хэрэглэн зогсоох боломжийг зохицуулсан байдаг.

⁴⁵Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 14-р зүйлийн 3 дахь хэсэг

⁴⁶Шинэчлэн баталсан Цагдаагийн албаны тухай хуулийн 2-р бүлгийн 12-р зүйлийн 12.1.2 дахь заалт

⁴⁷ЦБҮАЖ код-500 /Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах журам/ -ийн 500.6.1 дэх заалт

⁴⁸Шинэчлэн баталсан Цагдаагийн албаны тухай хуулийн 5-р бүлгийн 47-58-р зүйл

⁴⁹ХЗДХС, УЕП-ын 2017.09.06-ны өдөр хамтран баталсан А-224/А-102 тушаалын 1-р хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”

Тусгай хэрэгсэл нь хүний амь насанд аюулгүй ангилалд багтах боловч хэрэглэх журам, зааврыг зөрчиж буюу хэтрүүлэн хэрэглэвэл хүний амь нас, эрүүл мэнд хохирно гэдгийг ямагт санах хэрэгтэй. Тиймээс тусгай хэрэгслийг тусгайлан боловсруулж баталсан журам, нарийн заавар, удирдамжийн дагуу хэрэглэх ёстой.⁵⁰

Жагсаал цуглааныг албадан тараахад цагдаагийн байгууллага нь албаны зэвсэглэмжинд хүлээн авч бүртгэсэн тусгай хэрэгслийг хэрэглэдэг бөгөөд тэр дундаа олон хүмүүсийн хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, баривчлах саатуулах үедээ олон хүнд нэг зэрэг нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэдэг байна.

Өнөөдөр цагдаагийн байгууллага нь дараах төрлийн олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг албаны үйл ажиллагаандаа хэрэглэж байна⁵¹. Үүнд:

- Олон хүнд нэгэн зэрэг нөлөөлөх амьсгал боогдуулагч, нулимс асгаруулагч
- Утаан хөшиг үүсгэгч
- Усан хөөрөг
- Бусад тусгай хэрэгсэл

“Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл”- нөхцөл байдлыг хяналтдаа авах зорилгоор хоёр ба түүнээс дээш хүнд нэгэн зэрэг хэрэглэх боломжтой хэрэгслийг хэлнэ.

Олон хүнд зэрэг нөлөөлөх нулимс асгаруулагч: Энэ нь хоёр буюу түүнээс дээш хүнд нэгэн зэрэг нөлөөлөх хамрын самсаа, нулимсны булчирхайг цочроодог /хий, шингэн төлөвтэй байдаг/

Олон хүнд зэрэг нөлөөлөх амьсгал боогдуулагч: Энэ нь хоёр буюу түүнээс дээш хүнд нэгэн зэрэг нөлөөлөх амьсгалын замын эрхтнээр дамжин уушгинд хүрч ханиалгах, хоолой боох үйлчлэлтэй байдаг /шингэн, хий төлөвтэй байдаг/

Усан хөөрөг: Энэ нь усыг өндөр даралтаар хүчтэй цацаж сөрөг үйлдлийг сарниулна.

Утаан хөшиг үүсгэгч: Энэ нь үзэгдэх орчныг хязгаарлах зорилгоор утаан хөшиг үүсгэх бодис /гар бөмбөг, сум, утаа, шүршүүр хэлбэртэй байж болно/ Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэхийн өмнө тусгай хэрэгсэл хэрэглэх үндэслэл байгаа эсэхийг заавал тодорхойлно. Үндэслэлтэй шаардлага байгаа тохиолдолд тусгай хэрэгслийн төрөл, тоо, хэмжээ, хэрэглэх хүрээ, дэс дараа, тактикийг сонгоно.

Түүнчлэн олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэх талаар прокурорын байгууллагад урьдчилан мэдэгдэх хэрэгтэй.⁵²

Хууль бус жагсаал, цуглааныг цагдаагийн байгууллага нь албадан тараахдаа нэн түрүүнд хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон жагсаал, цуглаан хийх эрх, үндсэн хуульд заасан хүний амь нас, эрүүл мэнд, эрх, эрх чөлөөг хангах чиглэлийг баримтлан ажилладаг.

Иймээс жагсаал, цуглаан хийж буй этгээдүүд нь эрхээ хэтрүүлэн хэрэглэх тохиолдол нь хүний эрхийг хуулийн дагуу зөрчиж байгаа явдал юм.

⁵⁰ I дүгээр зүйл, НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд, 1990 он

⁵¹ Шинэчлэн баталсан Цагдаагийн албаны тухай хуулийн 5-р бүлгийн 53-р зүйлийн 53.1 дэх заалт

⁵² ХЗДХС, УЕП-ын 2017.09.06-ны өдөр хамтран баталсан А-224/А-102 тушаалын 1-р хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-ын 4-р зүйлийн 4.2.5 дахь заалт

Түүнчлэн тусгай хэрэгслийг хэрэглэхдээ удирдах албан тушаалтны байнгын хяналтанд байж гагцхүү зайлшгүй шаардлагатай үед ашиглагдах ёстой. Тусгай хэрэгсэл хэрэглэхийн өмнө болон хэрэглэсний дараа нарийн бүртгэл хөтөлж хууль бусаар буюу хяналтгүйгээр, өөр зорилгоор ашиглах явдлаас зайлсхийх хэрэгтэй.

Хууль бус жагсаал, цуглааныг тайван замаар хохирол багатай зохицуулан тараах нь цагдаагийн байгууллагын удирдлагын нэн тэргүүнд тавих зорилго байдаг.

Цагдаагийн алба хаагчид нь аливаа хууль бус жагсаал цуглааныг албадан тараах үед ажиллахдаа хамгаалах тусгай хэрэгслийг бүрэн гүйцэд ашиглах хэрэгтэй. Шаардлагатай тохиолдолд олон хүнд зэрэг нөлөөлөх усан хөөрөг, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, утаан хөшиг үүсгэгчийг ашиглахад бэлэн байлгана.

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэхдээ дор дурдсан үндэслэл бүхий нөхцөлд хэрэглэхээр олон НҮБ-ийн эрх зүйн баримт бичиг болон дотоодын эрх зүйн актуудад тусгасан байна. Тодруулбал:

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэх тохиолдлууд: Олон улсын зохицуулалт нь⁵³

- Хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд бодит хохирол учрах аюул
- Өөр арга, хэрэгсэл хэрэглэх нь үр дүнгүй буюу зайлшгүй нөхцөлд
- Хүч буюу тусгай хэрэгсэл хэрэглэх нь хуулийн биелэлтийг хангахад чиглэсэн байх

Монгол улсын зохицуулалт⁵⁴

- ✓ нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох;
- ✓ нийгмийн хэв журмыг бүлэглэн зөрчиж байгааг таслан зогсоох;
- ✓ байгууллага, иргэдийн мэдэлд байгаа барилга байгууламж, орон байрыг эзлэн авсан, гудамж, замын хөдөлгөөнийг бүслэн хаасныг чөлөөлөх;
- ✓ хориглон эсэргүүцэж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг баривчлах;
- ✓ цагдаагийн алба хаагч болон бусад хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон;
- ✓ цагдаагийн болон дотоодын цэргийн хамгаалалтад байгаа объект руу нууцаар нэвтрэн орсон, эсхүл зэвсэг хэрэглэн буюу бүлэглэн довтолсон;
- ✓ хүнийг барьцаанд авсан;
- ✓ ялтан, цагдан хоригдогч оргосон, хүнд, онц хүнд гэмт хэрэгт сэжиглэгдсэн этгээд зугатсан;
- ✓ галт зэвсэг, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болох бусад зүйлээр зэвсэглэсэн этгээд зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлэн эсэргүүцсэн;
- ✓ хуяглан хүргэж яваа этгээдийг суллахаар зэвсэг хэрэглэн, эсхүл бүлэглэн довтолсон;

⁵³4, 9 дүгээр зүйл, НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд, 1990 он

⁵⁴Шинэчлэн баталсан Цагдаагийн албаны тухай хуулийн 5-р бүлгийн 54-р зүйлийн 54.2 дахь заалт

- ✓ хорих, цагдан хорих, баривчлах байранд нийтийн эмх замбараагүй байдал гарч, хүний амь нас, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах бодитой нөхцөл байдал бий болсон.

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэхээс өмнө анхааруулга⁵⁵

Нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, нийгмийн хэв журмыг бүлэглэн зөрчиж байгааг таслан зогсоох, жагсаал, цуглааныг албадан тараах шийдвэрийг биелүүлэх, байгууллага, иргэдийн мэдэлд байгаа барилга байгууламж, орон байрыг эзлэн авсан, гудамж, замын хөдөлгөөнийг бүслэн хаасныг чөлөөлөх тохиолдолд олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэхийн өмнө урьдчилан анхааруулна.

Урьдчилан анхааруулахдаа тодорхой хугацаа зааж, чанга яригчаар зарлах зэрэг боломжтой аргыг хэрэглэнэ.

Урьдчилан анхааруулснаас хойш заасан хугацаанд үйлдлээ зогсоогоогүй бол тусгай хэрэгсэл хэрэглэнэ. Гэхдээ тухайн ажиллагаа, бүлгийг удирдаж байгаа албан тушаалтны шийдвэрээр урьдчилан анхааруулахгүй хэрэглэж болно⁵⁶.

Эсэргүйцлээ зогсоох хугацаа өгөх:

Цагдаагийн байгууллага, алба хаагч нь анхааруулга өгсөний дараа тэдэнд сайн дураараа тарж явах бололцоо олгоно. Энэ нь уг жагсаалыг сонирхогч иргэд, хөндлөнгийн хүмүүс тусгай хэрэгсэлийн нөлөөнд өртөхөөс сэргийлнэ. Цагдаагийн байгууллага, алба хаагч нь олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэхдээ анхааруулга өгөхөөс гадна тэдгээр жагсаалд оролцогчид, сонирхогчдыг чөлөөтэй тарж явах бололцоог олгож гарах, явах гарцыг нээсэн байна.

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх үед:

Хамгийн бага хохирол учруулахыг эрмэлзэх⁵⁷

Тусгай хэрэгсэл хэрэглэж байгаа зорилго нь тухайн эсэргүйцлийг няцаах, хяналтандаа авах, таслан зогсооход чиглэгдсэн байдаг тул аль болох бага хор уршиг учруулах. Эсэргүүцэл зогссон үед дахин хэрэглэхгүй байх

Хүний амь нас, нэр хүндэд хүндэтгэлтэй хандаж илүү их хохирол учруулахгүй байх⁵⁸

Хэдийгээр тухайн эсэргүүцэгч этгээд чулуу, мод, шил, төмөр шидсэн бусдын амь нас эрүүл мэнд, эд хөрөнгөнд халдсан ч гэсэн түүнийг барисан тохиолдолд иргэдийн урд гаргасан үйлдэлд өширхөх маягаар зодох, дэглэх үйлдэл хийж болохгүй. Түүнчлэн эмх замбараагүй байдалд оролцоогүй энгийн буюу хөндлөнгийн хүмүүсийн аюулгүй байдлыг хангаж ажиллах хэрэгтэй. Шүүхээр гэм буруутай нь тогтоогдоогүй үед хэнийг ч гэм буруутайд тооцож болохгүй гэсэн зарчмыг баримтлах.

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсний дараа эмнэлгийн туслалцааг гэмтэж бэртсэн хүн бүрт яаралтай үзүүлж шаардлагатай арга хэмжээ авах⁵⁹ /өмнө үйлдсэн үйлдэлээс үл хамаарна/

⁵⁵10 дугаар зүйл, НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд, 1990 он

⁵⁶ХЗДХС, УЕП-ын 2017.09.06-ны өдөр хамтран баталсан А-224/А-102 тушаалын 1-р хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-ын 4-р зүйлийн 4.3 дахь заалт

⁵⁷5 /б/ дугаар зүйл, НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд, 1990 он

⁵⁸5 /б/ дугаар зүйл, НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд, 1990 он

⁵⁹5 дугаар зүйл, НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд, 1990 он

Тухайн этгээдийн жагсаал, цуглаан дээр гаргасан авир байдлыг үл харгалзах ба хохирсон хэнд ч болов туслах /цагдаа, үймээн гаргагч, жагсагч, жирийн иргэн, сонирхогч г.м/.

Тусламж шаардлагатай хүнд газар дээр нь анхны тусламж үзүүлж, эмнэлэгийн байгууллагад хүргэх арга хэмжээг цаг алдалгүй авах, хордсон хүн амьтан гал түймэр гарах эх үүсвэр байгаа эсэхийг шалгаж холбогдох арга хэмжээ авах, иргэдэд зөвлөгөө өгөх⁶⁰

Дээд буюу удирдах албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх

Тусгай хэрэгсэл хэрэглэсэн талаар өгөгдсөн үүргийг хэрхэн биелүүлсэн талаар шуурхай удирдлагын штабт илтгэнэ.

Бэртэж гэмтсэн хүнийн ар гэрийхэн болон ойр дотны хүмүүст нэн даруй мэдэгдэх⁶¹

Жагсаал, цуглаанд оролцогчид болон иргэд нь хэдийгээр хууль бус үйлдэл хийж хэрцгий авирласан байлаа тусгай хэрэгсэлийн нөлөөлөлд өртөж гэмтэж бэртсэн бол цагдаагийн байгууллагаас уг этгээдийн хэн болохыг тогтоож, ар гэрийнхнийх нь хаяг, утасны дугаарыг тодруулан түүний ар гэр, хамаатан садан, найз нөхдийн аль нэгэнд яаралтай мэдэгдэх арга хэмжээ авна.

Уг хүний талаар ямар шийдвэр гарч хаана байгааг нь мөн дуулгана

Хүч хэрэглэсний дараа үзүүлэх эмнэлгийн анхны тусламж

Цагдаагийн байгууллагын алба хаагч албан үүрэг гүйцэтгэх явцдаа галт зэвсэг, тусгай хэрэгслийг бусад хүч хэрэглэсэн тохиолдолд наад захын эмнэлгийн анхны тусламж үзүүлэх шаардлагатай.

Ер нь ямар ч осол аюул тохиолдсон үед анхны тусламжийг зөв, тодорхой дэс дараалалтайгаар үзүүлэх явдал нь цагдаагийн ажилтны мэдлэг, ур чадварын нэг үзүүлэлт мөн.

Анхны тусламж гэдэг нь аливаа осол гэмтэл, гэнэтийн биеийн хямрал, өвчин эмгэгийн үед эмнэлгийн тусламж иртэл гарын доорх материалыг ашиглан өөртөө болон нөхөртөө, бусад хүнд үзүүлэх тусламжийг хэлнэ.⁶²

Өөрөөр хэлбэл эмнэлгийн мэргэжлийн бус жирийн ард иргэдийн өөртөө болон нөхөртөө үзүүлж байгаа тусламжийг анхны тусламж гэж нэрлэх ба үүнийг эмнэлгийн мэргэжлийн түвшинд үзүүлж байгаа анхны тусламжаас ялгаж ойлгох хэрэгтэй.

Анхны тусламжийг зөв үзүүлснээр тухайн хүний амь насыг аврах, осол гэмтлээс шалтгаалсан бусад хүндрэлүүдээс сэргийлэх, эдгэрэлтийг түргэсгэх, эмчилгээний зардлыг бууруулах, хөдөлмөрийн чадвар алдалтын хугацааг богиносгох зэрэг эерэг үр дагаврыг бий болгоно.

Хууль бус жагсаал цуглаанд нас, хүйс харгалзахгүй олон тооны хүмүүс оролцож байдаг тул тусгай хэрэгсэл хэрэглэсний дараа дээрх арга хэмжээг түргэн шуурхай авах нь цагдаагийн алба хаагчийн хариуцлагатай үйл ажиллагаа юм.

Дүгнэлт

Цагдаагийн байгууллага нь хууль бус жагсаал, цуглааныг албадан тараахдаа холбогдох хууль тогтоомжийг баримтлан түүнд тулгуурлан үйл

⁶⁰Шинэчлэн баталсан Цагдаагийн албаны тухай хуулийн 5-р бүлгийн 54-р зүйлийн 54.6 дахь заалт

⁶¹5 дугаар зүйл, НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд, 1990 он

⁶²Осол гэмтлийн үед анхны тусламж үзүүлэх журам ЦБҮАЖ-код-209

ажиллагаагаа явуулах нь учирч болох сөрөг дагавараас урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ болох юм.

Мөн албаны тусгай хэрэгслийг хэрэглэхдээ ашиглах аргачлал болон холбогдох аюулгүйн арга хэмжээг баримтлан ажиллах шаардлагатай билээ. Энэ нь алба хаагчийн эрх зүйн баталгааг хангах үндсэн нөхцлийг бүрдүүлж байна.

НҮБ-ийн байгууллагаас гаргасан холбогдох олон улсын гэрээ, конвенцийг албаны үйл ажиллагаандаа хэвшүүлж баримтлан мөрдлөг болгон ажиллах нь хүний эрхийг хангах үндсэн нөхцлийг бүрдүүлж түүний баталгаа нь болж өгнө.

Санал

1.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд баримталж байгаа хууль тогтоомж, эрх зүйн акт болон НҮБ-ийн хүний эрхийн талаархи конвенц,эрх зүйн баримт бичгийн талаар нэгдсэн сургалтыг холбогдох байгууллагатай хамтран алба хаагчдад зохион байгуулах ялангуяа эрх зүйн баримт бичгүүд шинэчлэгдэх бүрт сургалт хийж байх;

2.Цагдаагийн албанд ашигладаг олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийн үр нөлөө, хор уршгийг алба хаагч нэг бүрт мэдрүүлэх, ойлгуулах ингэснээр тухайн нөхцөл байдалд зөв үнэлгээ өгч хэрэглэх ур чадварыг дээшлүүлэх;

3.Бусад улс орны цагдаагийн байгууллага нь хууль бус жагсаал, цуглааныг хэрхэн ямар байдлаар албадан тараадаг, ингэхдээ ямар арга хэмжээ, зарчим баримталдаг талаархи туршлагыг нь судлах, түүнд тулгуурлан алба үйл ажиллагаандаа өөрчлөлт, шинэчлэлтийг тухай бүр хийж байх.

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ТӨРӨЛ, ХЭЛБЭР, АРГА

Ц.Наранчимэг

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн тэнхимийн
ахлах багш, доктор (Ph.D) цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга

Уг өгүүллээрээ гэмт явдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын өнөөгийн чиг хандлага-нөлөөллийн арга, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үүргийн тухай ойлголт, төрлийн талаар товч авч үзлээ.

Түлхүүр үгс: Гэмт хэрэг, урьдчилан сэргийлэх, гэмт явдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий, тусгай, нэг бүрчилсэн арга хэмжээ

Үндсэн хэсэг

Хүн бол нийгмийн амьтан билээ. Нийгэмд амьдрах хувь тавилан хүнийг хүссэн ч, эс хүссэн ч ялгаагүй, бусадтай хамтран аж төрөхөөс өөрөөр байх боломжгүй, тийм нэг гарцаагүй байдалд хүргэдэг байна. Хүн тийнхүү нийгэмд амьдрахдаа зөвхөн өөрийн зоргоор авирлаж, дур хүслээ хангаж эхэлвэл сөргөлдөн зөрчилдөж, цаашдаа хамтдаа байх боломжгүй болно. Тийм учраас үйлдэж болох хийгээд болохгүйн хэмжүүр тогтоож, хүмүүний үйлийг хянах хэрэгцээ гарна. Үүнийг нийгмийн дэг журам хэмээн нэрлэсээр нэгэнт заншсан

байх ажаам⁶³. Тиймээс нийгмийн дэг журам зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг гэмт явдал хэмээн ойлгож, нийгмийн тогтолцоо өөрчлөгдөх, хөгжихийн хэрээр түүний хүн төрөлхтөнд учруулах аюул, занал нэмэгдэх төлөвтэй болсон тул гэмт явдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил чухлаар тавигдаж гадны орны судлаачид дараах саналуудыг дэвшүүлсэн байна. Тухайлбал

- Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гэж утгачлан ялгах хэрэггүй, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гэсэн ерөнхий ойлголтын ижил утга, гэхдээ тодорхой семантик ялгаа бол бий гэж үздэг.
- Хэдийнэ болсон үйл явдлыг урьдчилан сэргийлэх боломжгүй ч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нэр томъёо бол онолын тогтсон хэллэг болж, ихэнх үйл ажиллагаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нэрээр зохион байгуулагддаг.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил бол хүмүүнших боломжтой гэмт хэрэгтнүүдийг нийгэмшүүлэх, тэднийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэмт явдалтай тэмцэх төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгчид, олон нийтийн байгууллага, бусад хүмүүс хамтран гүйцэтгэх арга хэмжээний тогтолцоо юм.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь (предотвращение преступлений) гэмт этгээд тодорхой гэмт үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхээр төлөвлөх, бодож боловсруулж байгаа эхний шатанд түүний гэмт үйл ажиллагаа-санаа бодлыг таслан зогсооход оршино, өөрөөр хэлбэл тухайн үйл ажиллагаа хэрэгжиж, гэмт этгээд эрүүгийн шийтгэл хүлээхээс өмнө таслан зогсооно гэсэн үг гэх мэтээр тэмдэглэсэн байна⁶⁴

Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ойлголт нь өргөн, явцуу утгаар ойлгогдож өргөн утгаараа профилактика (урьдчилан сэргийлэх) предупреждение (урьдчилан сэргийлэх) ижил утгыг илэрхийлж харин явцуу утгаараа профилактика (урьдчилан сэргийлэх) нь тодорхой гэмт үйл ажиллагааны шалтгаан, нөхцлийг арилгах, илрүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ байхаас гадна урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй гэмт этгээдүүдийг тогтоохыг илэрхийлнэ. Энэ үйл ажиллагаа нь гэмт явдлаас иж бүрэн сэргийлэх шатлалын нэг хэсэг нь болно.

Гэмт явдлын шалтгааныг тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан гэж ангилахаас гадна хүч хэрэглэсэн, шунахай, болгоомжгүй гэмт хэргийн шалтгаан, нийгмийн амьдралын янз бүрийн хүрээнд (гэр бүл, үйлдвэр, сургууль, ахуйн орчин гэх мэт) үйлдэгдэн гарсан гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг шинжлэх ухааны үндэстэй ангилан судлах нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх онол, практикийн чухал ач холбогдолтой.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь нийгмийн үйл ажиллагааны төрөл болохынхоо хувьд тодорхой үүргүүдтэй. Тухайлбал

- Хамгаалах (хүний амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгө, хууль зөрчсөн бусад халдлагаас урьдчилан сэргийлэх)
- Урьдчилан сэргийлэх (гэмт хэрэг гаргахгүй байхад чиглэсэн урьдчилан сэргийлэх ажил)

⁶³ Ц.Наранчимэг. Цагдаагийн алба хаагчийн ёс зүй. УБ. 2014. 14 дэх тал

⁶⁴ Криминология: Учебник для вузов / Под общ. ред. А. И. Долговой. 3-е изд., перераб. и доп. М., 2007. С. 435—436.

- Тогтмолжуулах (ёс суртахуун, эрх зүйн хэм хэмжээний харилцан хамаарлаар хүмүүсийн зан төлвийг тогтворжуулах урьдчилан сэргийлэх ажил)
- Хүмүүжүүлэх (хүмүүсийн ухамсарт мэдлэг, хүндлэл, эрх зүй, ёс суртахууны хэм хэмжээг дагаж мөрдөх хүмүүжлийг төлөвшүүлэх)

Гэмт этгээд гэмт хэрэг үйлдэх хэрэгсэл, зэвсгээ бэлтгэх, хань хамсаатан хайх, гэмт хэрэг үйлдэх хуйвалдаан зохион байгуулах бэлтгэл үе шат, мөн гэмт халдлагаар зорилгодоо хүрсэн, хор хохирол учруулсан байх аль алиныг гадаад үйлчлэлээр таслан зогсоох нь гэмт хэргийг таслан зогсооход чухал байр суурь эзэлнэ. Гэмт хэргийн нийгэмд учруулж буй хохирол маш их, эд материалын хохирол учруулаад зогсохгүй хүмүүс амь, амьдралаараа алуурчдын гарт хохирч байна.

Гэмт хэргийн түвшин их байхын хэрээр хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг хангах хөндлөнгийн зардал өндөр байх бөгөөд гэмт хэргээс урьдчилан сэргийлснээр уг зардлыг багасгах боломжтой. Энэ нь гэмт этгээдийн үйлдлийг эрт үед нь урьдчилан сэргийлснээр “бага цус гарах”, гэмт этгээдийг эргэн нийгэмшүүлэх, түүнийг нийгмийн хэвийн амьдралд нь буцаах нөхцөл бүрдэхэд ач холбогдолтой юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, олон нийтийн хүчинд түшиглэх, иргэд оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд энэ талаар зохион байгуулж байгаа ажилд оролцох, аж ахуйн нэгж, байгууллага дотооддоо болон үйл ажиллагааныхаа хүрээнд гэмт хэрэг гарах шалтгаан, нөхцлийг арилгах ажлыг хариуцан зохион байгуулах зарчимд тулгуурлана. АНУ-д гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны түвшинд үзэж урлаг хэмээн тодорхойлжээ⁶⁵.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааны төрөл, хэлбэр, арга

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь: гэмт хэргийн хохирогч тодорхой иргэн болон нийгэмтэй бүхэлдээ холбоотой гэмт хэргийн шалтгаан, нөхцөлд нөлөөлөх замаар илрэн гарна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг гүйцэтгэхдээ дор дурдсан нөлөөллийн аргаар шийдвэрлэж болох юм:

- Нийгэмтэй бүхэлдээ болон тодорхой иргэдтэй холбоотой шалтгаан нөхцөл гэмт хэргийн хүчин зүйлс, түүний төрөлд нөлөөлөх нөлөөлөл
- Хохирогчийн зан төлвийг сайжруулахад чиглэсэн гэмт хэргийн хохирогчийг урьдчилан сэргийлэх төрөлд нөлөөлөх нөлөөлөл
- Гэмт явдал, гэмт хэрэгтнүүдийг тодорхойлох үйл явц, зохион байгуулалттай гэмт хэрэг мэтчилэн гэмт явдлын аюултай төрөлд чиглэсэн тусгай нөлөөлөх нөлөөлөл

Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажил нь ерөнхий, тусгай, нэгбүрчилсэн гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ гэсэн 3 төрөлд хуваагдах бөгөөд энэ төрлүүд нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн объектоороо ялгагддаг.

Ерөнхий урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээ гэдэг нь иргэдийн материаллаг амьдралын байдал, соёл, боловсролын хэмжээг дээшлүүлэх замаар гэмт явдлын шалтгаан нөхцлийг арилгахад чиглэгдсэн дэс

⁶⁵ Crime Prevention Work of the Police Force

дараалалтай цогцолбор үйл ажиллагаа, чиг шугамыг хэлнэ. Энэ нь манай оронд төр засгаас авч явуулж буй арга хэмжээг ханган биелүүлэх үндсэн дээр эдийн засаг, улс төр, үзэл суртал, эрх зүйн шинжтэй бүхий л арга хэмжүүнүүдийн нийлбэр цогцоор тодорхойлогдоно⁶⁶.

Товчхондоо, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээ нь гэмт хэргийг гаргуулахгүй байх зорилгоор гэмт явдлын шалтгаан, нөхцлийг бууруулах, арилгахад чиглэгдэх юм. ОХУ-ын гавьяат хуульч Азалия Ивановна Долгова гэмт хэргээс урьдчилан сэргийлэх **ерөнхий арга хэмжээний** дараах аргууд байна гэж авч үзжээ⁶⁷. Тухайлбал

- Гэмт хэргээс эртнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ энэ нь гэмт хэргийн нийгмийн хүчин зүйлсийн өсөлтийг урьдчилан таамаглах таамаглалын үндсэн дээр боловсрогдож, хэрэгжүүлэхүйц идэвхтэй шинж чанарыг илэрхийлэх ёстой.
- Гэмт хэргээс шууд урьдчилан сэргийлэх гэдэг нь нийгэмд бий болсон гэмт хэргийн хүчин зүйлсийг саармагжуулахад чиглэгдэнэ. Жишээлбэл, санхүү, эдийн засгийн үйл ажиллагааг тогтворжуулах хууль тогтоомжийн боловсронгуй бус байдал нь эдийн засгийн “саарал” схем бий болоход хүргэж шууд хууль зөрчихгүй ч бараа товарийн эргэлт, санхүүгийн урсгал улсын хяналтаас гардаг.
- Ийм схемүүд эдийн засгийн гэмт үйл ажиллагааны тогтолцоонд амархан өсч авилга бий болж зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдэгдэх үндэслэл нь болно.
- Иймээс эрх зүйн талбарт: (хууль тогтоомжийг боловсронгуй болгох, эдийн засгийн үйл ажиллагаа, татвар, санхүүгийн өршөөл үзүүлэхтэй холбоотой) хууль дүрмийг хялбаршуулахад субъектүүдийн ижил төстэй ангиллыг буцаан хэрэглэхэд чиглэгдсэн арга хэмжээнүүд чухал байр суурь эзэлнэ.
- Гэмт хэргийн өөрөө өөрийгөө тодорхойлох гэдэг нь зохион байгуулалттай гэмт хэргийг зохион байгуулах үйл ажиллагааг мөн нийгмийн бүлэглэл, шинэ хүмүүсийн гэмт хэргийн оролцоогоор хувь хүний гэмт хэргийг таслан зогсоохыг хэлнэ.
- Гэмт хэргийн өөрөө өөрийгөө тодорхойлох нь төр, нийгмээс авахуулаад нийгмийн бүхий л түвшинд (гэмт хэргийн үйл ажиллагаагаа хөнгөвчлөхийн тулд гэмт бүлэглэлүүд хуулийг лоббидох гэх мэт) болон хувь хүмүүсийн хоорондын холбоонд илэрнэ гэж тодорхойлсон.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын өгөөж, үр дүнг дээшлүүлэхэд ерөнхий болон тусгай арга хэмжээнүүдийн объектыг зөв сонгох, шийдвэрлэх асуудлын хүрээнд нарийн судалгаа хийх, субъектүүдийн хүч, нөөц, тэмцлийн арга хэлбэр, хэрэгслэлийг төвлөрүүлэх, нийгэм эдийн засгийн хөгжлийн төлөв байдал, гэмт хэргийн шалтгаан нөхцлийн мэдээ мэдээллийг солилцон харьцуулсан дүн шинжилгээ хийх явдал чухал байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээ гэдэг нь гэмт хэрэгт нөлөөлж буй хүчин зүйл /үзэгдэл, үйл явц/ тэдний байдал, бүтэц, шинж чанараас шалтгаалж захиргаа, нутаг дэвсгэр, аж ахуйн салбар, объектод

⁶⁶ Н.Жанцан. Криминологи, УБ.2000, 68

⁶⁷ Криминология: Учебник для вузов / Под общ. ред. А. И. Долговой. 3-е изд., перераб. и доп. М., 2007. С. 430-438;

нөлөөлөх нөлөөллийн хэр хэмжээг, түүний онцлогийг тусган ажиллах арга хэмжээ юм.

Тусгай арга хэмжээний хүрээнд зохиогдох урьдчилан сэргийлэх арга хэмжээнд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг илрүүлэх, мөрдөн байцаах, ял шийтгэл ногдуулах, засч хүмүүжүүлэх зэрэг үйл ажиллагаатай холбогдож гарч ирсэн гэмт хэрэгтэй явуулах эрүүгийн эрх зүйн тэмцэл чухал байр суурь эзэлнэ.

Тусгай арга хэмжээ нь хэдийгээр үйлдэгдэж өнгөрсөн гэмт хэргийн хувьд хэрэгжигдэх боловч түүний нийгмийн ач холбогдол нь шинээр гэмт хэрэг үйлдэж болзошгүй тогтворгүй этгээдүүд хэрэг, зөрчил үйлдэхээс сэрэмжлэх, нийгмийн гишүүдийн зүгээс эрх зүйн зөрчилтэй явуулах тэмцлийг идэвхжүүлэн өрнүүлэх, урьд хэрэг үйлдсэн этгээд шинээр дахин хэрэг үйлдэх явдлаас урьдчилан сэргийлэхэд оршино.

Зарим төрлийн гэмт хэрэг /жишээлбэл, насанд хүрээгүй хүмүүсийг согтууруулах ундаанд татан оролцуулах, хутга, мэс бусад зэвсгийг гэмт хэрэг үйлдэх зорилгоор хийж бэлтгэх буюу биедээ авч явах, хадгалах/ даамжран гарч хүнд гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнө эрүүгийн хариуцлагад татаж түүнийг таслан зогсоох, гэмт хэрэг гарах боломж бололцоо, нөхцөл байдал, тохироо, гэмт хэрэгт нөлөөлөх хүчин зүйлсийг устгаж арилгах зорилгоор зарим төрлийн нэмэгдэл ялыг тусгай урьдчилан сэргийлэх арга хэмжээ болгон хэрэглэдэг байна.

Тусгай урьдчилан сэргийлэх арга хэмжээг түүний эзлэх байр, цар хүрээ, хэмжээгээр нь:

- Улсын хэмжээний
- Тодорхой засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн
- Нийгмийн их, бага, тодорхой бүлгийн
- Нийгэмд харш зан төлөвтэй болох нь тогтоогдсон тодорхой хэсэг этгээдэд чиглэгдсэн
- Тодорхой гэмт этгээдээс үйлдсэн хэргийн шалтгаан нөхцлийг арилгахад чиглэгдсэн нэгбүрчилсэн арга хэмжээнүүд хамаарна

Иймээс нэг буюу хэсэг бүлэг этгээдийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор авч явуулж байгаа тусгай арга хэмжээний энэ төрлийг нэгбүрчилсэн арга хэмжээ гэнэ.

Нэгбүрчилсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээгээр ялангуяа криминологийн тусгай арга хэмжээний хүрээнд өөртөө ёс суртахууны болон төрийн албадах арга хэмжээний элементүүдийг хослуулан хэрэглэдэг. Иймээс чухамхүү ямар трохиолдолд ямар арга хэлбэрийн арга хэмжээ хэрэглэх асуудлыг тодорхойлох явдал чухал байна. Үүнд:

- Урьд нь хэрэг үйлдсэн хүний хувьд түүнийг засч хүмүүжүүлэх, давтан хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
- Урьд нь эрүүгийн хэрэг үйлдээгүй хүний хувьд чухам ямар төрлийн зөрчил гаргадаг зан төлөв, ёс суртахууны доголдлыг судлан тогтоож түүнийг засч залруулахад чиглэгдсэн оновчтой арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Уг этгээдийн өөрийн зан төлөвт нь хэдийгээр сөрөг шинж байдал, ёс суртахууны гүнзгий доголдол илрээгүй боловч гэр бүл дэх тааламжгүй нөхцөл байдал, аж байдлын хүрээн дэх сөрөг элементүүд түүний зан байдал, нийгмийн үйлдэлд муугаар нөлөөлж байгааг арилгах арга хэмжээ авах замаар харьцах ёстой.

Нэгбүрчилсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээний үндсэн арга нь итгүүлэх арга байна, энэ нь тухайн этгээдийн нийгмийн тухай сөрөг мэдээлэлд сурган хүмүүжүүлэх болон сэтгэл судлалын аргаар нөлөөлж эерэг төсөөлөл бий болгоход чиглэгдэнэ. Итгүүлэх аргын үндэс болох нүүр тулсан чөлөөт харилцан ярилцлагыг төрөл бүрийн зорилгоор явуулж болно. Ярилцлага тухайн этгээдийн бие хүний, нийгэм ахуйн нөхцлийг тодорхойлох мэдээллийг олж авах, контакт холбоо тогтооход зайлшгүй шаардлагатай. Ярилцлага нь урьдчилан сэргийлэх болон хүмүүжүүлэх шинжтэй байна. Ярилцлагаас гадна итгүүлэх аргад тухайн этгээдийг хүмүүжлийн эерэг нөлөө үзүүлэх нийгмийн байгууллага, бүлэгт татан оролцуулж хүмүүншүүлэх аргууд байна, тухайлбал биеийн тамир, спортын секц дугуйлан, хөдөлмөрийн болон уран бүтээлийн хамт олон, олон нийтийн байгууллага гэх мэт

Мөн тусламж үзүүлэх арга нь бие хүний хөгжил ба түүний нийгэм ахуйн байдлыг сайжруулахад чиглэсэн тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой тул илүү үр дүнтэй ч хэрэгжүүлэхэд нарийн төвөгтэй байж мэдэх юм. Тухайлбал энэ ажил нь тухайн этгээдийг ажил, сургуульд хамруулах, амьдрал ахуйн нөхцлийг сайжруулах, нийгмийн таатай бичил орчныг боловсронгуй болгоход чиглэгддэг.

ОХУ-ын шинжлэх ухааны гавьяат ажилтан, хууль зүйн ухааны доктор, профессор Генрих Михайлович Миньковский гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг өөр үндэслэлээр буюу нутаг дэвсгэрийн болон нийгмийн хамрах хүрээнээс хамааран ангилж болно⁶⁸ хэмээн үзэж

- Улсын хэмжээний
- Бүс нутгийн
- Орон нутгийн (хүн амын тооноос хамааралтай)
- Хэсгийн (тодорхой байгууллагад хэрэгжүүлэх)
- Болзошгүй (нийгмийн тодорхой бүлэглэлд чиглэсэн) арга хэмжээ гэж хуваасан байна.

Зохиогч мөн урьдчилан сэргийлэх ажлыг агуулгаар нь болон нөлөөллийн үндсэн чиглэлээр нь:

- Нийгмийн баталгаа, тусламж, хүн амын амьдралын түвшинг сайжруулахтай холбоотой нийгэм эдийн засгийн арга хэмжээ
- Санхүү мөнгөний урсгалыг удирдах, аж ахуйг чиглүүлэхэд төр, албан тушаалтнуудаас авч хэрэгжүүлж байгаа шийдвэрийг хянах хяналт хүртээмжтэй, тодорхой байлгахад үндэслэгдсэн арга хэмжээ
- Хууль сахиулах байгууллага болон бусад төрийн байгууллагуудын алба хаагчдын хөдөлмөрийн зохион байгуулалтыг сайжруулахад чиглэсэн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ
- Нийгмийн итгэл үнэмшил, үнэ цэнийг мэдрүүлэх, зөв шударга зан төлөвтэй байхтай холбоотой үзэл суртал - зан суртахууны арга хэмжээ
- Нийгэм дэх сөрөг гэмт чиг хандлагыг дарах, ухаалаг хандлагыг төлөвшүүлэх нийгэм -сэтгэл зүйн арга хэмжээ, тухайлбал үндэстэнтэй холбоотой нийгмийн сүйрлийн айдас, түгшүүр ихсэх гэх мэт
- Нийгэмшээгүй субъектийн зан төлвийг засаж залруулах, сэтгэцийн тулгамдсан асуудалтай хүмүүсийг эмчлэх, нийгэмд аюул учруулахуйц

⁶⁸ Коробейников Б.В., Кузнецова Н.Ф., Миньковский Г.М. Криминология, М.1988

өвчнийг тархахаас урьдчилан сэргийлэх эмнэлгийн болон сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх арга хэмжээ

- Гэмт хэргийг хүндрүүлэх нөхцлийг бүрдүүлж байгаа техник хэрэгслийн тохиргооны асуудал (дохиолол хамгаалалт, утаанаас хамгаалах систем), түүнчлэн гэмт хэргийн үйлдлийг хянах (тооцооны кассын аппарат, хяналтын камер) техникийн арга хэмжээ
- Эрүүгийн хууль тогтоомж, гэмт хэрэгтэй тэмцэх үндэс болсон бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгохтой холбоотой эрх зүйн арга хэмжээ байна гэж хувааж авч үзсэн байдаг⁶⁹.

Дүгнэлт

Өнөөдөр гэмт хэргийг гарсан хойно нь хөрөнгө мөнгө, хүч хэрэгсэл, цаг заваа зарцуулан байж илрүүлэх, шийдвэрлэхдээ биш, харин гарахаас нь өмнө аль болох урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, эрх зүйн зөрчил гарах нөхцөл байдлуудыг арилгахад чиглэгдсэн арга хэмжээг иж бүрэн цогцолбороор нь явуулах ажил чухлаар тавигдаж байна

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чухал анхдагч түвшин бол хувь хүн болон гэр бүлийн орчин байж гэмт хэрэгт холбогдсон хүмүүст суурь хүчин зүйл нь болж байдаг. Хувь хүний сургуульд хамрагдах, боловсрол эзэмших, олон нийтийн үйл ажиллагаанд оролцох зэрэг хүчин зүйлүүд нь гэмт хэрэгт холбогдох боломжийг бууруулдаг байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн ажлын хүрээнд төрийн бус субъектэд хууль сахиулах чиглэлийн хамгаалалтын албад, хувь хүн, хууль сахиулах байгууллагуудын олон нийтийн туслахууд, аюулгүй байдлын албадууд, олон нийтийн мэдээллийн тусгай хэрэгслүүд хамаарна, өөрөөр хэлбэл практикаар бүх байгууллага, иргэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд оролцдог.

Санал

1. Гэмт явдалтай тэмцэх ажлыг улсын, олон нийтийн тодорхой субъектийн гэж ангилан удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, тухайлбал Боловсрол ТВ-ийн “Ардын буйдан” контентийг ГХУСА-ны чиглэлээр ашиглах боломжийг судлах;

2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулийн хүрээнд яам, агентлаг, төрийн бусад байгууллага, захиргааны хяналтын албад эрхэлсэн асуудлынхаа хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах үүрэгтэй гэж заасныг үндэслэн гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлах эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг үр бүтээлтэй зохион байгуулах, тухайлбал улсын хэмжээнд сэтгэцийн тулгамдсан асуудалтай иргэдийн судалгааг гарган эрүүлжүүлэх, нийгэмшүүлэхэд дээр дурдсан арга хэмжээнүүдээс хэрэгжүүлэх;

3. Хэсгийн байцаагч нар ард иргэдтэй хамгийн их ойр дотно байж, тэдний санал хүсэлтийг байнга сонсож, мэдээ мэдээлэл цуглуулан бүртгэл, судалгаандаа тогмол баяжилт хийх, иргэдийн дунд санал асуулгын хайрцаг явуулж, тэдний санал хүсэлтийг өөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж цагдаа-иргэдийн хоорондын хамтын ажиллагаанд дэмжлэг болгохын тулд тэдний орон тоог нэмэгдүүлэх зэргийг харгалзан үзэх;

⁶⁹ Коробейников Б.В., Кузнецова Н.Ф., Миньковский Г.М. Криминология, М 1988

4.Эцэст нь Чезаре Беккариа-гийн Шийтгэлээс илүүтэйгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь чухал юм, хууль тогтоомжийн зорилгыг хангахад сайн, муу харилцааны мөн чанараараа хүмүүсийн аж жаргалтай амьдрах, эсхүл зовлонтой амьдрах нь тэдний биеэ авч явах соёлоос хамаарна гэсэн үгээр өгүүллээ дуусгая.

ОБЪЕКТЫН СУДАЛГАА ХИЙХ АРГА, ТЕХНОЛОГИЙГ САЙЖРУУЛАХ ЗАРИМ АРГА

Г.Бямбадорж

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн
ахлах багш, цагдаагийн хошууч

Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүн амын төвлөрөл, барилгажилт, хот төлөвлөлт, хотын амьдралын хэв маяг, нийгмийн ёс суртахууны доройтол, хотжилтыг даган эрчимжиж буй гэмт явдлын чиг хандлага, нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөл зэргийг харьцуулан судалж цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээ онолын болон практикийн түвшинд тодорхойлж, ажиллах шаардлага зүй ёсоор тулгарч байна⁷⁰.

Цагдаагийн байгууллагын хяналтанд байх субъект түүний дотор объектын судалгааны нэг төрөл болох хорих ял эдлээд суллагдсан зарим хүнд тавих захиргааны хяналтыг цагдаагийн хэв журмын албаны алба хаагчид тухайлбал: Хэсгийн байцаагч, төлөөлөгч нар хэрэгжүүлж байгаа бөгөөд тэний захиргааны хяналт тавих үйл ажиллагаа төдийлөн үр дүнд хүрэхгүй байгаа нь нууц биш.

Гэмт хэргийн гаралтыг, хүн амын нягтаршилтай холбон авч үзэл: Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор суурин хүн амыг Монгол Улсын нутаг дэвсгэрт болон гадаадад тоологдсон гэж нарийвчилж авч үзэх боломжтой болсноороо өмнөх тооллогоос ихээхэн онцлогтой болжээ.

Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин сууж байгаа болон албан ёсны бүртгэлтэй 2647.6 мянга, гадаадад улсад оршин сууж байгаа 107.1 мянган хүн тоологдож, суурин хүн ам 2754.7 мянга болжээ. Монгол Улсын хүн ам 2000-2010 оны хоорондох 11 жилийн хугацаанд 16.1 хувиар өсч, жилийн дундаж өсөлт нь 1.5 хувь болсон байна. Өсөлтийн энэ хувь өмнөх тооллого хоорондынхоос 0.1 пунктээр илүү болсон нь хүн амын ердийн хөдөлгөөний цэвэр өсөлт сүүлийн арван жилд илүү байсан, 1990-ээд оны эхний хагаст гадаадад олон арван мянган хүн шилжин суурьшсан шиг томоохон хөдөлгөөн гараагүйтэй холбоотой⁷¹.

Хүн амын өсөлт энэ хэвээр үргэлжилбэл Монголчууд бид 2040 гэхэд 4 сая болох судалгаа гарчээ. Монгол улсын хүн ам өсөж хотжих үйл явц эрчимтэй явагдаж байгаа цаг үеэ дагаад гэмт хэргийн гаралт нэмэгдэж байна.

⁷⁰ Цагдаа судлал сэтгүүл 2013 №3. 47 дахь тал

⁷¹ Хүн ам орон сууцны тооллогын материал 2010 он.

Ийм учраас цагдаагийн байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ ялангуяа хорихоос суллагдсан этгээдэд тавих захиргааны хяналтын үйл ажиллагаанд “Secure alert” буюу “Электрон гав”, “Полиграф”, “GPS”, “Comp.stat”, “Crime mapping”, “CCTV” Хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх төрөл бүрийн программ зэрэг орчин үеийн smart системүүдийг нэвтрүүлж ашиглах зэргээр цагдаагийн байгууллагаас хийх объектын судалгааг сайжруулж болно гэж үзэж байна. Мөн орчин үеийн техник технологи хэрэглэх талаар 2017 онд Шинэчлэн найруулсан Цагдаагийн албаны тухай хуулийн 21-р зүйл **Цагдаагийн төв байгууллагын даргын бүрэн эрх** 21.1.13-д Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд шинжлэх ухаан, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээний ололтыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах⁷²” гэж заасан нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалтыг сайжруулах эрх зүйн үндсийг зааж өгсөн байна.

Энэхүү заалтын хүрээнд цагдаагийн байгууллага өнгөрөсөн 2016 онд Цагдаагийн ерөнхий газар, Монголын дүлий иргэдийн үндэсний холбоо харилцан тохиролцон сонсголын бэрхшээлтэй иргэдээс яаралтай тусламжийн дуудлага, мэдээллийг үүрэн холбооны цахим зурвас (SMS)-аар хүлээн авах төрөөрөмж, ухаалаг цагдаа цахим гомдлын нэгдсэн систем, Увс аймгийн Улаангом сумыг ХЗДХЯ-аас 360000000 сая төгрөгийг зардлыг шийдвэрлэж камержуулсан, Нарны энергээр цэнэглэдэг, 360 градус эргэдэг өдөр шөнийн камер, хүнийг дүрс царайгаар таних камер, 3 G сүлжээ, Тээврийн хэрэгслийн мэдээллийн сан, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, хүн эд зүйлсийг эрэн сурвалжлах сангийн программ хангамж зэргийг шинэчлэн үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ашиглаж байна.

Мөн Улаанбаатар хотын цагдаагийн газрын Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтсийн хариуцсан 9 хорооны нутаг дэвсгэрт хэсгийн байцаагчийн объект, субъектын судалгааг дэлгэрэнгүйгээр Ачит-10 программд тусган үйл ажиллагаандаа хэрэглэж байгаа нь субъектын судалгааны үр нөлөөг дээшлүүлэх нэг алхам болжээ.

Уг программийн өгөгдөлд хэсгийн байцаагч, төлөөлөгчийн субъектын болон объектын бүртгэл судалгаанд түвиглэн хяналтанд байгаа хүмүүсийн байршил, зай нягтрал зэргийг харуулж хяналт тавих үйл ажиллагааг сайжруулахад тус дөхөм болсон юм. Энэхүү цахим программд оруулах мэдээллийн хэмжээ хязгаараас хамааран нэг хэлтэст 10-15 сая төгрөгний зардал тооцоологдож байгаа бөгөөд үүнийг бүх дүүрэг газар хэлтэст нэвтрүүлж ашиглах боломжтой ба энэхүү зардлыг аймаг дүүргийн ГХУСАЗ дэд зөвлөл, төрийн бус байгууллагаас санхүүжүүлэх боломжтой.

Энэхүү програмд Цагдаагийн байгууллагын объектын судалгааны нэг бүрэлдэхүүн хэсэг болох субъектын судалгаа “хорих ял эдлээд суллагдсан захиргааны хяналтанд байгаа этгээд” гэсэн цахим сангийн мэдээллийн өгөгдөл оруулж, хяналтанд байгаа иргэдийг зургийг байршуулж, цагдаагийн урамшуулалт эргүүл, олон нийтийн цагдаагийн ажилтан нар өдөр тутмын үйл ажиллагааны нэг хэсэг болгон захиргааны хяналтанд байгаа этгээдтэй уулзан зөвлөгөө өгөх тэдний зан харилцаа амьдрлын хэв маяг, эрхэлж буй ажил, гэр бүлийн харилцаа тэдний байдал зэрэгт хяналт тавьж ажилснаар цагдаагийн

⁷² legalinfo.mn. Шинэчлэн найруулсан Цагдаагийн албаны тухай хууль

байгууллагаас тавих хяналтын үр нөлөө сайжирч, тэдний зүгээс үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн гаралт буурч хяналтанд эерэг дүн үзүүнэ.

Субъектын судалгааны Ачит-10 цахим системийг нэвтрүүлснээр дараах ач холбогдолтой байна. Үүнд:

- Гэмт хэрэгтэнээ хайхад үрэгддэг үр ашиггүй цаг хугацаа зардал хэмнэгдэнэ;
- Иргэний амьд явах эрх болон аюулгүй орчинд амьдрах эрх баталгаажина;
- Гэмт хэргийн гаралт багасаж, олон нийтийн газар гудамж талбайд үйлдэгддэг танхай, дээрэм булаалт гэх мэт бусад гэмт хэрэг эрс багасанад
- Цагдаагийн алба хаагч нарын амрах цаг бага ч уртасана;
- Цагдаагийн байгууллагын нэр хүнд өсөж жинхэнэ утгаараа хяналтыг бий болгож чадна;
- Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь хэмээг нэмэгдэх зэрэг олон талын ач холбогдолтой болно.

Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж байгаа урамшилтай эргүүл, олон нийтийн цагдаагийн ажилтан нарыг цагдаагийн байгууллагын захиргааны хяналтын нэг хэсэг болох хорих ял эдлээд суллагдсан хүмүүст тавих хяналт сайжруулах зорилгоор хорооны нутаг дэвсгэрт хариуцсан гудамж талбай хэсэгтээ эргүүл хийхдээ, өөрийн гар утас таблет ашиглан хяналтанд байгаа хүний талаар цахим программ ажиллуулан мэдээлэлтэй байх, хаяган дээрээ байгаа эсэхэд хяналт тавих ажлыг зохион байгуулан ажиллах нь зүйтэй.

Ингэснээр нь хорих ял эдлээд суллагдсан этгээдэд тавих хяналт сайжирч, хэсгийн байцаагчийн субъектын судалгааны ач холбогдол нэмэгдэнэ.

Тэрчлэн үйлдэгдсэн гэмт хэргийн байдалд дүн шинжилгээ хийж аль дүүрэг хороонд ямар төрлийн гэмт хэрэг өсч байна тэр хороонд эргүүлийн чиглэлийг түлхүү ажиллуулах, хяналтын системийг түлхүү ашиглах зэрэг үйл ажиллагаагаа сайжруулах ач холбогдолтой юм.

Монгол улсын хүн амд ноогдох цагдаагийн алба хаагчийн тооноос шалтгаалж гудамж “гэмт хэрэг зөрчил үйлдэж болзошгүй этгээдүүдийн судалгаа”-нд байгаа этгээдүүдийг хянаж чадахгүй байгаа учир иргэдийн аюулгүй байдлыг хангахад нийт гудамж тайлбайг гэрэлтүүлэх, хянах, тогтолцоог сайжруулж, бүх гудамж талбай болон гэр хорооллыг цахилгааны шон дагуу камержуулж болох юм.

Тухайлбал: Английн цагдаагийн байгууллага ССТҮ системийг ашиглаж үйлдэгдсэн гэмт хэргийнхээ 90% илрүүлж чадаж байгаа бөгөөд энэхүү үйл ажиллагаандаа “Поли-фейс” системийг давхар ашиглаж байна.

Тэгэхээр нийслэл хотын дүүрэг бүрт байрлах хяналтын төв байгуулж камеруудыг хянаж, эргүүлийн үүрэг гүйцэтгэх үүрэг бүхий цагдаа нарыг гэмт хэргийн талаар тогтмол мэдээллээр хангаж, гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй эмзэг цэгүүдийг хяналтандаа авч гэмт хэргээс урьдчилан сэргийлж ажиллах.

Нөгөө талаар субъектын судалгаанд байгаа этгээдүүдийн гэрэл зургийг уг программд таниулснаар тэдний зүгээс үйлдэх гэмт хэргийг илрүүлэх боломжтой болно. Нөгөө талаар гэмт хэрэг үйлдэгдсний дараа гэмт хэрэгтэнээ хайдаг биш, гэмт хэргийг газар дээр нь илрүүлдэг, гэмт хэрэгтэнтэй хөөцөлддөг биш гэмт хэргийг урьдчилан сэргийлж, таслан зогсоох боломж бүрдэнэ.

Мөн гэмт хэргийн тоо үзүүлэлтэнд дүн шинжилгээ хийдэг европын орнуудын цагдаагийн байгууллагад хэрэглэдэг “Comp.stat” системийг нэвтрүүлж ашиглах шаардлагатай байна. Анх 1994 онд АНУ-ын Нью-Йорк хотод цагдаагийн комиссар Уильям Браттон цагдаагийн хэлтсийн мэдээлэлд суурилсан удирдлагын загварыг танилцуулсан бөгөөд энэхүү загвар нь АНУ даяар маш хурдан тархаж энэ нь гэмт хэрэг бууруулахад чиглэсэн орчин үеийн менежментийн загвар болж чадсан байна⁷³.

Comp.Stat загвар нь гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөл, стратегийн ач холбогдолтой асуудлыг шийдвэрлэх, тодорхой үйл ажиллагаанд анализ хийх, гэмт хэргийн гаралт, төрөл, гэмт хэрэг гарсан цэг бусад нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлоход ашиглагдаж байгаа мэдээ мэдээлэл, түүний үнэн зөв эсэхийг цаг хугацаанд нь дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлж байна.

Энэхүү нөхцөл байдлын үнэлгээн дээр тулгуурлан, тохирсон хариу арга хэмжээ авах, алба хаагч ажилтан болон нөөц хүчийг зохих газар хурдацтай байршуулах, байдлаар хэрэгжүүлж байна.

Comp.Stat загварын хүрээнд нь асуудлыг шийдвэрлэх, шинжилгээ хийх, хариуцлагын тухай олон давхаргат загварыг ашиглаж байна. Олон давхаргат загвар нь гэмт хэрэг бууруулах “стратегийн”-аас урт хугацааны асуудлуудыг хэрэгжүүлэх загвар юм⁷⁴.

Иймд Comp.stat системийг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлж ашигласнаар тухайн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдалд долоо хоног бүр дүн шинжилгээ хийж тухайн долоо хоногт үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэргийн төрөл, гэмт явдлын шалтгаан нөхцөл, тохироо, гэмт хэрэг үйлдэгч, хохирогч, халдлагын зүйл зэрэгт дүн судалгаа хийж объектын судалгаанд тусгаснаар цаашид авах арга хэмжээг төлөвлөж ямар гэмт зөрчил үйлдэгдэж байна түүнийг бууруулах урьчилан сэргийлэх үйл ажиллагаагаа оновчтой тодорхойлох, гэмт явдалд прогноз хийх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Өнөөгийн байдлаар цагдаагийн байгууллагын мэдээлэл судалгааны алба үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт, гэмт хэргийн төрөл, өсөлт бууралт, хэргийн ангилал, халдаж буй нийгмийн харилцаагаар нь, гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаагаар сар бүр дүн шинжилгээ хийж байгаа ч энэхүү статистик мэдээг гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд ашиглахад төдийлөн үр дүнд хүрдэггүй байна. Энэ нь үндсэндээ гэмт хэргийн статистик үзүүлэлт, ажлын тайлан хэлбэртэй л байна.

Түүнчлэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаад “Crime mapping” буюу гэмт хэргийн зураглал үйлдэх системийг бүрэн ашиглаж болно.

“Crime mapping” буюу гэмт хэргийн зураглал нь: Гэмт хэрэг явдлын гаралт, төрөл, ангилалтыг зурагт төсөөлөн харах болон гэмт явдлыг шинжлэхийн тулд хууль сахиулах байгууллага ашигладаг систем юм.

Хүмүүс анх газрын зургийг хад чулуу, агуйн хананд зурж эхлээд улмаар мал, амьтны ширийг ашиглан зурж хүрээлэн буй орчиноо таньдаг байжээ. Газрын зурагт аливаа газар орны уул, гол мөрөн, төмөр зам, онгоцны буудал, гудамж, талбайн нэрс, барилга байгууламжийг дүрсэлж харуулахаас гаднаулс орнуудын хил хязгаарыг хооронд нь заагласан байдаг тул ач холбогдлыг нь

⁷³ <http://www.compstat.umd.edu>

⁷⁴ <http://www.compstat.umd.edu>

үнэлж баршгүй юм. Газрын зургийн хөгжил дэлхийн түүхийг харуулдаг хэмээн эрдэмтэд үздэг.

Дэлхийн улс орнуудын цагдаагийн байгууллагууд гэмт хэргийн илрүүлэлт, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд гэмт хэргийн газрын зургийг ашиглаж эхлээд удаж байна. Тухайлбал: Өнгөрсөн зууны эхээр өрнөдийн улсуудын цагдаагийн байгууллагууд хариуцсан нутаг дэвсгэрийнхээ цаасан газрын зураг дээр үйлдэгдсэн гэмт хэргийг, түүний төрөл зүйлээр нь ялган өнгө өнгийн туг хатган нэвтрүүлж эхэлсэн. Тэд ийм тэмдэглэгээ хийсэн газрын зурагт тулгуурлан эрүү, хэв журмын нөхцөл байдлыг тодорхойлох задлан шинжилгээ хийн, улмаар ирээдүйд хийх ажлынхаа төсөөллийг авдаг байв.

Харин өнөөдрийн газрын зураг нь газар зүйн мэдээллийн шинжлэх ухааны ололтоор сая сая хүний гар утас, таблет, компьютерийн дэлгэцэнд багтаж, маш нарийвчлалтай харуулдаг болсон. Энэхүү технологийн дэвшлийг олон улс орны цагдаагийн байгууллагууд амжилттай ашиглаж байна.

Гэмт хэргийн газрын зураг гэдэг нь хамгийн энгийнээр өгүүлбэл гэмт хэргийн үйлдэгдсэн байршлыг газрын зурагт тэмдэглэж буй үйлдэл юм. Нарийвчилж хэлбэл гэмт хэргийн бүртгэлийг үйлдэгдсэн газартай нь уялдуулан байршуулж буй газар зүйн болон криминологийн шинжлэх ухааны мэдээллийн системийг хэлнэ.

Нэг үгээр гав, галт зэвсэг, гар чийдэн гэх мэт цагдаагийн алба хаагч нарт өдөр бүр хэрэглэгддэг хэрэгсэлтэй адил гэмт хэргийн газрын зураг нь тэдний гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн багаж болон хөгжиж байна.

Гэмт хэргийн газрын зураг

Түүх эргэн сөхвөл гэмт хэргийн газрын зургийн үндсэн санаа 1800-аад оны дунд үед Францын сэтгэл судлаач Андре Гейри, Адолф Кютлет нарын гэмт хэргийг гаралтыг бүртгэхээр оролдсон ажлынх нь үр дүнгээс эхлэлтэй.

Улмаар 1900 оны эхээр Чикагогийн их сургуулийн сэтгэл зүйч, нийгмийн ухааны эрдэмтэн, багш нар гэмт хэргийн газрын зургийг өнөөгийн түвшинд хүргэхэд их нэмэр болсон гэдэг. Тэдгээр эрдэмтдийг “Чикагогийн сургуулийн баг” гэж ч алдаршуулан нэрлэдэг. Тиймдээ ч энэхүү аргыг Иллинойс мужийн цагдаагийн газрууд 1926 оноос хүн амины гэмт хэргийг газрын зурагт “зүү” хатган бүртгэж ажилдаа анх нэвтрүүлсэн юм.

“Давтагдах хөдөлгөөний онол”⁷⁵ (Routine activity theory) нь гэмт хэргийн газрын зургийн суурь үндэслэлийг тодорхойлсон байдаг. Гэмт хэргийн тухай энэ онол нь 1950-иад оны дунд үеэс Амос Хавлеу-гээр дамжаад 1979 онд Лавренс Кохен болон Маркус Фалсон нарын хамтын бүтээлээс эхлэлтэй бөгөөд криминологийн шинжлэх ухааны нэгэн онол болон хөгжсөөр байгаа.

Онолын гол санааг маш товчхоноор өгүүлбэл гэмт үйл явдлыг хүрээлэн буй орчинтой холбож тайлбарлах арга юм. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг, зөрчил үйлдэх эрсдэлтэй, эсхүл аль хэдийнээ үйлдсэн иргэний зан авир, эцэг эхийн удамшил, хувь хүний боловсрол, хүмүүжлээс шалтгаалж гэмт хэрэг үйлдэгдэж буй эсэхийг судалдаг бусад онолоос ялгаатай. Тодруулбал “ямар төрлийн гэмт хэрэг хаана хэдэн цагт үйлдэгдээд байна вэ гэсэн” асуултад хариулт өгнө.

Жишээ нь иргэн А-гийн дэлгүүр өглөө 10 цагт онгойж орой 23 цагт хаах тогтсон цагийн хуваартай. Гэтэл өнгөрсөн жилүүдэд уг дэлгүүр удаа дараа

хулгайн халдлагад өртөж. Ингээд дэлгүүрийн байршил дээр хулгайн гэмт хэргийг илтгэсэн цэнхэр өнгийн хэд хэдэн “зүү” хатгагджээ.

Зүүг харсан цагдаагийн алба хаагч төвөггүйгээр дүн шинжилгээ хийж дэлгүүрийн орчимд гэрэлтүүлэг, манаач, камер, давхар хаалга, цонхны төмөр хаалт, цагийн хуваарийг өөрчлөх үү зэрэг дахин хулгай гаргахгүйн тулд цаашид ямар арга хэмжээг авах, юу хийх шаардлагатай вэ? Гэдэг хариултыг олно. Үүнээс улбаалж цагдаагийн явган болон машинт эргүүлийн чиглэл, хуваарь, алба хаагчийн тоо ч мөн өөрчлөгдөж байх болно. Төрийн болон төрийн бус байгууллага, иргэд юу хийж болох, хоорондоо хэрхэн хамтарч ажиллаж байх зэрэгт чиглэл болно.

“Давтагдах хөдөлгөөний онол”-ын үндэслэлээр “гэмт хэргийн газрын зураг” хэмээх аргыг цагдаагийн байгууллагууд хот, суурин газар гэлтгүй орон нутагт бүртгэгдэж байгаа гэмт хэргийг бууруулах зорилгоор өргөнөөр ашиглаж байна. Тухайлбал: Австрали, Бразил, Канад, Энэтхэг, Япон, Норвеги, Их Британи зэрэг олон орны цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үндсэн үүрэгтээ ашиглаж байгаа бол АНУ-д 1998 оны байдлаар хууль сахиулах байгууллагуудын 75% нь ажилдаа нэвтрүүлсэн тухай мэдээ байна⁷⁶.

Тэд 1990-ээд оноос гэмт хэргийн цахим газрын зургийг компьютерийн тусламжтайгаар үүсгэн ашиглаж эхэлсэн бөгөөд түүнээс хойш зарим хотууд тодорхой төрлийн гэмт хэргийн түвшинг 20% хүртэл бууруулжээ.

Гэмт хэргийн газрын зургийг нэвтрүүлэх шаардлага

Манай улсад гэмт хэргийн гаралт жил бүр өссөөр байна. Цагдаагийн байгууллагад 2013 онд 25362 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оныхоос 3273 хэргээр буюу 14.8 хувиар их байна⁷⁷. Үүний 15419 буюу талаас илүү нь нийслэлд үйлдэгджээ. Харин өнгөрсөн жилд 27318 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 17144 нь нийслэлийн дүүргүүдийн цагдаагийн хэлтэст бүртгэгджээ. Нийслэл, орон нутгийн гэмт хэргийн гаралтыг хооронд нь харьцуулбал дийлэнх гэмт хэрэг нь Улаанбаатар хотод үйлдэгдэж байна.

Захиргааны зөрчлийн хувьд 2013 онд 777793, харин 2014 онд 681222 улсын хэмжээнд бүртгэгдсэн бөгөөд зөрчлийн тоо түрүү жилд өмнөх жилийнхээс бага зэрэг буурсан боловч дийлэнх нь мөн л нийслэлд бүртгэгджээ.

Үүнээс гадна цагдаагийн байгууллагад бүртгэгдээгүй гэмт хэрэг, зөрчлүүд бий бөгөөд зарим нэг шалтгаан, нөхцлөөс дурдвал хохирогч цагдаагийн байгууллагад хандаагүй, хандсан ч гомдол, мэдээллийг бүрэн гүйцэт шалгадаггүй, хохирлын хэмжээг дарж эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалздаг, дуудлага өгсөн иргэний нууцлалыг хадгалдаггүй, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг дутуу хийдэг гэх мэт ажлын алдаануудад анхаарч ажиллах тухай цагдаагийн төв байгууллагын даргаас алба хаагч нарт 2015 онд өгсөн үүрэгтээ дурдсан байна.

Сүүлийн үед бүртгэгдсэн болон бүртгэгдээгүй гэмт хэрэг, зөрчил болон тэдгээрийг үйлдсэн хүний талаарх мэдээ олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, интернет орчинд тун хурдан тарж байна. Энэхүү мэдээлэл үнэн эсэхээс үл шалтгаалан нийгэмд айдас түгшүүр бий болгодог бөгөөд үүнийг дагаад иргэд стресс орж бухимдан Хууль тогтоох, Гүйцэтгэх, Шүүх эрх мэдлийн болон

76. Robinson.Crime mapping, 2006

77. ЦЕГ. Монгол улс дахь гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал. УБ хот, 7 дахь тал

хууль сахиулах, нутаг дэвсгэр, засаг захиргааны байгууллагын удирдлагаа шүүмжлэх, ялангуяа цагдаагийн байгууллагад үл итгэх хандлага үүсэх, аюулгүй орчинд амьдарч байгаадаа эргэлзэх зэрэг маш олон сөрөг нөлөөллийг үүсгэдэг нь тогтоогдсон билээ.

Эндээс дүгнэхэд эрүү, захиргааны нөхцөл байдал жил ирэх бүр өссөн, цагдаагийн алба хаагч нарын гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх уламжлалт арга барилыг өөрчлөх, нийгэмд үүссэн айдас, түгшүүрийг багасгах, арилгах нь гэмт хэргийн газрын зураг аргыг нэвтрүүлэх зүй ёсны шаардлага байх болно.

Гэмт хэргийн газрын зургийн ач холбогдол

Иргэд ямар ч шалтгаангүйгээр айж алхах нь утгагүй юм. Монгол Улсын иргэд цаашилбал гадаадын жуулчдыг гэмт хэргийн хохирогч болохоос сэргийлэх шилдэг аргын нэг бол гэмт хэргийн газрын зураг үйлдэх билээ. Энэ нь гэмт хэргийг газрын зурагт тэмдэглэх энгийн нэг арга мэт боловч өргөн утгаар нь авч үзвэл “аюулгүй байдлыг хангахгүйгээр тэнд хүүхэд сайн сурах, хүчирхийллийг халах, эрүүл амьдрах тухай ойлголт байхгүй”⁷⁸ гэдгийг санах хэрэгтэй.

Гэмт хэргийн газрын зургийг нэвтрүүлэх нь олон төрлийн ач холбогдолтой. Үүнд:

1. Гэмт хэргийн зураглалыг нэвтрүүлснээр тухайн хорооны нутаг дэвсгэрийн нэг хэсэгт нь гэмт хэрэг гарч байдаг бол нөгөө хэсэгт нь гардаггүй учрыг олох болно. Жишээ нь: Баянгол дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэрийн яг аль хэсэгт, ямар цагт, ямар төрлийн гэмт хэрэг, зөрчил илүүтэй үйлдэгдээд буй нь тодорхой болох юм;
2. Гэмт хэргийн бүртгэлийг байршилтай нь уялдуулснаар сургуулийн орчимд юмуу, байрны орцонд уу, дэлгүүрийн ард талд уу, граж олонтой газар үйлдэгдсэн үү, хулгайд өртсөн машин дохиололтой байсан уу зэрэг олон олон эзэнгүй асуултын хариуг өгөх “ой санамж” нь байх болно. Өөрөөр хэлбэл одоо байгаа гэмт хэргийн статистик мэдээ хэргийн тоог л илэрхийлэхээс гарсан нөхцлийг илэрхийлдэггүй байдлыг өөрчлөх юм;
3. Энэ “ой санамж” нь хэвлэл мэдээлэл, зурагт, Facebook, twitter-ээс ирэх мэдээллээс илүү бодитой байх тул иргэд итгэлтэй нь аргагүй бүрэнхийд гэр лүүгээ алхаж чаддаг болно. Гэгээ тасрангуут яаран сандран гүйдэг хүүхдүүд цөөрөх болно. Нэг үгээр мэдээлэл бодит болсноор тухайн хот, дүүргийн талаарх таагүй ойлголт өөрчлөгдөх, хиймлээр үүссэн гэмт хэрэг, гэмт этгээдийн талаарх айдас нь алга болно;
4. Цагдаагийн байгууллагаас үе үе хэрэгжүүлдэг хүн хүч, бензин тос шаардсан олон олон нэгдсэн арга хэмжээнүүд цөөрөх болно. Тэд гэмт хэргийн газрын зургийг ашигласнаар цагдаагийн байгууллага хаана хүчээ төвлөрүүлэх, ямар цаг хугацаанд эргүүл ажиллах уу гэдгээ үр дүнтэй болгон өөрчилж чадна;
5. Гэмт хэргийн түвшинг 20% хүртэлх хэмжээнд бууруулах боломжтой. Мөн зөрчлийн гаралтыг бууруулж, урьдчилан сэргийлнэ. Жишээ нь: АНУ-н Нью Йорк хотын цагдаагийн газар compstat компьютерийн

⁷⁸ Anne Milgram. Smart Statistic, 2014

програмыг ашигласнаар хулгай, дээрэм, хүн амь, танхай, машины эд ангийн хулгай зэрэг гэмт хэргийн гаралтыг 1994 оноос 2009 оны хооронд 64% бууруулсан бөгөөд холбооны хэмжээнд 19.4% багасгасан байна⁷⁹;

6. Нийслэлийн иргэд болон цагдаагийн алба хаагч нар тухайн газарт яагаад гэмт этгээд тэр газрыг сонгож гэмт хэрэг үйлдэж буй шалтгааныг, ямар иргэд хохирогч болж, эсхүл халдлагад өртөлгүй зүгээр өнгөрөөд буйг мэдэх болно;
7. Эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал ямархуу байгааг дүгнэх боломжийг бий болгох тул Засгийн газар, нийслэлийн удирдлагаас гэмт хэрэгт өртөөд буй эмзэг цэгүүд дээр юу хийж болох, хэрхэн байдлыг өөрчлөх юм зэрэг асуудлаар шийдвэр гаргахад нь шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгаанд үндэслэсэн луужин нь болдог зэрэг олон зэрэг үр дүн авчрах ач холбогдолтой.

Гэмт хэргийн газрыг зургийг ашигласны ач холбогдлыг нэгтгэн дүгнэвэл гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлыг, удирдлагын шийдвэр, одоо хэрэгжүүлж буй арга хэмжээ, ажиллагаануудад дүн шинжилгээ хийх бааз нь болно.

Гэмт хэргийн газрын зураг нэвтрүүлэх арга зам

ШШГЕГ, ГЕГ, УТЕГ, Болор толь бичиг, Монос зэрэг хэдэн арван байгууллага өөр өөрийн онцлогтой аппликайшн ашиглаж байна. Тэр ч бүү хэл шумуул үргээх аппликайшн бүтээгдсэнийг иргэд ашиглаж байна.

ХЗЯ-ны төрийн нарийн бичгийн даргын тушаалаар 2013 онд “гэмт хэргийн цахим зураглал”-ыг практикт нэвтрүүлэхээр ХСИС, ЦЕГ, МУИС зэрэг байгууллагын төлөөллийг багтаасан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.


Гэмт хэргийн газрын зургийг Six Sigma, TQM, compstat зэрэг софтвер програм ашиглаж болохоос гадна гар утас, таблетны аппликайшн ашиглах нь түгээмэл болж байна. Учир нь энэ аппликайшныг бүтээхэд тийм ч өндөр зардал гардаггүй.

Жишээ нь Улаанбаатарт буй манай улсын зарим компанийн үнийн санал 5 сая орчим төгрөг байна. Аппликайштай зэрэгцээд цахим хуудсыг ажиллуулж цугт нь баяжуулаад явах боломжтой. Цахим хаяг хийх зах зээлийн үнэ нь 500.0-2 сая төгрөгийн хооронд байна. Интернетийн (host service fee) жилийн хураамж 80-100\$ орчим үнэтэй. Нийт 5.7-7 сая төгрөгийн зарцуулна.

Нэгэнт бий болгосон аппликайшныг цагдаагийн алба хаагчид, хүсвэл иргэд үнэ төлбөргүй татаж авна. Жишээ нь АНУ-д бүх муж, хотын цагдаагийн газруудыг багтаасан, дунд нь ашиглагддаг, иргэд нь бас суулгах боломжтой үнэ төлбөргүй “Crime Mapping” аппликайшныг ашигладаг. Мөн тэндэхийн иргэд оршин суугаа газрынхаа эсхүл жуулчлахаар төлөвлөсөн хотынхоо нэрийг оруулахад хэзээ, аль гудамжинд, ямар төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байсан тухай мэдэх болно. Үүнээс өөрсдийнхөө эд хөрөнгө болон амь насаа хамгаалах, юунд анхаарал болгоомжтой хандах вэ гэдгээ дүгнэж байдаг.

Зураг 5: Тодорхой нутаг дэвсгэрт бүртгэгдсэн гэмт хэргийг өнгөөр харуулав.

⁷⁹ Public Engines. Does the CompStat Model Really Reduce Crime
<http://www.publicengines.com/solutions/compstat.php>



Энэ дундаас аль нэг дүрсийг дарж ямар утгатай мэдээлэл болохыг харах боломжтой. Жишээ нь чернилен ягаан өнгө нь машины хулгайг илтгэнэ. Дээр нь дарахад зургийн дотор харагдаж байгаа цагаан өнгийн хүснэгт гарч ирэн дараах мэдээллийг өгнө.

Үүнд: Эрүүгийн хэргийн дугаар (151408855), хэрэг үйлдэгдсэн он сар өдөр, цагийг (3/4/2015, 11:30 PM), хэрэг үйлдэгдсэн гудамжны нэр буюу өргөн чөлөөний нэр (10700 ROSE AV), ингээд хамгийн доод талд нь хэргийн товч утга (хохирлын хэмжээ) зэргийг багтаасан.

Дээрх “Crime Mapping.com” болон “Crime map” аппликайшн нь хувийн хэвшлийн компаниас хохирогч нарын дунд явуулсан судалгаа, цагдаагийн байгууллагын рапорт, ажиглалт, ярилцлага зэрэгсудалгааны аргуудыг ашиглан төсвөөс санхүүжин мэдээллээ баяжуулдаг.

Манай улсын хувьд хоёр сонголт бий. Хувийн хэвшлийн байгууллага эсхүл цагдаагийн байгууллагад хариуцуулан хийлгэх боломжтой.

Хаана: Нийслэл хотод дийлэнх гэмт хэрэг нь үйлдэгддэг учраас хотын дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүдийг түшиглэн хэрэгжүүлэх нь зүйтэй.

Хэн: Хувийн хэвшил юмуу цагдаагийн байгууллагын аль нь ч байлаа гэсэн баяжуулалт хийх нь тийм ч төвөгтэй бус. Тухайлбал мэдээлэл-судалгааны тоо бүртгэгч, мэдээлэл-судалгааны ахлах байцаагч нар гэмт хэргийн бүртгэлийг цахимжуулан, баяжуулаад явна. Харин хувийн хэвшлийн байгууллагыг түшиглэн хийвэл цагдаагийн байгууллагаас өглөө бүр гаргадаг хоногийн нөхцөл байдлын мэдээг (цагдаагийн рапорт) ашиглан хэрэгжүүлнэ.

Мэдээлэл оруулах: Гэмт хэргийн тэмдэглэгээг өдөр бүр шинэчилнэ.

Хэрхэн: Компьютерийн програм, гар утас таблет-нд зориулсан аппликайшныг энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаг хувь хүн, компаниар хийлгэнэ. (21-30 хоног)

Хугацаа: Хэрэгжүүлж эхлэхэднийгдээ 1-2 сарын хугацаа шаардана.

Төсөв: Аппликайшн болон цахим хуудас хийх зардлыг нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, ЦЕГ, Улаанбаатар хотын цагдаагийн газар зэрэг байгууллагын төсвөөс гаргах боломжтой.

Үр дүн: Энэ ажлын үр дүнг ЦЕГ-ын Судалгааны төв жил бүрийн эцэст тайлагнана.

Иргэд учирч болох эрсдлийг тооцоолоогүйн улмаас гэмт хэргийн хохирогч болж болох боловч, газар зүйн хувьд буюу тэр орчинд амьдардаг

гэдгээрээ эсхүл дэлгүүр ажиллуулдаг гэдгээс хамаарч гэмт хэргийн хохирогч болж буй нь байж боломгүй үзэгдэл юм.

Шинжлэх ухааны үндэслэлтэй, олон улсын туршлагаар баталгаажсан, орчин үеийн технологи боловч зардал багатай бүтээгдэх, 24/7 хоног тасралтгүй ажиллагаатай, бодитой үр дүн гарахуйц гэмт хэргийн газрын зургийн ашиглах аргыг нийслэл хотод хэрэгжүүлэх нь зүйтэй гэдгийг энэ нийтлэлээр харууллаа.

Энэ нь гэмт хэрэгт дүн шинжилгээ хийх, цагдаагийн стратегийн Comp.Stat загварын нэг гол бүрэлдэхүүн хэсэг юм. “Crime mapping” буюу гэмт хэргийн зураглал үйлдэх системийг газар зүйн мэдээллийн систем (GIS) ашиглан бусад чиг хандлага, гэмт явдлын төлөв байдлыг шинжээчийн тусламжтайгаар тодорхойлж гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй цэгүүдийг тодорхойлох боломжийг олгодог систем юм⁸⁰.

Энэхүү системийг ашигласнаар тухайн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийг зураглал дээр тусгай тэмдэглэлээр тэмдэглэж ямар гэмт хэрэг өссөн, аль дүүрэг хороонд хэд хэчнээн гэмт хэрэг үйлдэгдсэн, ямар төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байгааг аль ч үед (шаардлагатай үед) харж болох боломжтой бөгөөд энэхүү зураглалыг “Comp.stat системтэй хослуулан ашиглавал илүү үр дүнд хүрч болно.

Тэрчлэн үйлдэгдсэн гэмт хэргийн байдалд дүн шинжилгээ хийж аль дүүрэг хороонд ямар төрлийн гэмт хэрэг өсөж байна тэр дүүрэг хороонд эргүүлийн чиглэлийг түлхүү ажиллуулах, хяналтын системийг түлхүү ашиглах зэрэг үйл ажиллагаагаа сайжруулах ач холбогдолтой юм.

Түүнээс гадна цагдаагийн байгууллагын объектын судалгааны бүрэлдэхүүн хэсэг болсон субъектын судалгаанд авагдсан этгээдийг хянах үйл ажиллагаанд “**Secure alert**” буюу цахим хянагч полиграф, GPS зэрэг орчин үеийн smart системүүдийг нэвтрүүлж түлхүү ашиглах шаардлагатай байна.

“Secure-alert” буюу цахим хянагч төхөөрөмжийг нэвтрүүлж ашигласнаар ял тэнссэн, гэрийн хорионд байгаа, хорихоос суллагдсан захиргааны хяналтанд байгаа этгээдүүдийг тусгай техникийн тусгай шийдэлтэй байрлал тогтоох GPS системийн тусламжтайгаар үр дүнтэй хяналт тавих төхөөрөмж юм.

GPS (Global positioning system) буюу дэлхийн хэмжээнд байрлал тогтоох системийг АНУ болон дэлхийн бусад улс орнууд өргөнөөр ашиглаж байгаа билээ. Уг системийг 2006 онд анхлан сэжигтний гаранд электрон бугуйвч зүүж, хэрэв байх ёстой газраас хэтэрвэл хиймэл дагуулаар дамжин удирдлагын компьютерт мэдээлэл өгөх байдлаар хэрэглэх болжээ.

Энэхүү төхөөрөмжийн талаар дурьдахын өмнө юуны түрүүнд судалгааны явцад мэдсэн нэгэн жишээнээс эхлэх нь зүйтэй гэж үзэж байна. Америкийн Нэгдсэн Улсын Масачусетс хотод болсон жишээг сийрүүлбэ. Виллиам Коттер гэгч эр бүсээрээ дүүрэн сум хийгээд, өөрийн салсан эхнэр Доротигийн гэрт нь дайрч ороод нуруунд нь буудсан бөгөөд өөрийнхөө амийг ч мөн хороосон байна. Уг хэрэг 2002 оны гуравдугаар сарын 26-нд АНУ-ын Масачусетс хотод гарсан бөгөөд дээрх хэргээс таван хоногийн өмнө эхнэртээ согтуугаар агсан тавьсны улмаас тус хотын шүүх Коттерийг эхнэрээс нь тусад нь байлгах шийдвэрийг гаргажээ. Гэвч шүүхийн энэхүү шийдвэр бүсгүйн амийг аврах хангалттай шалтгаан биш байв.

⁸⁰ wikipedia.org

Дээрх явдлаас зургаан жилийн дараа электрон хяналтын технологи хөгжиж, АНУ-д зөрчил гаргасан этгээдийг хянах дэвшилтэт технологитой болсон юм. Хэрэв тухайн үед энэ технологи нэвтэрсэн байсан бол Доротигийн амийг аврах бүрэн бололцоотой байсан аж. Тэр нь юу вэ гэхээр: GPS (Global positioning system) буюу дэлхийн хэмжээнд байрлал тогтоох систем юм. Ганц АНУ-д бус бусад орнуудад энэхүү технологийг өргөн ашиглаж байгаа билээ.

Уг системийг 2006 онд анх гарандаа электрон бугуйвч зүүж, хэрэв байх ёстой газраас хэтэрвэл хиймэл дагуулаар дамжин удирдлагын компьютерт мэдээлдэг болжээ.

Тус мужийн шүүхээс хэрэгтэнд уг бугуйвчийг зүүлгэх асуудлыг хуулиар зөвшөөрдөг бөгөөд одоо АНУ-ын хэд хэдэн мужид уг хууль үйлчилж эхэлсэн байна⁸¹.

Оклахомад GPS-ээр гэмт хэрэгтнийг хянах асуудлыг 100%-ийн саналаар баталжээ. Энэхүү системийн бас нэгэн давуу тал нь хөрөнгө мөнгөний асуудал гэнэ. Масачусетс мужийн цагдаагийн хэлтсийн дарга Паул Лүччигийн ярьснаар “Гэмт этгээдийг шоронд хориход жилд 30-40 мянган ам.доллар зарлагддаг. Харин GPS-ийг ашиглахад жилд 3400 ам.доллар л шаардлагатай. Бидний үзэж байгаагаар энэхүү байрлал тогтоох систем аль аль талаараа давуу юм. Энэ бол нийгмийг хамгаалах хэрэгсэл мөн. Хэдийгээр бид хэн нэгний амь насыг даатгаж чадахгүй ч, илүү өргөн боломжийг олгож байгаа юм” гэжээ.⁸²

АНУ-ын Масачусетс хотод болсон энэхүү харамсалтай тохиолдол манай улсад давтагдахгүй гэх баталгаагүй бөгөөд давтагдсан байхыг ч үгүйсгэхгүй юм.

Тэгвэл GPS-Global positioning system буюу Дэлхийн хэмжээнд байрлал тогтоох систем гэж юу болох талаар судалсан судалгаанаас товчхон танилцуулья.

GPS-ийн үйлчилгээ нь анх цэргийн зориулалтаар гарсан боловч иргэний болон арилжааны чиглэлээр илүү өргөн ашиглагдаж байна.

Энэ системийн дагуулуудаас ирүүлэх дохиолол тасралтгүй бөгөөд хэрэглэгч, хүлээн авагчийн тоонд хязгаар байхгүй, мөн үйлчилгээ үзүүлсний төлбөр гэж байдаггүй. GPS технологийн үндэс нь маш өндөр нарийвчлалтай цаг хугацаа болон байрлалын талаархи мэдээлэл байдаг.⁸³

Цагдаагийн алба хаагч нь үйл ажиллагаандаа шинжлэх ухаан, орчин үеийн техник технолог, мэдээллийн сүлжээний ололтыг ашиглахаар заасан нь дэлхийн хэмжээнд байрлал тогтоох системийг цагдаагийн алба хаагч үйл ажиллагаандаа хэрэглэж болох эрх зүйн үндэс бий болсон гэж үзэж болно.

Байрлал тогтоох системийг гэмт хэрэгтэй тэмцэх болон гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдийн судалгаанд авагдсан, гэмт хэрэг үйлдээд батлан даалтанд байгаа этгээдийг хянах үйл ажиллагаандаа дараах байдлаар ашиглаж болох юм⁸⁴.

Мөн хэсгийн байцаагч, төлөөлөгч нар нь хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, хорих ял эдлгээд суллагдсан этгээдүүдийг хянахын тулд байршил тогтоох систем ашиглан хянахад улсын төсвөөс олон тэрбум төгрөг хэмнэх боломжтой байхыг үгүйсгэхгүй юм.

⁸¹ Цагдаа судлал сэтгүүлийн 2013 оны дугаар №3, 50 дах тал

⁸² www.lamongols.com

⁸³ oloo.mn modules.

⁸⁴ Цагдаа судлал сэтгүүлийн 2013 №3 дугаарын 47 дахь тал

Эдгээр техник технологиос гадна Шадар сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2010 оны 42/123, 246 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтыг үндэслэн ЦЕГ-ын даргын 2010 оны 367 дугаар тушаалын 7-р хавсралтаар баталсан Нийслэлийн засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын Холбоо, технологийн тасгийн орон тооноос офицер 9, ахлагч 3, бүгд 12 орон тоог Мэдээлэл шуурхай удирдлагын төвд шилжүүлэн нийт 35 хүний орон тоотой Ашиглалт, Радио холбоо, Сүлжээ програм хангамжийн гэсэн 3 тасагтай Холбоо, мэдээлэл технологийн хэлтэс, 2012 оны 09-р сарын 15-ны ЦЕГ-ийн №593 тоот тушаалаар Техник ашиглалтын хэлтэс болгон өөрчилж Шуурхай үйлчилгээний, Систем ашиглалтын, Техник ашиглалтын гэсэн 3 тасагтай 34 хүний орон тоотойгоор өөрчлөн байгуулсан.

Дээрх алба нэгжийг түшиглэн шуурхай удирдлага, хяналтын систем, шилэн кабелийн сүлжээ, тоон технологийн транкид радио холбооны систем, IP-д суурилсан телефон холбооны IP-PBX систем, теле хяналтын камерын систем, газар зүйн мэдээлэл, байрлал тогтоох системүүдийн ашиглан хяналтын нэгдсэн төвийг байгуулан ажиллаж чадвал бид субъектын судалгаанд авагдсан этгээдийг хянаж чадна.⁸⁵

Мөн ИШГБ-аас хорихоос суллагдсан этгээдийн талаар ирүүлсэн мэдэгдэх хуудасанд суллагдсан этгээдийн гэр хаяг нь тодорхой бус, гэрийн хаягыг хуучин байршил дугаараар нь бичих, ялтны хувийн байдлыг дутуу судлах, тухайн этгээдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлэхгүй байх зэрэг нь субъектын судалгаанд авагдах этгээдийг хянах боломжгүй болж улмаар тэдний зүгээс дахин гэмт хэрэг үйлдэх явдал гарах шалтгаан болно.

Иймд тухай этгээдийг хорих ангид ял эдлэж байх хугацаанд нь сайтар судлаж тэдний хань харилцаа, эхнэр нөхөр, эргэлт уулзалтаар ирсэн хүний нэр, хаяг, утасны дугаар, регистрийн дугаар, үйлдсэн гэмт хэргийн төрөл, ангилал, халдлагын зүйл, гэмт хэрэг үйлдсэн арга, цаг хугацаа, зэвсэг хэрэгсэл зэргийг нарийн судлаж уг судалгааг тухайн этгээдийг суллагдах үед нь оршин суух газрын цагдаагийн байгууллагад шилжүүлэн өгч байх ажлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хийж хэвшүүлэх шаардлагатай байгааг онцгой анхаарах шаардлагатай байна.

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ЦОГЦСЫГ ОРШУУЛСАН ГАЗРААС ГАРГАЖ ҮЗЛЭГ ХИЙХ ТАКТИК, АНХААРАХ АСУУДАЛ

П.Эрдэнэбаатар

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
ЭХХШЭЗТ-ийн багш, цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга: Цогцсыг оршуулсан газраас нь гаргаж шинжлэх мөрдөн шалгах ажиллагааны тактик зүйн анхааран үзэх асуудлын талаар хөндөж судалсан болно.

⁸⁵ <http://www.eincenter.mn>

Түлхүүр үг: Цогцос, оршуулгын газар, булш, бунхан, шарил, үзлэг

Үндсэн хэсэг

ЭХХША-ны үед гэмт хэргийн онцлогоос хамаарч янз бүрийн байдлаар үзлэгийг хийх шаардлага тулгардаг, эдгээр үзлэгүүд өөрсдийн онцлогтой тул хуульд заасан үндэслэл, журмаар хийгдээгүй үзлэг нотлох баримтын чадвараа алдах, хууль зүйн үр дагавартай учир тус бүрийн онцлог, эрх зүйн зохицуулалтыг баримтлах шаардлага тулгардаг. Цогцсыг оршуулсан газраас нь гаргаж шинжлэх тухай ЭХХШХ-д үндэслэл, журмыг зааж өгсөн байна⁸⁶.

Цогцост хийх үзлэг нь ердийн /хэргийн газарт, эмнэлэгт хийх/, оршуулсан цогцост хийх үзлэг гэж 2 төрөлд хуваагдана.

Цогцсыг оршуулсан газраас нь гаргаж үзлэг /эксгумаци/⁸⁷ хийх тохиолдолд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эрхлэн гүйцэтгэх эрх бүхий албан тушаалтан үндэслэл бүхий саналаа гарган прокурорын зөвшөөрөл авах, уг ажиллагааг гүйцэтгэхэд шүүх эмнэлгийн шинжээч, хөндлөнгийн гэрчийг байлцуулах, эсвэл дуу-дүрсний бичлэг хийж оршуулсан газар, цогцсны ерөнхий байдлыг бэхжүүлж, дараа нь цогцос, эд зүйл гэсэн дарааллаар хэрэгт ач холбогдолтой бүхий л баримтыг орхигдуулалгүй үзлэг хийдэг онцлогтой.

Цогцсыг оршуулсан газраас нь гаргаж үзлэг хийх дор дурдсан шаардлага, тохиолдол байна.

1. Оршуулсан хүний цогцсыг таниулах зорилгоор хийх;

2. Цогцост шинжилгээ хийлгүй оршуулсан тохиолдолд шүүх эмнэлгийн анхдагч шинжилгээ хийх;

3. Цогцост шүүх эмнэлгийн давтан эсхүл нэмэлт шинжилгээ хийх үед цогцсыг оршуулсан /булсан/ газраас нь гаргаж үзлэг, шинжилгээ хийх, ингэхдээ хэний цогцос /хүүр/⁸⁸-ыг, ямар зорилго, үндэслэлээр яах гэж ухан /хөндөн/⁸⁹ гаргаж байгаа тухайгаа тэмдэглэлд тусгана.

Цогцсыг оршуулсан газрын байрлалыг тогтоохын тулд нутаг дэвсгэрийн засаг захиргаа, иргэдэд үйлчлэх товчооноос цогцсыг оршуулсан газрын байршил, иргэний нас барсан гэрчилгээний дугаар, булшны дугаар, оршуулсан сар өдрийг тодорхойлсон баримт бичгийг гаргуулан авч хавтаст хэргийн материалд хавсаргана.

Цогцсыг оршуулсан газраас гаргаж үзлэг хийх нь нэг төрлийн тактик бөгөөд хамгийн ач холбогдолтой эд зүйл, ул мөр, нотлох болон эд мөрийн баримтыг илрүүлж, бэхжүүлж, хураан авч болох газар, цаг хугацаа, эд зүйлийн дэс дараалалыг ач холбогдлоор нь жагсаан шалгах ажиллагаа юм.

Цогцсыг оршуулсан газраас нь гаргаж үзлэг явуулах тактикийн үе шатыг онцгойлон анхаарах шаардлага тулгардаг гэдгийг санах хэрэгтэй. Иймд дараах үе шатуудад анхаарал хандуулахыг шаарддаг.

1. Бэлтгэл үе шатанд оршуулгын газарт очихын өмнөх, хэргийн газрын хамгаалалтын бүсийг тогтоох, хамгаалалтад авах, хамгаалалтыг цуцлах, бусдын

⁸⁶ ЭХХШТХ-ийн 23.4 дүгээр зүйлийн 5 дах хэсэг.

⁸⁷ Цогцсыг булш, бунхнаас нь гаргаж шинжлэхийг хэлнэ.

⁸⁸ contact@mongoltoli.mn Монгол хэлний их тайлбар толинд хүүр гэдэг нь...үхэгсдийн цогцос болон оршуулсан газар.

⁸⁹ contact@mongoltoli.mn Монгол хэлний их тайлбар толинд хөндөх гэдэг нь...юмыг хөдөлгөх, хүрэлцэх, өдөх.

аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын бүсэд хүн, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхгүй байх, эд мөрийн баримтыг илрүүлэх, цуглуулах бэхжүүлэх, аливаа зүйлийг бүхлээр нь эсхүл хэсэгчлэн хураан авах сав, багаж зэвсгийг бэлтгэх, хадгалах, ажлыг зохион байгуулна.

Цогцсыг оршуулсан газраас нь гаргаж үзлэг хийхэд анхаарах асуудал:

1. Бэлтгэл ажил;
 2. Цогцсыг оршуулсан оршуулгын газарт очих;
 3. Хамгаалалтад авах;
 4. Шинжлэн судлах зүйлсийг тогтоох;
 5. Нотлох баримтын бодит боломжийг үнэлэх;
 6. Нөхцөл байдлын талаар тэмдэглэл хөтлөх;
 7. Оршуулсан газрыг гэрэл зураг, дуу-дүрсний бичлэг ашиглан бэхжүүлэн, тэмдэглэлд тусгах;
 8. Цогцсыг оршуулсан газраас нь гаргаж үзлэг хийсэн зураглалыг үйлдэх;
 9. Цогцост нарийвчилсан үзлэг хийх;
 10. Бодит нотлох баримт цуглуулж, бэхжүүлэн авч тэмдэглэх;
 11. Төгсгөлийн шатны үзлэг хийх;
 12. Хамгаалалтыг буулгах, цуцлах;
- Цогцсыг оршуулсан оршуулгын газарт очиход анхаарах асуудал:
1. Цогцсыг оршуулсан газрын орчин нөхцөл байршлыг судлах, явуулах тактикийн аргуудыг сонгох;
 2. Нотлох баримтыг устгах, үгүй болохоос урьдчилан сэргийлэх;
 3. Устаж үгүй болж болзошгүй нотлох баримттай болгоомжтой харьцах;
 4. Оршуулгын газрын ерөнхий байдал анхаарал сонирхол татсан зүйлсийг тэмдэглэх;
 4. Мөрдөгч өөрийн болон бусад оролцогчдын хувийн аюулгүй байдлыг хангах
 5. Үзлэг хийх хэмжээ, хүрээ хязгаарыг тодорхойлох, тогтоох
 - Гаднах хэсэг: томоохон талбай байх
 - Дотор хэсэг: илүү хувийн шинжтэй байх гэх мэт.
- Цогцсыг оршуулгын газрын ерөнхий байдал: зураг №1



Хамгаалалт⁹⁰, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт⁹¹-ыг хангахад анхаарах асуудал:

⁹⁰ ЭХХШТХ-ийн 23.3 дугаар зүйл.

⁹¹ ЦБҮАЖурам, код: 810. Цогцост үзлэг хийх зөөвөрлөх, задлан шинжлэх ажиллагаанд оролцсон алба хаагчдад нэмэгдэл олгох.

1. Хамгаалалт авах газрын цар хүрээг тогтоох, практик амьдралд зарим тохиолдолд оршуулгыг газар төв суурин газартай ойр, хүний хөл хөдөлгөөн их байх тохиолдлууд байх тул цаг хугацааг нарийн төлөвлөх, тогтоох.
2. Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан шөнийн нөхцөлд гэрэл хангалттай бус байх, гэрэл зураг авахад объектийг тусгайлан гэрэлтүүлэх төрөл бүрийн хиймэл үүсгэвэр ашиглах⁹²;
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал хангагдсан эсэхийг шалгах;
3. Оршуулсан газрын анхны нөхцөл байдлын талаар мэдээлэл цуглуулах;
4. Үзлэгийн тэмдэглэлийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу үйлдэх;
5. Үзлэг хийх явцад зөвшөөрөлгүй гаднаас, дотроос нэвтрэгчдээс болгоомжлох, хязгаарлалт тогтоох;
6. Хамгаалалтын бүсэд орсон, гарсан хүнийг бүртгэх⁹³;
7. Цогцсны гаднах хэсгийг цаг агаарын нөлөөнөөс хамгаалах арга хэмжээ авах;

Цогцсыг оршуулсан газраас нь гаргаж үзлэг хийх үе шатуудыг төлөвлөхөд анхаарах асуудал:

1. Багийн ахлагчийн нэгдмэл нэг удирдлаганд ажиллах;
2. Хэргийн газар ажиллах үйл явц, арга ажиллагааг хэлэлцэх;
3. Хэргийн газарт оролцох бүрэлдэхүүнийг тодорхойлох /шинжилгээний хүрээлэнгийн ажилчид, мэргэжилтнүүд, эрэн хайх техник тоног төхөөрөмж⁹⁴;
3. 4. Устаж, үгүй болж болзошгүй нотлох баримтуудыг хамгаалах;
5. Хүрээлэн буй орчин, цаг агаар, физикийн нөхцөл байдлын талаар дэлгэрэнгүй тэмдэглэл хөтлөх гэх мэт.

Биологийн ба физикийн нөлөөллөөс үүссэн нотлох баримтыг үнэлэхэд анхаарах асуудал:

1. Үнэлэх ажиллагаа нь хэргийн газарт очсоноос эхлэн явагдана.
2. Урьдчилсан үзлэгт дэлгэрэнгүй байдлаар тусгана.
3. Эд мөрийн баримт устах үгүй болох, баларч болзошгүй нотлох баримтуудыг эхлэн цуглуулж, бэхжүүлэн баримтжуулна.
4. Үзлэгээр хураан авсан нотлох баримтыг шаардлагатай баглаа боодлоор хамгаална.

Цогцсыг оршуулсан газраас нь гаргаж хөндөх⁹⁵ буюу малталт⁹⁶ хийх ажиллагаанд анхаарах асуудал:

1. Цогцсыг оршуулсан газарт улирлын /өвөл, зун, хавар, намар/ онцлогоос шалтгаалан гар ажлын багаж хэрэгсэл болон техник ашиглан бага багаар хөрсийг хуулах;
2. Булш-⁹⁷наас гарч ирсэн шороо, шулууг тусад нь байршуулах;
3. Шороо, чулуунд байгаа зүйлд анхаарлаа хандуулах
4. Шарил-⁹⁸ыг гарган үзлэг хийх үе шат
5. Цогцсноос ДНХ-ийн болон бусад эд эсийн шинжилгээний дээж авах⁹⁹ гэх мэт.

⁹² Б.Бат-Эрдэнэ. Криминалистик. УБ.,2017

⁹³ ЦБҮАЖурам, код: 205. Гэмт хэрэг, зөрчийн газрыг хамгаалах.

⁹⁴ Хэргийн газрын үзлэгийн үндэс /Аргачилсан зөвлөмж/ УБ.,2013. 21 дэх тал

⁹⁵ Монгол хэлний их тайлбар толинд хөндөх гэдэгт...Юмыг хөдөлгөх, хүрэлцэх элзэг газрыг хөндөх, газар хөндөх, тахилга шүтээнтэй онгон газар нутгийн хөрсөнд хүрэх.

⁹⁶ Хэргийн газрын үзлэгийн үндэс /Аргачилсан зөвлөмж/ УБ.,2013. 44-45 дах тал

⁹⁷ contact@mongoltoli.mn Монгол хэлний их тайлбар толинд булш гэдэг нь... дарж булсан юм.

⁹⁸ contact@mongoltoli.mn Монгол хэлний их тайлбар толинд шарил гэдэг нь... биеийн шарил.

⁹⁹ ЦБҮАЖурам, код:705. ДНХ-ийн дээж авах, сан бүрдүүлэх.

Нотлох баримт бэхжүүлэх, хураан авах ажиллагаанд анхаарах асуудал:

1. Шинжилгээнд зориулж эд эрхтэнээс дээж, ул мөрний хэв авах¹⁰⁰;
2. Нотлох баримтуудын тус тусад нь савлан хадгалах;
3. Булшны газраас шорооны дээж авах;
4. Булшны газраас олсон ямарваа шавьж хорхойг цуглуулах;
5. Хадгалахын тулд спирттэй шилэн савд хийж таглах;
6. Булшны газраас олдсон ургамлуудыг цуглуулах;
7. Үзлэгээр хураан авсан нотлох баримтыг шаардлагатай баглаа боодлоор хамгаална.

Цогцсыг оршуулсан газраас нь малталт хийж гаргасан байдал: зураг №2



Үзлэгийн тэмдэглэл үйлдэхэд анхаарах асуудал:

1. Цогцсыг оршуулсан газрын ерөнхий тайлбараас үндэслэн гаргана.
2. Үзлэгийг ерөнхий зүйлсээс нарийвчилах хүртэлх бүгдийг тэмдэглэнэ.
3. Анхаарал татсан зүйлсийг тэмдэглэх;
4. Тэмдэглэлд гэрэл зураг, дуу-дүрсний бичлэгийн ямар техник хэрэгсэл ашигласан талаар тэмдэглэх гэх мэт.

2. Ажлын үе шатанд цогцсыг оршуулсан газраас нь гаргаж нарийвчилсан үзлэг хийхэд дараах асуудалд анхаарлаа хандуулах:

1. Цогцсыг оршуулсан газрыг үнэлэх үндсэн үзлэг;
2. Ерөнхий болон нарийвчлан шатны үзлэгүүдийг хийх¹⁰¹;
3. Анхаарал татсаныг эхэнд, дараа нь овор ихтэйд үзлэг хийх;
4. Эхлээд тодорхойг дараа нь далд байгааг зүйлд үзлэг хийх;
5. Цогцсыг гаргах, нэвтрэх, байршуулах гарцуудыг бэлтгэх;
6. Нотлох баримтыг гэмтээх, бохирдуулах, халдварт өвчнөөс хамгаалахын тулд нэг бүрийн хамгаалах хэрэгсэл өмсөх;
7. Дэс дараалалтай эмх цэгцтэй хийх;

Ул мөр цуглуулах, бэхжүүлэхэд анхаарах асуудал:

1. Цогцсны зургийг гэрэл зураг, дуу-дүрсний бичлэгт буулган бэхжүүлэх;
2. Үзлэгээр илэрсэн нотлох баримтыг тэмдэглэлд бүрэн тусгаж хөтлөх;
3. Боломжтой бол нотлох баримт хамгаалах хүн томилох оролцуулах;

¹⁰⁰ ЦБҮАЖурам, код:919. ДОХ, Халдварт, бусад эрсдлээс сэргийлэх.

¹⁰¹ Ж. Хурцгэрэл, Криминалистик. УБ., 2004

4. Цогцсонд үзлэг хийхдээ үзлэгийг болгоомжтой эхэлж, идэвхитэй дуусгах;
5. Цогцсонд үзлэг хийж байх үед цогцсноос шинжилгээнд зориулан эд эрхтэний дээж авах шаардлага тулгардаг тул хураан авсан нотлох баримтын баглаа, боодолд тэмдэглэгээ хийх лацдах;

Гэрэл зураг, дуу-дүрсний бичлэг¹⁰² хийхэд анхаарах асуудал:

1. Нэвтрэх хэсэг болон орж гарах гарцууд гэрэл зургийг авах;
2. Навч, ургамалыг нь зайлуулсаны дараа оршуулсан газрын гэрэл зургийг авах;
3. Бүгдийг, гол хэсгийг, тодруулсан байх;
4. Хүрээлэн буй орчин, зэргэлдээх хэсгийг авах;
5. Нэмэлт тойм зураглал, тэмдэглэлийн гэрэл зураг авах;
6. Хэтэрхий олон гэрэл зураг авах шаардлагагүй тул хэмжих, тооцоолох багаж, төхөөрөмж ашиглана.

Төгсгөлийн үе шатанд анхаарах асуудал:

1. Цогцсыг буцаан оршуулахдаа дараалалын дагуу нягт нямбай хийх гүйцэтгэх;
2. Цогцсыг буцаан оршуулах үе шатыг гэрэл зураг, дуу-дүрсний бичлэгээр баримтжуулах;
3. Хэргийн газрын үзлэгийг орхиж явах үеийн гэрэл зураг, дуу-дүрсний бичлэг хийж бэхжүүлэх;
4. Бүх нотлох баримт бүртгэгдсэн, хэргийн газар аюулгүй болсон эсэхийг магадлан шалгах;
5. Ашигласан бүх багаж хэрэгсэлээ авсан эсэхийг шалгах, юуг ч орхигдуулаагүй гэдэгтээ итгэлтэй байх;
6. Оршуулгын газрыг орхихоосоо өмнө шаардагдах бүх зүйлсийг авсан эсэхийг шалгах гм.

СЭТГЭЛ СУДЛАЛЫН ОНОЛ ПРАКТИЗИЙН АСУУДАЛ

**ЦУВРАЛ АЛУУРЧИНЫ ЕРӨНХИЙ ДҮР, ТӨРӨЛ, ТҮҮНИЙ СЭТГЭЛ
ЗҮЙГ ШИНЖЛЭХ УХААНЫ ТАЛААС СУДЛАХ НЬ**

П.Цагаандарь

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн
тэнхимийн багш, магистр, цагдаагийн ахмад

Энэхүү судалгааны гол субъектыг бид бүхэн биеэчлэн танихгүй ч, хувь хүний зан араншин, дадал, хандлагыг түүний аллагаар судлах болно. Цуврал алуурчдын дүр зураг сэтгэл зүйн олон төрлийн шинжлэх ухааны салбарт судлагдаж байна. Үүнд:

- ✓ Эрүүгийн эрх зүй
- ✓ Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд

¹⁰² ЦБҮАЖурам, код:301. Гэрэл зураг, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг ашиглах.

- ✓ Шүүх эмнэлэг, сэтгэц эмгэг
- ✓ Ерөнхий криминологи болон сэтгэл судлалд

Энэхүү гэмт хэрэгтэн бие хүний сэтгэл зүйн, авир араншинг бид бүхэн сэтгэл зүйн талаас нь судлах болно.

FBI буюу Холбооны мөрдөх товчоогоос бидэнд санал болгож байгаа цуврал алуурчидын дүр зургыг судлах болно.

- Зохион байгуулалттай, нийгмийн эсрэг хадлагатай
- Зохион байгуулалтгүй, нийгмийн эсрэг хандлагатай
- **Зохион байгуулалттай, нийгмийн эсрэг хадлагатай алуурчин**
 - Сэтгэн бодох чадвар, IQ, харилцааны өндөр чадвартай
 - Өөрийгөө хянах, барих, /зарим үед түр хугацаанд сураг чимээгүй алга болж, үйл явдлыг намжихыг хүлээх чадвартай, эрсдэлийг сайн үнэлдэг/
 - Нийгмийг жигшэн, хүлээж авхаас татгалздаг, цөөн тооны хүмүүстэй нийлдэг, ичих, айх, санаа зовох мэдрэмж түүнд төрдөггүй.
 - Гэр орон, машин, гадаад үзэмжиндээ өндөр анхаарал тавидаг. / бүх зүйлд хэт өндөр шаардлага тавидаг/
 - Хохирогчийн хувийн зохион байгуулалтад тааруулж залжин эсвэл өөртөө татах байдлаар өөрийн болгодог. /эмч, цагдаа, аль ч байгууллагын хувцасыг ашиглан хохирогчийг хууран мэхэлдэг.
 - Алуурчинд хохирогчийн гадаад үзэмж чухал байдаг /биений бүтэц, өндөр, үс, нүд, арьсны өнгө, хувцаслалтын хэв маяг/.
 - Гэмт хэргийг эртнээс урьдчилан төлөвлөдөг. /хаана, хэдэн цагт, ямар багаж зэмсэгээр хэрхэн хөнөөх талаар/
 - Хохирогчийн бүрэн удирдаж, захирахын тулд ихэвчлэн хүлдэг байна.
 - Хохирогчийг шууд алдаггүй, эхлээд өөрийн төсөөлөн бодсон бүхий л бодол, мөрөөдлөө бүрэн гүйцэтгүүлж, зовоон тарчлаасны дараа амыг нь авдаг.
 - Өөрийг нь илчлэх бүхий л сэжүүрийг үгүй хийдэг ба зарим тохиолдолд хохирогчийн цогцсыг өөр газар руу шүлжүүлдэг.
 - Зарим тохиолдолд өөрийн алах хэв маг, гарын үсэг, таних тэмдгийг хохирогчийн бие, тухайн аллагын газарт үлдээдэг.
 - Цагдаагийн байгууллага, эрэн сурвалжлах багын сайн дурын туслах ажилтан болж хамтран ажиллах чадвартай.
 - Гэмт этгээд баригдсан үедээ сэтгэл зүйн хувьд тогтвортой маш тайван байж, байцаагчийн сэтгэл зүйг мэдүүлэг өгөх хугацаанд судлан түүгээр тоглох, гэмт хэргийн сэжүүрийг өөрөөсөө холдуулж, өөр тийш хөтлөж чадах тохиолдол элбэг гарч байсан. Иймд зарим нэг гэмт этгээдүүд цагдаагийн байгууллагад баригдсан ч нотлох баримт хангалтгүйн улмаас олон удаа мултарч гарч байсан гашуун түүхүүд бий. Үүний гол алдаа нь гэмт хэрэгтэний сэтгэн бодох чадвар, хүний сэтгэл зүйг сайн таньж мэдэх чадвар алба хаагчаас илүүд байгаад оршидог.
 - Аллага үйлдэлж байсан бүхий л цаг хугацаанд аллага нь улам төгсөрч, шинэ төрлөөр алах, тамлан зовоох арга нь улам нарийссан байдаг.
- **Зохион байгуулалтгүй, нийгмийн эсрэг хандлагатай алуурчин**
 - Сэтгэн бодох чадвар дундаж ба дунджаас доогуур, бусадтай ойлголцох, харилцаанд орох чадвар дунд эсвэл муу хөгжсөн.

- Хүрээлэн байгаа хүмүүстэй хэл амаа олдоггүй /эсрэг хүйстний хүнтэй тэр дундаа/
- Бага насандаа, үеийнхээ хүүхдүүдтэй хэл амаа олдоггүй байсан. Гэр бүлийн уур амьсгал тааламжгүй, эсэргээрэй хатуу ширүүн, гэр бүлд өссөн байдаг.
- Хэрэгтэн бага, өсвөр насандаа бэлгийн хүчирхийллийн хохирогч болж байсан
- Өөртөө болон гадаад үзэмжиндээ анхаарал тавидаггүй, гадаад байдал нь нямбай, цэмбэгэр бус
- Гэмт хэргийг ихэвчлэн гэнэт сэтгэлийн хөөрлөөр үйлддэг
- Аллагыг эртнээс зохион байгуулалттай хийдэггүй
- Гэмт хэргийг өөрийн оршин суудаг гэр, ажлаас /15км/ холгүй зайд үйлддэг.
- Гар доорх эд зүйл ашиглан хохирогч руу дайрдаг
- Ой снамжиндаа гэмт үйлдлээ хадгалахыг хичээдэг, өдрийн тэмдэглэл бичих, зураг, бичлэг хадгалдсан байдаг.
- Хохирогчийн гэр бүлийн гишүүдэд захиа илгээмж өгөх байдлаар холбоо барьж ил гарч ирдэг.
- **Цуврал алуурчдыг энэ 2 бүлэгт хуваан авч үзхээс гадна, завсрын алуурчид бас байдаг байна. Үүнд:**
- Дундаж, дунджаас дээгүүр IQ-тай бусадтай харилцах, өөрийгөө болон бусдыг ойлгох чадвар дунд
- Үе тэнгийн хүүхдүүд, гэр бүлийн зүгээс хүнд хүүхэд насыг туулсан /шооглуулах, зодуулах, сэтгэл зүйн болон бие физиологийн хүчирхийлэлд өртөж байсан/
- Өөрийгөө сайн удирдаж чаддаг боловч далд ухамсрын түвшинд гэмт хэргийг үйлддэг
- Гэмт хэргийг гэрийнхээ, ажлынхаа ойролцоо үйлддэг
- Гэмт хэрэг хийх үедээ өөрийгөө эзэмдэж чадах аа болидог, бүх зүйлийг сэтгэл хөдлөл нь удирддаг
- Хохирогч нарын зурагт цомог үүсгэж, гэмт хэрэг үйлдэхэд шаардлагатай орчин бий болгодог.
- Гэмт этгээдийн 50 хувь нь гэмт хэргийн ул мөрийг устгадаг.
- Гэмт этгээд баривчлагдсан тохиодолд өөрийгөө маш тайван авч явдаг ба, мэдүүлэг өгөх үед хаалттай болж, хамтран ажиллахаас үргэлж татгалздаг.
- Энэхүү завсрын алуурчдын дунд ОХУ-н цуврал алуурчид болох А.Р.Чикатило, С.А.Головкин, А.Е.Сливко нар багтдаг байна.

Цуврал алуурчдын нийтлэг дүр зургийн хувьд:

- Бага болон өсвөр насандаа сэтгэл зүй, сэтгэцийн гэмтэл авч байсан.
- Гэр бүлийн хүнд хэцүү харилцаа, /эхийн зүгээс хайр, дулаан харилцаа мэдэрч байгаагүй, эцэг эхийн хэт өндөр, хатуу шаардлага эсвэл хяналтад өссөн. Гэр бүлдээ нэг хүүхдийг илүүд үзэж хайрлан бусдыг нь шийтгэн, байнга зандрах/ гм.
- Эсрэг хүйстний хүнтэй харилцаанд орж чаддаггүй, бие физиологийн дутуу хөгжилтэй холбоотой байх магадлалтай

- Бага насандаа уур уцаараа амьтад дээр гаргаж, тэднийг тамлан зовоож алдаг байсан гэх мэт олон төрлийн хүчин шалтгаанаас болж нийгэмд дасан зохицох чадваргүй, нийгмийн эсрэг гэмт хэрэгтэн, цуврал алуурчин гардаг байна.

Гэмт этгээдийг цагдан хорьсоны дараа түүний гэм зэмгүй хүнийг алах болсон шалтгаан нөхцлийг тодруулдаг. Иймд бид цуврал алуурчидын сэдлийг мэргэжлийн үүднээс тайлбарлаж байна.

Гедонисты: Энэ төрлийн гэмт хэрэгтний зорилго нь таашаалыг авах. Аллага бол тэдний хувьд сэтгэл зүйн, бие физиологийн хэрэгцээг ханган таашаал авах нэгэн хэлбэр.

Гедонистууд дараах төрөлд хуваагдана:

- **Сексуаль:** Энэ төрлийн гэмт хэрэгт хосолмол хэлбэрийн хүчингийн хэрэг орно. Сексийн дур хүслээ хангахын тулд аллага үйлддэг, учир нь энгийн харилцаанаас таашаал авдаггүй тул. Энэ үед гэмт этгээд хүчирхийлэх үедээ, зовоон тарчлаах, эрүүдэн шүүх үеэс ташаал авдаг.
- **Дестроеры** /Англи хэлнээс to destroy- устгагч,сүйтгэгч/. Энэ төрлийн гэмт этгээдүүдийн гол зорилго нь хохирогч нарыг тамлан зовооход оршидог. Гэмт этгээд хохирогчтой бэлгийн харилцаанд ордоггүй ба хохирогчийг тамлан зовоох үйл явц болон хохирогчийн цуснаас, болж байгаа дүр төрх, үйл явдал, дуу чимээнээс ташаал авдаг.
- **Меркантильные:** Хувийн ашиг сонирхол, материаллаг эд зүйл авхын төлөө оршино. Энэ төрлийн гэмт этгээдүүдэд эмэгтэй хүмүүс их багтдаг. Гэмт этгээдүүд хүчирхийлэл үйлддэггүй ба үхэлд хүргэх хор, төрөл бүрийн хүчтэй эм бэдлмэл ашигладаг.
- **Властолюбцы:** Гэмт этгээд хохирогчийг өөрийн өмч, түүний үгийг үг дуугүй биелүүлдэг боолоо болгохыг хичээдэг. Хохирогчийг эрх мэдэлдээ байлгаж байна гэдэг бодол, дүр төрх, үйлдэл нь түүнд таашаал авчирдаг. Энэ төрлийн гэмт этгээдүүд бага насандаа хүчирхийлэлд өртсөн байдаг ба нас биеэнд хүрсэн үед ч өөрийгөө нийгэмд хүчгүй сул дорой гэж мэдэрдэг байна.
- **Визионеры:** Энэ төрлийн гэмт этгээдүүдийн талаар тайлбарлахад их хүнд: Учир нь тэд нар ад чөтгөр, бурханы зарлигаар хүн алсан гэж мэдүүлдэг. Тэдэнд “чи” хэн нэгний алах хэрэгтэй гэсэн дуу хоолой тушаадаг гэж тайлбарладаг. Ихэнх гэмт этгээдүүд сэтгэцийн өвчтэй байдаг. Гэхдээ ад чөтгөрийг тахин шүтдэг бүлэг гишүүдийн талаар санах хэрэгтэй. Учир нь тэд хохирогчын амь насаар тахил өргөж өөрийн гэсэн алах дүр зураг, хэв маяг, уламжлалтай байдаг.
- **Миссионеры:** Нийгмийг муу муухай зүйлээс арилгаж, сайжруулах ёстой гэж өөрсдийгөө үздэг. Гэмт этгээдийн хохирогч нар нь / өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ижил хүйстэн, биеэ үнэлэгч нар/ байдаг. Сэтгэцийн хувьд эрүүл, хийсэн хэргээ хүлээх чадвартай гэж сэтгэцийн эмгэгээр тогтоогддог.

Цуврал алуурчдыг олж илрүүлэхэд ямар хүндрэл бэрхшээл тулгардаг вэ?

Гэсэн асуултад Холбооны мөрдөх товчооноос /FBI/ (*лат-modus operandi*)- (*маска нормальности*)- (*хэвийн баг*) гэж хариулдаг. Энэ нь криминологид гэмт хэрэгтэн бие хүний сэтгэл зүйг судалж илрүүлэн барихад чиглэгдсэн арга. Харин энгийн, өдөр тутмын амьдралын хэрэгэлэнд бие хүний өдөр тутмын хийж заншсан

үйлдлийг нэрлэдэг байна. Иймд нийгмээс ялгаран гарахгүйн тулд баг зүүж, зохиомол биений хэлэмж, үйлдэл, үг хэл яриа ашигладан бидний дунд уусдаг гэсэн үг. Иймд бид гэмт хэрэгтэн бие хүнийг хуулийг чандлан сахигч иргэнээс ялган илрүүлж харж чаддаггүй байна.

“Modus oprendi”- “Хэвийн багтай”- алуурчдын амьдрал ахуйн байдлаар нь 3 ангилна:

1. Жүжиглэх чадвар дээд зэргийн гэмт этгээдүүд: Хоёр давхар амьдралаар хэнд ч мэдэгдэлгүй амьдрах чадвартай. Өөрийнхөө хэл яриа, биений хэлэмжийг маш сайн хянадаг. Маш сайн эцэг, хань, дотны найз, хүү, охин, ажилтан байдаг.
2. Жүжиглэх чадвар дунд: Өөрийгөө хянах чадвартай, гэхдээ үе үе нөхцөл байдлаас шалтгаалан хяналтаа алдаж хүрээлэн буй хүмүүс зарим нэг сонин, гаж байдлыг нь анзаардаг. Гэхдээ энэ үйлдлийг нь ажлын ачаалал, стресс, гэр бүлийн маргаан, амьдралын хүндрэлтэй байдалтай холбон тайлбарладаг. Энэхүү төрлийн гэмт этгээдүүд 60-70 хувьд гэр бүлтэй, гэхдээ байнгын хэрүүл тэмцэлтэй байдаг ба эхнэр нөхрийн аль нэг нь гэр бүлийн дотоод харилцаанд илүү эрх мэдэлтэй нэгэн байдаг.
3. Жүжиглэх чадвар муу: Өөрийгөө хянах чадвар маш муу, байнга өөрийгөө хянах чадвараа алддаг. Хүрээлэн буй хүмүүс тэднийг гаж, сэтгэцтэй, эрүүл бус гэж хүлээн авдаг. Ихэнх тохиодолд ажилгүй, гэр бүлгүй, ганцаараа, эсвэл эцэг эхийндээ амьдардаг.

Гэмт хэрэгтэй тэмцэж байгаа алба хаагч бүр жинхэнэ “Профайлер”-/дүр, төрх/ судлаач хүн байх ёстойг 21 зууны гэмт явдал судлаачид үзэж байна. “Профайлер” гэмт хэрэгтэн барих арга барил анх 1970 онд АНУ үүссэн. FBI-гийнхан цуврал алуурчидын сэтгэл зүйг нэг бүрчлэн судалж, тэдний дүр зургыг гаргаж эхэлсэн ба үүнээс улбаатай профайлер гэсэн хэллэг, мэргэжил үүссэн байдаг. Олон жилийн судалгааны үндсэн дээр профайлер алба хаагч нарыг ашиглан АНУ-д 1979 онд анхны цуврал алуурчинг барисан байна. Профайлер мэргэжилтэнүүд гэмт хэргийн газраас ирсэн зураг, шинжээчийн дүгнэлт, нэмэлт мэдээлэлтэй маш сайн ажилласаны үндсэн дээр нийт хэргийн 67 хувийг илрүүдэг тухай үзүүлэлт гаргасан.

Профайлер алба хаагчийн гол шинж: Гэмт хэрэгтэний зан араншинг тодорхойлж, хувийн зохион байгуулалт, биений хэлэмж, нас, хүйс, итгэл үнэмшил, шашин шүтлэг, гэр бүлийн байдал, ажил эрхлэлт, дотно харилцаа, дадал зуршил, хобби, сонирхол, бүр гадаад стиль имидж, хохирогчтой ямар нэг хамааралтай байсан эсэх, дараагийн хийх үйлдэл, аллаганы дүр зургийг гаргаж өгдөг байна.

Сэтгэл судлалын доктор Мики Писториус /Micki Pistorius/ /FBI-Холбооны мөрдөх товчооны удирдлагын их сургуулийг Профайлер мэргэжлээр төгссөн байна. Тэрээр гэмт хэрэг шалгаж байгаа алба хаагчдын нэг дутагдалтай тал ажиглагддаг гэж дүгнэсэн. Тэд гэмт хэргийн материалтай танилцахад хангалттай гэж үздэг. Гэтэл гэмт этгээдийн хэрэг үйлдсэн газар хичнээн их нуугдмал мэдээлэл байдгийг анзаардаггүй.

Тэрээр элсэн чихэрийн тариалангийн талбайд эмэгтэйчүүдийг алж байсан цуврал алуурчин “Фениксийн хэрэг” дээр ажиллаж, хэргийг амжилттай илрүүлсэн байна. Би гэмт хэрэг гарсан Өмнөд африкийн элсэн чихрийн тариалангийн газар ирсэн. Би тариалангийн дундуур явж эхэлхэд, энд тэндгүй

могой, олон төрлийн шавьжаар дүүрэн байсан ба энэ байдал надад айдас, тухгүй мэдрэмж төрүүлж байсан. Харин гэмт этгээдэд эсэргээрэй, алагдсан хохирогчийн хажууд 15 ширхэг тамхи татаж өөрийгөө аюулгүй, тухтай байдалд байгааг мэдэрч байсан ба тухайн газрыг сайн мэддэг нэгэн байсаныг шууд илтгэсэн. Гэмт этгээд хохирогчийн өсгийтэй гутлыг нямбай гэгч цогцосны хажууд тэгш хэмтэй байрлуулсан байсан нь тэрээр их “ПЕРФЕКЦИОНИСТ”-буюу бүх зүйл төгс байх ёстой гэж үздэг хүмүүсийн нэг байсан тодорхой. Түүнийг баривчлан саатуулахад түүний гэр маш цэвэр, бүх зүйл нь эмх цэгцтэй байсан. Гадаад үзэмжиндээ их ач холбогдол өгдөг тул аллага болсон газрыг цэгцтэй байлгахыг хичээдэг байж. Тэрээр элсэн чихрийн талбай руу орохдоо өндөр өвсийг тэгш хэмтэйгээр огцолж орсон байсан нь түүнийг ойр орчмын тэр дундаа “Зулу” үндэстний хүн гэсэн таамаглал нь хүртэл мөн байсан. Гэмт этгээд хохирогч нарыг өөртөө итгүүлж сайн дурын үндсэн дээр элсэн чихрийн талбай руу авчирдаг байсан ба зарим тохиодолд хүн дамжин явахыг чимээгүй хүлээдэг байсан. Иймд гэмт хэрэгтэн бие хүний дүр төрх, сэтгэл зүй, зан араншинг тогтоох нь хэрэг илрүүлэхэд хамгийн чухал байдгийг нотолсоор байна.

Төгсгөлд: Германы гүн ухаантан, зохиолч Ф.Ницшегийн “Нөгөө талын сайн сайхан ба хорон муу” зохиолын номноос ишлэл хүргэмээр байна. “Мангаснуудтай байлдаж байгаа хүн өөрөө мангас болохоос болгоомжлох хэрэгтэй, харанхуй нүх рүү удаан харах юм бол нүх бас чамайг харах болно” гэжээ.

Ашигласан ном зүй:

1. Дуглас, Джон. Психологический портрет убийцы. Методики ФБР : [перевод с английского]/ Джон Дуглас, Марк Олшейкер. – Москва : Алгоритм, 2016. – 432 с. – (Человек преступный. Классика криминальной психологии).
2. Криминалистика. Учебник. Том II/ под общ. ред. А.И. Бастрыкина. – М. : Издательство «Экзамен», 2014. – 559, [1] с.
3. Антонян Ю.М. Криминология. Избранные лекции. — М.: «Логос», 2004. — 448 с.
4. Бертовский Л. В. Допрос: тактика и технология / Л.В. Бертовский. – М. : Издательство «Экзамен», 2015. – 303, [1] с.
5. Лавров Н. Н. Маньяки: охотники на людей / Н. Н. Лавров. – Ростов н/Д: Феникс, 2008. – 252, [2] с. – (Х-файлы).
6. Антонян, Ю. М. Криминология : учебник для бакалавров / Ю. М. Антонян. – 2-е изд., перераб. и доп. – М. : Издательство Юрайт, 2012. – 253 с. – Серия : Бакалавр. Базовый курс.
7. Теория оперативно-розыскной деятельности: Учебник. 3-е изд., перераб. и доп. / Под ред. К.К. Горяинова, В.С. Овчинского, Г.К. Синилова. – М.: ИНФРА-М, 2014. – VIII, 712 с. – (Высшее образование: Бакалавриат).
8. Чуфаровский Ю.В. Юридическая психология. Учебное пособие. — М.: Право и Закон, 1997. — 320 с

БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ**СУРАЛЦАГЧ ТӨВТЭЙ СУРГАЛТЫН
ТЕХНОЛОГИ****Д.Цэрэнлхам**ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн
эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн дэслэгч**Товч агуулга**

Боловсролын салбарын хувьд даяарчлагдаж буй дэлхий ертөнцөд гарч буй нийтлэг хандлага, ололтод тулгуурлан уламжлалт тогтолцоо, хандлагыг өөрчлөн шинэчлэх ажлуудыг эхлүүлээд байгаа билээ.

Энэхүү өгүүллээрээ би суралцагч “бие дааж бүтээлчээр сэтгэх”, “өөрийн хурдаар сурах”, “хэрэгтэй мэдлэг, чадварыг мэдээллийн олон эх үүсвэрээс эрж хайх”, “нээлттэй, ардчилсан байх”, “өөрийн хэрэгцээг илэрхийлэх” зэрэг олон бололцоог нээж өгдөг суралцагч төвтэй сургалтын ач холбогдлын талаар авч үзсэн болно.

Түлхүүр үг: Сургалтын технологи, сэдэлжүүлэлт, уламжлалт арга, шинэ загвар, хамтран зүтгэгч

Үндсэн хэсэг

Суралцагч төвтэй сургалт гэсэн ойлголтыг анх Францын нэрт соён гэгээрүүлэгч Жан Жак Руссо 1762 онд хэвлүүлсэн “Эмиль буюу хүмүүжлийн тухай” зохиолдоо хэрэглэсэн байдаг. Ш. Ичинхорлоо, Г.Долингор нар сургалтын энэ хэлбэрийг “Сурагч төвтэй сургалт бол хүүхдийн авъяас, чадавхи, хэрэгцээ, сонирхол, эрх, эрх чөлөө зэргийг эрхэмлэсэн, түүнд чөлөөтэй хөгжих боломжийг олгосон, тэр хэрэгтэй мэдлэг туршлагыг өөрөө амьдрал орчноос олж авдаг сургалтын нэг чиглэл юм” гэж тодорхойлсон байдаг.

Тэгвэл суралцагч төвтэй сургалтын технологи гэж юу вэ? Сургалтын онолын үүднээс авч үзвэл, сургалтын технологи нь зорилго, үйл явц, үр дүн гэсэн бүтэцтэй байх бөгөөд түүнийг сургалтын зорилгыг хамгийн бага хугацаанд өндөр үр дүнтэй хэрэгжүүлэх арга зүй гэж товчоор ойлгож болно. Европын орнуудад сургалтад дэвшигдсэн зорилт, түүнийг хэрэгжүүлэхэд баримтлах зүй тогтол, зарчим, зохион байгуулах хэлбэр, арга, хэрэглэлийг хэрэглэх дэс дарааллыг сургалтын технологи гэж томъёолдог ерөнхий хандлага байна.

Сургалтын технологи гэсэн ойлголт анх шинжлэх ухаан, техник, технологийн ололтыг сургалтад нэвтрүүлэхтэй уялдаж 1950-иад онд АНУ-ын сургалтын онол, практикт гарч ирсэн бөгөөд онолын үндэс нь бихеровизм юм.

Үүнийг үндэслэгчид нь Б. Скиннер, С. Пресс, Э. Торндайка нар юм. ОХУ-ын хувьд Н.Ф. Талызина, М.В. Беспалько, В.Я. Полиповский, П.У. Крейтсберг, З.И. Кальмыкова, Е.Н. Кабанова-Меллер, П.Я. Гальперин, В.М. Полонский нарын эрдэмтэн судлаачид сургалтын технологийн онол, арга зүйн асуудлуудыг судалжээ.

Дээрх эрдэмтэн судлаачид сургалтын онол, багшлах ур чадвар, техник зэрэг чиглэлүүдийг арга судлал, онол, заах аргын түвшинд судалсан байна.

Даяаршлын эрин үед сургалтыг орчин үеийн байдлаар зохион байгуулахын тулд: нэгдүгээрт, бие дааж сэтгэн бодох, хийж бүтээх чадавхтай иргэн төлөвлүүлэх нийгмийн хэрэгцээг, хоёрдугаарт, суралцагчдын эрэлт хэрэгцээ, сонирхол зэргийг хамтад нь хамтад нь харгалзан үзэж, хангах шаардлагатай юм.

Орчин үеийн сургалтын үндсэн зорилго бол:

1. Суралцагчдын хүсэж байгаа, тэдэнд хэрэгцээтэй байгаа суурь мэдлэгийг эзэмшүүлэх /олгох, өгөх бус/;
2. Суралцагчдад бие дааж суралцах арга барил, чадварыг эзэмшүүлэх;
3. Суралцагчдад бие хүний эрхэм зан чанаруудыг төлөвшүүлэх /бие дааж сэтгэн бодох, шийдвэр гаргах, хариуцлага хүлээх, шударга байх/

Сургалтын зорилготой холбоотой бидний гаргаж буй гол алдаа нь дээр гурван зорилгын эхний зорилгыг биелүүлээд хоёр, гурав дахь зорилгуудыг орхигдуулдаг явдал юм.

Иймээс багш нар арга зүйгээ шинэчлэе гэвэл суралцагчдад зөвхөн мэдлэг олгох явцуу зорилгод баригдалгүй, тэдэнд бие даан суралцах арга барил, дадал төлөвшүүлэх, тэднийг бие хүн болгон төлөвшүүлэх зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн өргөн хүрээний олон янзын аргыг хэрэглэх нь зайлшгүй юмаа.

Суралцагчийг татан оролцуулах хамгийн түгээмэл, нийтлэг арга бол суралцагчийн үзэл бодлыг илэрхийлэхэд оршино¹⁰³.

Суралцагч төвтэй багшийн үүрэг:

-  Суралцах нөхцөл байдлаар хангах, дэмжлэг үзүүлэх;
-  Суралцагчдаар олон талт асуудлыг шийдүүлэх;
-  Суралцах нөхцөлд эерэг нөлөө үзүүлэх

Ш.Ичинхорлоо суралцагч төвтэй хичээлийн технологи хэрэгжих үндсэн нөхцөл¹⁰⁴-ийг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

-  Багш суралцагчдад өөрийгөө өөрчлөх, хөгжүүлэх хэрэгцээ үүсгэх, ийм зүйл маш хэрэгтэйг ухааруулж ойлгуулах;
-  Суралцагч сурч танин мэдэх үйлдлүүдийг ухамсартай, дуртай хийж гүйцэтгэх;

¹⁰³ Елигбаева Гульжахан Жакпаровна “Студенто-ориентированное обучение: современные подходы и инструменты” Алматы., 2016 он.

¹⁰⁴ Ш.Ичинхорлоо “Сургалт” УБ., 2005 , 11 дэх тал

- ✚ Суралцагчдын амьдралын орчноос олж авсан мэдлэг туршлагад тулгуурлах;
 - ✚ Тэдний хэрэгцээ сонирхолд тулгуурлах;
 - ✚ Суралцагчдын сурч танин мэдэх үйл ажиллагаанд тулгуурлах гэх мэт
- Харин Д. Ванчигсүрэн “Бидний судалгаа, ажиглалт туршилтаас үзвэл шавь төвтэй сургалтыг явуулах үржил шимт хөрс нь:
- ✚ Суралцагсдын бие даан ажиллах чадвар;
 - ✚ Суралцагсад хоорондын болон багш суралцагсдын харилцан сургах хамтын ажиллагаа юм” гэж тодорхойлсон байна.

Багшийн шинэ загвар¹⁰⁵: Сургалтыг суралцагч төвтэй явуулахтай холбоотойгоор багш “өөрөө бага ярьж, сурагчдаар ихийг хийж бүтээлгэх”, “суралцагчдад бие дааж суралцах арга барил эзэмшүүлэх”, “суралцагч болоод нийгмийн хэрэгцээг судалсны үндсэн дээр хичээлээ бэлдэж, явуулах”, “суралцагчдыг сэдэлжүүлэх, тэднээр эрэл хайгуул хийлгэх, багаар ажиллуулах”, “суралцагчдаар мэдлэг бүтээлгэх”, “өөрсдөөр нь мэдлэг, чадварыг нь хянуулж, үнэлүүлэх”, “суралцагчдад амжилттай суралцах таатай нөхцлийг бүрдүүлж, суралцагчдын хамтран зүтгэгч байх” гээд олон, олон зүйлд шинээр суралцаж, уламжлалт хандлагаа өөрчлөхийг цаг үе шаардаж байна.

“Уламжлалт сургалтад багшийн гол үүрэг суралцагчдад шинжлэх ухааны их мэдлэг олгох, түүнийгээ хянан шалгах явдал байсан бол орчин үед суралцагч төвтэй сургалтын үзэл санаа дэлгэрч улмаар багшийн үүрэг суралцагчид өөртөө хэрэгтэй мэдээлэл, арга туршлага өөрөө олж авахад нь туслан зөвлөх, тэдэнтэй хамтран ажиллах, тэдний сурах үйлийг чиглүүлэх явдал болж өөрчлөгдсөн¹⁰⁶. Үнэхээр орчин үед сурагч мэдлэгийг зөвхөн багшаас олж авдаг уламжлалт хандлага хуучирч, тэд мэдээллийн олон төрлийн эх үүсвэрээс өөрсдөө бие даан суралцах явдал чухал боллоо. Ийм нөхцөлд багш би бүхнийг мэднэ, бусдад бүхнийг заана гэсэн хоцрогдсон сэтгэлгээнээсээ салж, харин үүний оронд өсвөр залуу үеийнхэнд хэрэгтэй мэдлэг, чадвар, туршлага олж авахад нь туслагч, сургалтын үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулагч, чиглүүлэгч болон өөрчлөгдөх хэрэгтэй болж байна.

Уламжлалт сургалтаар яваа багш	Багшийн шинэ загвар
✓ Суралцагчаа байнга чирч явдаг;	✓ Багш, суралцагч дасан зохицон тасралтгүй хөгжигч;
✓ Мэдлэгтэй багш;	✓ Чадамжтай багш;
✓ Багш ихийг зааж сургадаг;	✓ Багш, сурагчид хамтран сурах;
✓ Элсэлт-албадмал, нэг төрлийн;	✓ Элсэлт-сонирхлоороо, олон сонголттой;
✓ Мэдлэг дамжуулдаг технологи давамгайлдаг;	✓ Мэдлэг бүтээх технологи давамгайлдаг;
✓ Нэг талын, онолд тулгуурласан боловсрол олгодог.	✓ Олон талт боловсрол олгодог;

¹⁰⁵http://bataabaatar.blogspot.com/2015/01/blog-post_99.html

¹⁰⁶Ш.Ичинхорлоо “Багшийн ном” УБ., 2005, 19 дэх тал

✓ Прагматик боловсрол.

“Суралцагч” төвтэй үнэлгээний систем: Дэлхий нийтээрээ “хүн” төвт хөгжлийн үндсийг боловсрол, эрдэм мэдлэг гэж тодорхойлох болсон өнөөгийн нөхцөлд монгол орны боловсролын тогтолцоог өөрчлөх, түүнд нийгмийн болон хувь хүний хэрэгцээ, шаардлага, үндэсний онцлог зэргийг харгалзан үзэх шаардлагатай байгаа билээ. Олон улсын их сургуулиудын жишгээс харахад “Мэдлэг бол хүч” гэж тодорхойлсон ба энэ нь хүний оюуны хэрэгцээг өдөөж, сэтгэхүйг нь төлөвшүүлэх гол хэрэгсэл бөгөөд түүнийг тодорхойлох гол элемент нь үнэлгээ юм.

Мэдлэг олгох сургалтын үйл ажиллагааны явц дахь үнэлгээг “багш” төвтэй, “оюутан” төвтэй гэж ангилах бөгөөд тэдгээрийн үнэлгээг дараах байдлаар харьцуулсан байна.

“Багш” төвтэй үнэлгээ:	“Суралцагч” төвтэй үнэлгээ:
✓ Заах арга болон үнэлж дүгнэхийг тус тусад нь ялгаж салган үнэлдэг байна ✓ Үнэлгээ бол сургалтын явцыг хянах хэрэгсэл юм ✓ Зөв хариулт бол үнэлгээний гол түлхүүр байна ✓ Оюутан өөрийн чадлаар бусад эх сурвалжаас олж авсан мэдлэгийг үнэлдэггүй харин багш өөрийн бэлдсэн тест материалаар оюутны мэдлэгийг үнэлдэг ✓ Бие даан идэвхтэй суралцах болон багаар хэрхэн ажиллаж байгааг үнэлдэггүй байна ✓ Зөвхөн оюутан суралцах ёстой бөгөөд багшийн ярьснаар үнэлнэ.	✓ Заах арга зүйг үнэлгээтэй холбож уялдуулан үнэлдэг байна. ✓ Үнэлгээ бол сургалтын явцыг идэвхжүүлэх зөв гаргалгаа бий болгодог хэрэгсэл юм ✓ Оюутныг цааш хөгжүүлэн алдаанаас сурах боломжийг үнэлгээ бий болгоно ✓ Оюутан мэргэжлийн сэтгүүл, өгүүллэг, төсөл зэрэг бусад эх сурвалжаас өөрийн хүсэл, чадлаар олж авсан мэдлэгийг багшийн заасантай харьцуулж дүгнэхийг үнэлнэ. ✓ Хамтран багаар ажиллах, бусдаа сонсох дэмжих, бие даан ажиллах зэрэгт үнэлгээ өгнө ✓ Багш, оюутан хамтран суралцах ба багш бүгдийг мэдэх албагүй байна.

Дүгнэлт:

Уламжлалт сургалтын тогтолцооноос Суралцагч төвтэй сургалтын тогтолцоонд шилжих үйл явц нь сургалтыг явуулж буй багш түүнийг хэрхэн ойлгож ухаарсан, түүнд нийцүүлэн өөрийн үзэл бодол, хандлага, заах арга зүйгээ өөрчилж чадаж байгаа эсэхээс шууд хамаарч байна.

Сургалтын хүссэн үр дүнд оюутнуудыг хүргэхийн тулд багшийн хийх ёстой зүйл бол сургалтын үйл ажиллагаанд суралцагчийг татан оролцуулах явдал юм.

Их сургуулиудын боловсролын өөрчлөлт, шинэчлэлийг харахад “суралцагч” төвтэй үнэлгээгээр үнэлдэг болсон байна.

Өнөөгийн байдлаар манай улс боловсролын шинэчлэл хийх ажлуудыг шат дараатай хийж байгаа бөгөөд сургалтын явцад суралцагчийн эзэмшсэн мэдлэгийг “суралцагч” төвтэй үнэлгээгээр үнэлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага гарч ирж байна. Ингэснээр сургалтын үйл ажиллагааны явц дахь суралцагчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг бүрэн тодорхойлж тэдгээрийн мэдлэгийг хэмжигдэхүйц байхаар үнэлэх юм.

Суралцагчийн оролцоо /суралцагч төвтэй сургалт/ нь зөвхөн шинэ хандлагад төдийгүй боловсрол олгох хөтөлбөрт ач холбогдол өгөх үр дүнтэй хүчин зүйл юм.

Санал

- Багш бид бусдад бүхнийг заах гэдэг, өөрийгөө төгс гэж боддог хуучинсаг ойлголтоосоо салж, сургалт ба суралцагчийг цоо шинэ өнцөгөөс харж, ӨӨРИЙГӨӨ шинэ хүн болгон өөрчлөхөөс ажлаа эхлэх ёстой гэж үзэн дараах саналуудыг дэвшүүлж байна.
- Суралцагч бүр бие сэтгэл, оюун ухааны хувьд адилгүй байдаг бөгөөд бүх зүйл дээр адилхан амжилт гаргадаггүй. Тиймээс бусдаас хоцроод байгаа суралцагчид тусгайлан даалгавар өгдөг байх;
- БОД (think)---ХОСЛО (pair up)---ХУВААЛЦ (share) зарчмыг илүү баримтлах;
- Суралцагч бусад эх сурвалжаас өөрийн хүсэл, чадлаар олж авсан мэдлэгийг багшийн заасантай харьцуулж дүгнэхийг, хамтран багаар ажиллах, бусдыгаа сонсох дэмжих, бие даан ажиллах зэрэгт оч холбогдол өгч үнэлдэг байх.